

MONGOLIAN ECONOMY

2015 оны 10 сар. № 19 (098)

www.mongolianeconomy.mn

АЖ ҮЙЛДВЭР


iPhone шиг автобус

Өрсөлдөж чадвал хөрөнгөтэй

Худалдааг хуульчлахын учир



Монголд үйлдвэрлэв



Дэлхийн эдийн засгийн замын зураг
бүтэн жилийн турш тантай хамт

Дэлхий 2016

Дэлхий нийтийн ирээдүйн таамаг

The Economist Таны ирэх
жилийн хөтөч

The Economist сэтгүүлийн
“THE WORLD IN 2016” жилийн
дугаарыг Монгол дахь албан ёсны тусгай
зөвшөөрөл эзэмшигч **“Mongolian Economy”**
сэтгүүл монгол хэлээр эрхлэн гаргах гэж
байна.

2016.01 сард танд хүрнэ



Утас 94092904, 94092905, 70115476, 70115477

www.marketing@mongolianeconomy.mn

www.info@mongolianeconomy.mn

MONGOLIAN
ECONOMY



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.БЭХБАЯР / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.ҮҮРИЙНТУЯА

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.ТҮВШИН

ОРЧУУЛАГЧ:

Б.ЭНХМӨНХ

ВЭБ РЕДАКТОР:

Б.ЭНХЦЭЦЭГ

СЭТГҮҮЛЧИД:

Э.ЗОРИГ

Г.ОРХОН

Ц.ЭЛБЭГСАЙХАН

ДИЗАЙНЕР:

Б.СЭР-ОД

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904/

Э.ЗОРИГ /9409 2905/

ХАЯГ

УЛААНБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ.

1 ХОРОО, ЭНХТАЙВНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ.

ЭКСПРЕСС ТАУЭР. 1101 ТООТ

15160 УЛААНБААТАР, ТӨВ ШУУДАН,

Ш/ Х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

“ИНТЕР НОМ”

“ЦЭЦЭГ ТӨВ”

“МИНЖ ПЛАЗА”

“АЛТАНТҮЛХҮҮР” НОМЫН ДЭЛГҮҮР

“НОМИН” СУПЕРМАРКЕТИЙН БҮХ САЛБАР

“МАКС” СУПЕРМАРКЕТИЙН БҮХ САЛБАР

“ФРЕСКО” СУПЕРМАРКЕТ

BTSI СУПЕРМАРКЕТ

“АЗ ОРЧЛОН” НОМЫН ДЭЛГҮҮР

“БИЛЭГ” ИХ ДЭЛГҮҮРИЙН НОМЫН ТАСАГ

“ГРАНД ПЛАЗА” ДАХЬ СУПЕРМАРКЕТ

“МИР” НОМЫН ДЭЛГҮҮРИЙН

“GRAND PLAZA”

“METRO MALL”

“SKY” СУПЕРМАРКЕТ

“УЛААНБААТАР” ИХ ДЭЛГҮҮР

“МАХ МАЛЛ” ДЭХ САЛБАРУУД

Зурвас

Монгол Улс ирээдүйн хурдацтай хөгжлийн чиглэлээ тодорхойллоо. Энэ бол боловсруулах салбар. Аж үйлдвэрийн яамыг байгуулж, салбарыг хөгжүүлэх бодлого, стратегийг төрөөс батлан гаргалаа. Үйлдвэржилтийг хөгжүүлэх, эрчимжүүлэх их ажлын эхлэлийг тавьж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох төслүүдийг дэмжин ажиллах боллоо. Зэс, төмөр, газрын тосны томоохон үйлдвэрүүд байгуулж, түншлэгч орнуудтай хамтран ажиллахаа илэрхийлээд байна. Мөн ямар салбарын аль төслийг гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тухайгаа олон улсад ил тод зарлалаа.

Энэ мэтчилэн бодлого, төсөл, хөтөлбөрийнхөө тухай гадаад, дотоодын хөрөнгө оруулагч болоод үйлдвэрлэгчдэд тодорхой ойлголт өгөх зорилготой “Монголд үйлдвэрлэв” аж үйлдвэрийн анхны чуулганыг зохион байгуулж байна.

Хүн бүр сайхан амьдрахыг хүсдэгчлэн Монгол Улсын зорилго ч мөн иргэд нь амгалан тайван, нийгэм нь бухимдалгүй, ирээдүй нь гэрэлтэй, боловсон хүчин нь боловсролтой, хөгжингүй орон болох. Түүнд хүрэх хөгжлийн гарц нь аж үйлдвэрийг хөгжүүлэх гэдгийг мэргэжилтэн, судлаачид хэлж байна.

Тиймээс ч манай сэтгүүл Тус форумд зориулсан тусгай дугаарыг Аж үйлдвэрийн яамтай хамтран хийлээ. Төрөөс энэ салбарт ямархуу бодлого, журам, дүрэм гаргасан, хэрхэн хэрэгжүүлэх, хүнд, хөнгөн үйлдвэрүүдийн төсөл, хөтөлбөр, Концессоор ямар төслүүд хэрэгжүүлэх зэрэг салбарын асуудалтай холбоотой нийтлэлүүдийг энэ дугаарт орууллаа.

Олон улсын туршлагаар төрөөс нь аж үйлдвэрийн салбартаа нэлээд анхаарал тавьж хөгжүүлснээр дагаад жижиг, дунд үйлдвэрүүдээ хөгжүүлж, улмаар улс орноо өндөр хөгжилд хүргэсэн тухай олонтаа сонсож, харж, уншиж байлаа. Олон ч туршлага судалсан, холбогдох албаны хүмүүс. Одоо ажил хэрэг болгохоор зорьж, эхний том алхмуудаа хийж, урагш харан явж байгааг “Mongolian Economy” сэтгүүл дэмжиж, энэхүү дугаарыг уншигч таны гарт хүргэж байна. Цаашид Аж үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, төслийн тухай бодитой мэдээллийг байнга хүргэж байх болно.

“Mongolian Economy” сэтгүүлийн редакци

ЗАХИАЛГЫН ҮНЭ:

НЭГ ДУГААР	15,000₮
УЛИРАЛ /6 ДУГААР/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 ДУГААР/	180,000₮
ЖИЛ /24 ДУГААР/	360,000₮

БОРЛУУЛАЛТЫН ҮНЭ:

18,000₮



Аж үйлдвэр

- 10 БАЯЛГИЙГ АРВИЖУУЛЖ БАЯЖДАГ
- 11 IPHONE ШИГ АВТОБУС
- 14 Д.ЭРДЭНЭБАТ: МОНГОЛ УЛС УУЛ УУРХАЙГААС БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ РУУ ШИЛЖИХЭЭ ОЛОН УЛСАД ЗАРЛАЛАА
- 21 НАРАН МАНДАХ ЗҮГЭЭС
- 22 ӨРСӨЛДӨЖ ЧАДВАЛ ХӨРӨНГӨТЭЙ
- 24 З.ЭРДЭНЭБАТ: САЙН ЧАНАРЫН БУДАГ ЭХ ОРОНDOO ҮЙЛДВЭРЛЭХИЙГ ЗОРЬСОН
- 27 ХӨГЖЛИЙН ХӨДӨЛГҮҮРИЙН ТУХАЙД ЦУХАСХАН
- 28 МӨРӨӨДЛИЙН ЧИМЭЭ
- 30 МОНГОЛЫН ОРГАНИК НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЭКСПОРТЛОНО
- 33 Д.БАТТОГТОХ: СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН АЖ ҮЙЛДВЭРИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ, ЗУРАГЛАЛЫГ ГАРГАСАН
- 36 ҮЙЛДВЭРЛЭЛД ТУЛГУУРЛАСАН ХӨГЖЛИЙГ ТҮГЭЭГЧИД
- 38 “АЖ ҮЙЛДВЭР” ТЭДНИЙ НҮДЭЭР
- 42 ЧУХАЛ НЬ ЭКСПОРТ
- 43 ИЙМ НЭГЭН “ГОВЬ”
- 45 ХӨГЖЛИЙН ХӨГ
- 48 ҮЙЛДВЭРЛЭГЧИД ЯРЬЖ БАЙНА
- 50 ХУДАЛДААГ ХУУЛЬЧЛАХЫН УЧИР



Зах зээлийн сургаар навс унасан нэг салбар бол яах аргагүй аж үйлдвэрийн салбар. Ийнхүү зоримог хэлж байгаагийн учир нь хэвийн ажиллаж байсан үйлдвэрүүдийг хувьчилж, ажилчид нь

24-р хуудас



Маргаан дагуулсан “Экобус” авто угсралтын үйлдвэр тун цэвэрхэн аж. Будаг нь хангалсан 20 ширхэг J-800T автобусыг хэдхэн хоногийн өмнө нийслэлийнхэнд гардуулсан энэ үйлдвэрт чимээ анир бараг алга.

11-р хуудас



Цагаан будаа, чихрийн ургамлаас өөр орлогын эх үүсвэргүй байсан нэгэн улс өнөөдөр Азийн бар болтлоо хөгжиж чаджээ. Энэ бол Тайвань.

28-р хуудас

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



**ХУВИЙН
БАНК**

ОНЦГОЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Зөвхөн танд зориулав



☎ 70111646 /1100, 1101, 1106/

✉ premierbanking@golomtbank.com

G O Y O

FALL/WINTER 2015-16



Монгол экспорт



Боловсруулах чиглэлийн 94 аж ахуй нэгж өнгөрсөн онд 212 сая ам.долларын экспорт хийжээ. Монгол Улс одоогийн байдлаар аж үйлдвэрийн өрсөлдөх чадвараар 133 орноос 109 дүгээрт жагсч байна. Мөн үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүний хэмжээ салбарын нийт экспортын ердөө 5.6 хувийг эзэлж байгаа юм. Гэтэл ОХУ-д 28 хувь байгаа бол бидний урд хөршийн аж үйлдвэрийн салбарын нийт экспортын 40 хувийг үнэ цэнэ, технологи шингэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Бидэнтэй хамгийн ижил төстэй гэгддэг Казахстан улсын экспортод гаргаж байгаа бараа, бүтээгдэхүүний 6.8 хувь нь технологийн агууламж бүхий үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн байгаа нь биднээс давуу үзүүлэлт юм.

Өнөөдрийн байдлаар манай улсад боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл эрхэлдэг 94 аж ахуй нэгж бий. Нийт 94 аж ахуй нэгж өнгөрсөн 2014 оны байдлаар 212 сая ам.долларын экспорт хийжээ. Энэ нь нийт экспортын 3.6 хувийг эзэлж байгаа тоон үзүүлэлт юм. Тэр дундаа ноолуур, оёмол бүтээгдэхүүн, арьс, ширний салбарынхан дунд буюу нам технологийн боловсруулалт хийж, түүнийгээ экспортод гаргаж байна. Өөрөөр хэлбэл, бидний хагас болон бүрэн боловсруулан экспортолж буй нэг ширхэг үхрийн ширээр 4-5 ширхэг гутал үйлдвэрлэх боломжтой. Үүнийг л бид үнэ цэнэ шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хэмээж буй.

Нефть



Хүнд үйлдвэрийн чиглэлээр нефть боловсруулах, зэс хайлуулах цэвэршүүлэх, хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах зорилт тавин ажиллаж байна. Говийн бүсэд нефть боловсруулах үйлдвэр байгуулах ажил эхэлсэн бөгөөд урдчилсан ТЭЗҮ-г боловсруулах компанийг сонгон шалгаруулсан. Мөн зүүн бүсэд 300 мянга хүртэлх тоннын хүчин чадалтай нефть боловсруулах үйлдвэр барих компанийн сонгон шалгаруулалт дууссан. Сонгон шалгаруулалтад 14 компани оролцож, саналаа ирүүлсэн байна. Энэ онд багтаж хийх нефть боловсруулах үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ, сонгон шалгаруулалтыг дуусгаад ирэх жил хөрөнгө оруулагчдын сонгон шалгаруулалтыг эхлүүлэх боломж бүрдээд байна. Зэс хайлуулж, цэвэршүүлэх үйлдвэрийн тухайд он гармагц хөрөнгө оруулагчийг шалгаруулж, ирэх хавраас ажлыг эхлэхээр байгаа аж.

Монгол даавуу



Дотоодын үйлдвэрүүд 1.5 сая ширхэг адууны арьс, шир боловсруулах хүчин чадалтай бөгөөд жилд 250 мянган арьс, шир бэлтгэдэг байна. Өөрөөр хэлбэл, адууны арьс, ширийг дотооддоо бүрэн боловсруулах хүчин чадалтай. Тиймээс адууны арьс, ширийг түүхийгээр нь гаргахыг хориглосон бөгөөд хэрэв 160 мянган арьс, шир хадгалж байгаа хүмүүс байгаа бол дотоодынхоо үйлдвэрүүдэд өгч боловсруулахыг аж үйлдвэрийн сайд сануулжээ. Түүнчлэн сурагчийн дүрэмт хувцасны даавууг ирэх онд дотоодын үйлдвэрүүд бүрэн хангах боломж бүрдсэн байна. Өөрөөр хэлбэл, ирэх хичээлийн жилээс монгол даавуугаар дотооддоо үйлдвэрлэсэн дүрэмт хувцсыг сурагчид өмсөх нь.

Төсөл хөтөлбөр

Экспорт, импортыг дэмжих 300 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэрийг Засгийн газар гаргасан. Өнөөдрийн байдлаар нийт 110 төсөл ирүүлснээс 31 төсөл эхний ээлжинд санхүүжигдэхээр бэлэн болжээ. Ирүүлсэн төслүүдийн дийлэнх нь боловсруулах үйлдвэртэй холбоотой. Нийт оруулж байгаа хөрөнгө оруулалт нь тухайн төсөл хэрэгжүүлэгч үйлдвэр өөрийнхөө хөрөнгөөр 22.7 хувийг, гадаадын хөрөнгө оруулалтаар 53.8 хувийг, экспортыг, импортын зээлийн хүрээнд Хөгжлийн банкны зээлээр 23.5 хувийг санхүүжүүлэх аж. Өөрөөр хэлбэл, Монголоос гарч байгаа нэг төгрөг тутмын эсрэг хоёр ам.доллар орж ирэх төслүүд байгаа аж. Мөн төгрөгөө валют болгоод тоног төхөөрөмж худалдан авахгүй байх эерэг боломжийг үүсгэж байгаагаараа энэ төслийн инфляцийг өдөөх эрсдэл бага аж.

Хөнгөлөлттэй зээлээс бодлогын зээл рүү



Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулж 70 тэрбумын төсөл хэрэгжүүлэхээр Засгийн газраас батласан. Нийт 588 төсөл дэмжигдсэн. Хуучин шалгарсан төслийн 20-30 хувь нь банкинд тэнцдэг байсан бол энэ жилийн төслийн 50 хувь банкны шалгаруулалтыг дааж гарчээ. Үүнээс зээл авах боломжгүй 256, санхүүжилт хийсэн 152 төсөл байна.

Мөн ноолуурын экспортын бараа бүтээгдэхүүнийг дэмжихэд зориулж 150 тэрбум төгрөгийн төслийг санхүүжүүлсэн. Өнөөдрийн байдлаар 25 экспортын компани дэмжигдсэн. Үүнээс 14 төсөл батлагдаж, 70.1 тэрбумын зээл авчээ. Үр дүн нь ирэх оны нэгдүгээр сард нэгтгэгдэж гарах аж. Энэ 25 компани экспортын хувь хэмжээгээ нэмэгдүүлсэн бол зээл үргэлжлээд олгогдоод сунгагдана. Эспортын төвшингөө нэмэгдүүлээгүй бол цаашдаа зээл авах эрх нь хаагдах юм. 2016 оноос Аж үйлдвэрийн яам хөнгөлөлттэй зээлийг бодлогын зээл рүү шилжүүлэхээр төлөвлөжээ.

ДЭЛХИЙД

Хөгжиж буй зах зээлийн аж ахуйн нэгжийн өр



Олон улсын валютын сангийн Дэлхийн санхүүгийн тогтвортой байдлын тайланд хөгжиж буй зах зээл дэх компаниудын ам.долларын өр нэмэгдсэнийг дурьджээ. Энэ нь валютын ханшны эрсдэл учруулж болзошгүй бөгөөд энэ эрсдэлийг тайлбарлавал дотоод валютын ханш суларч ам.доллар эсвэл өөр гадаад валютаар төлөгдөх өр зээлийг төлөхөд хүндрэлтэй болох юм. Энэхүү эрсдэлээс своп зэрэг санхүүгийн эрсдэлийг даатгуулах аргаар хамгаалах боломжтой ч хөгжиж буй эдийн засагтай орнуудад дериватив буюу санхүүгийн үүсмэл зах зээл сайн хөгжөөгүй байдаг аж.

АНУ-ын төвбанк ойрын хугацаанд бодлогын хүүгээ нэмэх өндөр магадлалтай. Ингэснээр ам.долларын ханш улам чангарч бусад валютын ханш харьцангуй сулрах юм. Ханшийн өөрчлөлт салбар тус бүрт өөрөөр нөлөөлдөг. Уул уурхай зэрэг экспортод жичлэсэн салбарт дотоодын валютын ханш сул байх тусам ашигтай байгаа бол үл хөдлөх хөрөнгө болон барилгын салбар зэрэг импорт давамгайлсан салбарт эсрэгээрээ нөлөөлдөг аж. Энэхүү судалгаанаас үзэхэд АНУ-ын Төвбанк мөнгөний бодлогоо хэвийн хэмжээнд хүргэх хэрээр ам.долларын ханш өсөх тул хөгжиж буй зах зээлүүд урьдчилан бэлтгэх хэрэгтэй аж.

Японы үйлдвэрлэл

Япон улсын Төвбанк Японы бизнесийн нөхцөл байдлыг судалдаг “Танкан” судалгааны гуравдугаар улирлын тайланг гаргажээ. “Танкан” судалгааны индекс нэмэх 12 оноотой гарч зургаадугаар сарын 15-наас буурсан байна. Үйлдвэрийн бүтээгдэхүүний гарц өнгөрсөн наймдугаар сард долоодугаар сарын үзүүлэлтээс 0.5 хувь буурсан нь тус улсын бизнесийн нөхцөл байдал улам

дордож байгааг илтгэж байна. ДНБ-ий өсөлт хоёр дахь улиралдаа дараалан сөрөг үзүүлэлттэй гарах тохиолдолд Япон улсыг эдийн засгийн хямралтай орнуудын эгнээнд шилжсэнд тооцож болох юм. БНХАУ-ын эдийн засгийн удаашрал үүнд ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь Азийн бусад оронд ч хүнд тусаж байгаа аж. Үйлдвэрлэлийн бус салбаруудын бизнесийн итгэл нэмэх 25 болж өмнөх улирлаас хоёр оноогоор нэмэгдсэн байна. Судалааны үр дүнд зарим салбар дордож байхад



зарим нь сэргэх үзүүлэлттэй байсан ч Японы Төвбанк мөнгөний тэлэх бодлого баримтлах бололтой. БНХАУ, Европын холбоо болон АНУ-ын үйлдвэрлэлийн салбар мөн уналттай байгаа юм.

Хятадын хэрэглээ



Энэ оны хоёрдугаар улиралд БНХАУ-ын цалингийн хэмжээ долоон хувиар өссөн бол гадаад ажилчдын хөлс 10 хувиар өссөн байна. Энэ жил жижиглэнгийн худалдаа 10.5 хувиар өсч, 6-7 хувьтай гарна гэж таамаглаж буй ДНБ-ий өсөлтийг давсан байна. Гадагш аялж буй жуулчдын зарцуулсан мөнгөний нийт дүнгээрээ БНХАУ-ын жуулчид дэлхийд тэргүүлж байгаа юм. Өргөн хэрэглээний барааны нэмэгдсээр буй эрэлт, түүхий эдийн буурч буй эрэлт нь экспортод чиглэсэн орнууд эдийн засаг хүндрэлтэй тулгарсаар байхыг илтгэж байна.

Монгол Улс тэргүүтэй Хятадын


хэрэглэгчдийн эрэлтийг нөхөхүйц үйлдвэрлэл явуулдаг эдийн засгууд уналтад орж буй экспортоо нөхөхөд улам хүндрэлтэй болох аж. “The Economist” сэтгүүлд “Хятадын өргөн хэрэглээний барааны хэрэглэгчдийн өсөлт нь бодитой бөгөөд цаашид ч үргэлжлэх нь тодорхой” гэжээ. Хэдий тийм боловч энэ нь дэлхийн эдийн засгийг сэргээхэд хангалтгүй юм. Хэрвээ Монгол Улс Хятадын хэрэглэгчид худалдаж авах бүтээгдэхүүн болон үйлчилгээг экспортлох боломжийг бүрдүүлбэл тус улсын өргөн хэрэглээний салбарт өрсөлдөх алтан боломж болох аж.

ОХУ-ын үйлдвэрлэл

ОХУ-ын үйлдвэрлэл таамаглаж байснаас илүү гүйцэтгэлтэй байна. Есдүгээр сард захиалгын индекс (Purchasing Managers' Index) 49.1-т хүрч наймдугаар сарын 47.9 гэсэн үзүүлэлтээс өсчээ. Хэдийгээр энэ тоо нь шинжээчдийн таамаглаж байснаас яльгүй өндөр байсан ч тус салбарын агшилтыг илтгэсэн хэвээр л байгаа юм. “PMI” индекс 50-иас доош орвол агшилтыг илтгэдэг, харин 50-иас дээш гарвал өсөлттэй байгааг илтгэх аж. ОХУ-ын хувьд сүүлийн 10 сарын турш 50 онооноос доош үзүүлэлттэй байна. Рублийн ханшийн уналт импортын өртгийг нэмэгдүүлсэн бөгөөд тус улсын Засгийн газар хэрэглээ зарцуулалтыг нэмэгдэх олон арга хэмжээ авч буй. ОХУ-ын эдийн засаг хоёр жилийн турш хямарч байгаа нь нэг талаас АНУ болон Европын холбооны эдийн засгийн хориг арга хэмжээ, нөгөө талаас нефтийн сул үнэтэй холбоотой. Рубль ам.долларын эсрэг 39 хувиар суларсан байна. Хэдийгээр хэрэглэгчид дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авалт түлхүү хийж байгаа ч тус улсын үйлдвэрлэл сүүлийн хоёр жилийн турш буурсан бөгөөд өсөн нэмэгдэж байгаа зардлын улмаас компаниуд ажлын байраа танахад хүрч байна. ■



Баялгийг арвижуулж баяждаг



Ц.Элбэгсайхан

Монголчууд өнгөрсөн жил 5.2 тэрбум ам.долларын импорт хийжээ. Үүний 30 хувь нь автомашин, түүний эд анги, 30 хувь нь бензин, түлш эзэлж байна. Дээрээс нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн худалдан авахад 12 хувийг, химийн бүтээгдэхүүн хаймар, хуванцар худалдан авахад мөн 12 хувийг зарцуулжээ. Үлдсэн нь хүнс болон бусад төрлийн бүтээгдэхүүн.

Машины ганц үйлдвэртэй болчихвол гадагш урсан гарч байгаа дээрх ам.долларын хэдийг нь хадгалж үлдэж чадах бол. Олон жил дуншиж байгаа нефть боловсруулах үйлдвэрийг барьчихвал мөн хичнээнийг хэмнэж болох вэ?

Гэхдээ бидний одоо хөндөх сэдэв зөвхөн хэмнэх, хадгалах тухай бус үржүүлэх, арвижуулах тухай юм. Өнөөдөр Монгол Улсын гадаад зах зээлд санал болгодог зүйлс нь ердөө л түүхий эд. Нийт экспортын 88 гаруй хувийг ашигт малтмалын бүтээгдэхүүн эзэлдэг. Ашигт малтмалын экспорт дотроо чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр болон баяжмал, боловсруулаагүй нефть 83 хувийг, нийт экспортын 73 хувийг эзэлж байна. Төмрийн хүдрээ баяжуулалгүй экспортлоход тонн тутам нь 40-50 ам.доллар. Хэрэв түүнийгээ боловсруулж, хайлуулж, хэвэнд цутгаад

арматур төмөр болгож зарвал тонн тутам нь 600 ам.доллар хүрэх боломжтой.

Яг үүнтэй адилаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж ихээхэн хэмнэлт хийж буй жишээ ердөө дэргэд байна. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн засвар механикийн завод гэж бий. Энэ заводод уул уурхайн машин, механизмын эд анги үйлдвэрлэдэг. Жишээ нь, тус завод туузан дамжуургын гинжийг өөрсдөө бүтээж байна. Хэрэв үүнийг гадаадаас худалдаж авбал 480 мянга орчим ам.доллар. Харин дотооддоо бүтээх өртөг нь 180 сая орчим төгрөг гэнэ. “Эрдэнэт” үйлдвэрийн засвар механикийн завод одоогоор үндсэн үйлдвэрлэл, экскаваторын төрөл бүрийн эд анги, бутлуурын эд анги үйлдвэрлэдэг. Үйлдвэрийн нөөц бололцоог бүрэн ашиглавал уул уурхай төдийгүй хөдөө аж ахуй, барилга, хүнсний үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүдийг ч хийх боломжтой гэнэ.

“Эрдэнэт” үйлдвэрийг түшиглэж “Эрдмин” гэх компани байгуулагдсан. Компани тус уурхайн хаягдал овоолгыг ашиглан хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг юм. Хагас боловсруулсан гэдэг нь 99.9 хувийн агууламжтай цэвэр катодин зэс юм. Цэвэр зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр ойролцоогоор 5000 ам.доллар. Харин

олборлосноо тэр чигээр нь экспорлоход тонн тутамд нь 30 ам.доллар л олно. Хаягдал овоолгоос жилдээ 3000 тонн катодин зэс үйлдвэрлэдэг. 1997 оноос хойш ажиллаж байгаа тус үйлдвэр 2005 оноос кабельны түүхий эд татанги утас, 2007 оноос төрөл бүрийн кабель бүтээх болжээ. Өнөөдөр тэдний хэрэглэгчийн гарт хүрдэг эцсийн бүтээгдэхүүн нь цахилгааны уртасгагч залгуур. Цэвэр зэсээрээ уртасгагч залгуур үйлдвэрлэхэд нэг тонноос олох орлого нь гурав дахин өсдөг байна.

Хүртээмжтэй байдлаа бодох юм бол жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх нь зөв. Гэхдээ жижиг, дунд үйлдвэрлэл нь хүнд үйлдвэрлэлээ дагаж хөгждөг ажээ. Тухайлбал “МонШибасаки” гэх монгол компани аутсорсинг үйлчилгээ явуулж “Тоёота”, “Хонда”, “Исүзү” зэрэг Японы томоохон автомашины үйлдвэрт жижиг эд анги үйлдвэрлэн нийлүүлдэг байна. Жижиг гэдэг нь ерөнхийдөө эрэг, гайх гэж ойлгож болно. Хэрэв хүнд үйлдвэрүүд бий болчихвол монголчууд оймс нэхэж, углааш оёхоос илүү олон зүйл бүтээж чадахын нотолгоо аж. Яагаад Японд байгаа үйлдвэрүүдийг түшиглэж болоод байхад Монголдоо байгааг нь болохгүй гэж. Нөгөө талаас хүнд үйлдвэр байхгүй учраас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид түүхий эд, бэлдэц материалыг

нэмүү өртөгтэйгээр, тээврийн зардалтай, гаалийн татвар төлж байж импортоор авч байна. Энэ нь бүтээгдэхүүнийг зах зээл дээр үнийн хувьд өрсөлдөх чадваргүй болгодог.

Аж үйлдвэрийн сайдын зөвлөх Д.Галтбаатар “Суурь үйлдвэр нь бусад үйлдвэрлэлээ дагуулж байдаг учир хамгийн түрүүнд байгалийн нөөц баялагтаа түшиглэх нь зайлшгүй юм. Суурь үйлдвэрлэлээ бий болгоод нөхцлийг бүрдүүлээд өгчихвөл бүгдийг төр хийх шаардлага гарахгүй. Үр ашигтай л бол гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг зах зээл татдаг жамтай” гэсэн юм.

Хүнд үйлдвэрийг хөгжүүлж чадвал газрын доорх баялгаа газрын дээр гаргаад хэдэн арав дахин арвижуулах боломж их байна. Монгол нефть, төмөр, нүүрс нөөцтэй юм. Бид нефть боловсруулах үйлдвэр нэг, төмрийн хүдэр хайлуулах үйлдвэр нэгийг барихад цөөнгүй асуудал шийдэгдэх боломжтой. Зөвхөн нефтийн хувьд авч үзэхэд боловсруулах үйлдвэртэй болвол өгөөж нь маш их. Технологийн хувьд товчхондоо спирт нэрдэгтэй төстэй гэнэ. Нефтиэ нэрээд бензин гаргаж авна. Үлдэгдлээс нь дизель түлш, мазутийг ялгаж аваад үлдсэн шаарыг бусад технологиор боловсруулна. Тухайлбал,

гадаас импортолж авдаг замын хар хийх үндсэн материал нь мөн л нефть. Төрөөс аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын эцсийн зорилго нь өндөр технологийн үйлдвэрлэл бий болгох. Өнөөдөр монголчуудын хийж, бүтээж буй бүхний 97 хувь нь технологийн агууламжгүй, нам технологитой. Өндөр технологийн бүтээгдэхүүн гэж хэлж болох барааны эзлэх хувь ердөө 0.01 хувь. Эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгцээ шаардлагын тухай эдийн засагчид, улстөрчид, гадаад дотоодын зөвлөх байгууллагууд хэлж ярьсаар буй. Тэгвэл тэр боломж хүнд үйлдвэрлэлээ дагаад бий болох хөгжлийн нэг гарц харагдаж байна. ■

СУРВАЛЖЛАГА



“Экобус” авто угсралтын үйлдвэрийн J-800T автобусууд

iPhone шиг Автобус

Э.Зоригт

Маргаан дагуулсан “Экобус” авто угсралтын үйлдвэр тун цэвэрхэн аж. Будаг нь ханхалсан 20 ширхэг J-800T автобусыг хэдхэн хоногийн өмнө нийслэлийнхэнд гардуулсан

энэ үйлдвэрт чимээ анир бараг алга. Өмнөх нийгмийн үед агуулах байсан урт барилгын дээд талд “Экобус” хэмээн бичсэн том хаалганы ард хүн байгаа эсэх нь үл мэдэгдэм тийм чимээгүй.

Том хаалгыг хүчлэн таттал сэв хийх салхины аясаар машины тос, маслоны үнэр хамар цоргино. Өмнө нь агуулах байсан гэж мэдэгдэхээргүй болтол нь засварласан авто угсралтын үйлдвэрт

хоёр ч J-800T автобус байх бөгөөд дэргэд нь хөнгөн хөдөлгөөнтэй эмэгтэй зогсож харагдана. Тэрбээр “Эколог бус” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Цэцэгмаа аж. Өдгөө 70 насны босго шүргэн алдаж яваа ч тун чиг ануухан харагдах захирал аж. Эдийн засгийн сэтгүүлээс сэтгүүлч ирнэ гэсэн сургаар автобусаа үзүүлэхэд бэлдэж зогссон нь энэ.

Жилд 120 автобус үйлдвэрлэх хүчин чадалтай тус үйлдвэр Ерөнхийлөгчийн сүүн мялаалгаар анхны монгол автобусыг үйлдвэрлэж эхэлсэн нь саяхан. Гэтэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Монголчууд автобус хийгээгүй. Сэлбэг хэрэгслээ хятадаас авчирч угсарсан” хэмээн шүүмжилсэн нь олонтой. Энэ бол энэ инженерийн мэдлэггүй хүний үг аж. “Би энэ үйлдвэрээ талхны үйлдвэртэй зүйрлэх дуртай. Талхыг хийхийн тулд ганцхан үйлдвэр буудай тарьж, гурил тээрэмдэж, ууталж савлаад, хөөлгөгчөө өөрсдөө хийж, давс сахраа ч гэсэн үйлдвэрлэдэггүй. Харин бэлэн болсон бүтээгдэхүүнийг тус тусынх нь үйлдвэрээс худалдан авч өөрсдийн орц найрлагын дагуу өөр өөрийн онцлогтой гэсэн талхыг үйлдвэрлэдэг. Бид ч гэсэн ялгаагүй Зохион бүтээх товчоогоор өөрсдийн автобусны зураг төслийг гаргаад Монголын уур амьсгал, зам, зорчигчдод зориулсан автобусыг угсарч үйлдвэрлэдэг. Зарим хүмүүс угсралтыг үйлдвэрлэл биш гээд байгаа. Гэтэл тээвэрлэлтийг материаллаг үйлдвэрийн дөрөв дэх салбар гэж үздэг” хэмээн тус үйлдвэрийн захирал тайлбарлалаа. Тэгэхээр J-800T-г Монгол инженерүүдийн ур ухаанаар бүтсэн монгол автобус яах аргагүй мөн аж. Хөдөлгүүрээ хийж чадахгүй байж машин үйлдвэрлэнэ гэж юу байдаг юм гэж хэлэх хүн олон таардаг. Гэтэл дэлхийн жишиг угаасаа л ийм байдаг аж. Толгой угсралтын үйлдвэрийг дагаад салбар үйлдвэрүүд үүсдэг. Монгол автобусны нүүрийг монгол компани хийж байгаа гэсэн. Одоогоор тус үйлдвэрийг дагаад суудлын бүрээс оёдгоос авахуулаад 10 гаруй жижиг үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг байна. Дэлхийн аль ч оронд аж үйлдвэржилт энэ замаар л хөгжиж иржээ.

Автобус төрөх нь

Made in Mongolia гэдэг бичгээр магнайгаа чимэглэсэн ногоон өнгийн J-800T-г үйлдвэрлэх хамгийн эхний

шат бол зураг төсөл. 3D программ дээр эх бэлтгэлээ хийгээд юуг яаж, ямар хэлбэртэй захиалахаа төлөвлөнө. Тэр төлөвлөгөөний дагуу захиалгаа компаниудад өгнө. Ихэнх захиалгаа дотооддоо захиалахыг хичээх бөгөөд 10 гаруй монгол компаниуд. Тухайлбал, күзү, урд хойд нүүр, будаг, цонх гээд л автобусанд орох жижиг сажиг бүгдийг



J-800T автобусын дотор тал

л дотоодоосоо авна. Харин гаднын оронд захиалахаас аргагүй том тоног төхөөрөмжүүд байдаг гэнэ. Үүнд: Хөдөлгүүр, хурдны хайрцаг, урд хойд тэнхлэг, дугуй, шил багтдаг. Энэ дундаас монголчууд шилийг хийж чадаж байгаа ч “Экобус”-ийн стандартад нийцсэн үзэгдэх орчинг илүү өргөн болгосон бөмбөгөр том шилийг одоохондоо хийж чадахгүй байгаа аж. Чадахгүйдээ ч биш тийм том зуух л байхгүйд хамаг учир нь байгаа гэсэн. Тэр зуух нь үнэтэй учраас өртгөө нөхөхийн тулд монголчууд илүү олон автобус үйлдвэрлэх шаардлага тулгарч байгаа гэдгийг үйлдвэрийн Ерөнхий инженер Ариунболд хэлсэн юм. Хөдөлгүүр болон бусад эд ангийн хувьд гаднын оронд захиалдаг учир нь манайд төмөрлөгийн үйлдвэрийн хөгжил тааруутай холбоотой аж.

Захиалгаа өгсний дараа ирсэн эд ангиудыг холбож, угсрах ажил эхэлнэ. Угсрах хэсгийг Үйлдвэрлэлийн дамжлага шугамын I хэсэг гэх бөгөөд энд бүх эд ангийг холбоно. Түүний дараа будалтын буюу II хэсэгт бэлэн болсон автобусыг шилжүүлдэг аж. Тус үйлдвэр нийт 2000 ам метр ашигтай талбай бүхий өөрийн үйлдвэрийн байртай,

захиалгаас хамаарч үйлдвэрлэлийг 2-3 ээлжээр зохион байгуулж хүчин чадлыг өсгөх боломжтойн дээр өөр өөр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэгэн зэрэг зохион байгуулах технологийн бололцоотой, техник зохион бүтээлт, тооцоолол, технологи, чанарын хяналтын чиглэлийн инженер техникийн ажилтнуудтай. Нийт 30 гаруй ажилтантай

тус үйлдвэр нэг автобусыг дунджаар ажлын 21 хоногт бэлэн болгодог. Харин автобус зураг төслөөс хотын замд гарах хүртлээ нийт 12 шат дамжлага давдаг бөгөөд шалгалт, тохиргоо, туршилт гэсэн гурван шалгуурыг заавал давдаг аж. Товчхондоо “J-800T” төрөх явц ийм. Хэрвээ илүү дэлгэрэнгүй танилцахыг хүсвэл тус үйлдвэрийн үүд хаалга хүн бүрт нээлттэй байдаг гэсэн шүү.

“Ногоон” автобус

Ногоон гэдгийг хашилтад хийсэн учир нь J-800T бол байгальд ээлтэй автобус юм. Учир нь “Экобус” нь дизель хөдөлгүүрийн утааны хортой азотын ислийг ердийн азот буюу ус болгох сонгомол үйлчилгээтэй катализатортой тул хөө тортог гаргахгүй. Мөн компьютерийн удирдлагатай Евро-4 стандартын дизель хөдөлгүүр зэрэг нэмэлт төхөөрөмжөөр тоногдсон аж. А.Цэцэгмаа захирал “Импортын автобуснаас гарч байгаа утааг экобусынхтай харьцуулаад үзээрэй. Мөн бид олон улсын чанарын стандартчиллын байгууллагаар хорт утаа бараг гаргадаггүй гэдгийг баталгаажуулсан. Тухайлбал, манай автобус UNECE-ээс баталсан дэлхийн

техникийн шаардлагад нийцсэн” гэв. Үүнээс гадна монгол автобусын давуу тал ихээ. Тухайлбал, “Экобус” нь Монгол орны цаг уурын орчин нөхцөлд тохирсон, утаа ялгаруулдаггүй, жирийн автобуснаас шал нь хоёр дахин намхан тул хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан үйлчлүүлэхэд тохиромжтой.

Хүний оролцоогүйгээр буудлаа зарлах ухаалаг системтэй, өвлийн улиралд цантдаггүй вакуум цонхтой. Вагон хэлбэрийн, үргэлж металл гангамал хийцтэй, кузов хэсгийг дотооддоо бүрэн үйлдвэрлэсэн, аюулгүй байдал, ажлын гүйцэтгэл, түлшний зарцуулалтын хяналт, хийн нум, давхар амаржин, ухрахын болон дотор зааланд камертай, GPS системтэй гээд дурдаад байвал дуусахгүй.

Түүнчлэн байгаль орчинд ээлтэй ногоон хөдөлгүүртэй, урд хаалганы хэсэгт төлбөрийн цахим карт унших боломжтойгоор шийдэж өгсөн нь нийтийн тээврийн салбарт өөрчлөлтийн эхлэлийг тавьсан гэдгийг инженерүүд нь онцолсон юм. Портал тэнхлэгтэй уг автобус 9.56 метр урт, 30 хүний суудалтай, 70-80 хүний багтаамжтай аж.

Үнэ үү чанар уу?

“Та хямдхан учраас Nokia брэндийн 3310 утас барьдаг уу эсвэл илүү

технологижсон iPhone барьдаг уу”. Энэ асуултыг “Экобус”-ын үнийг тодруулсан сэтгүүлчээс Цэцэгмаа захирал асуулаа. Хариулт нь тодорхой iPhone. Гэтэл J-800T-г гаднаас оруулж ирдэг автобуснаас үнэтэй байдаг талаар олон хүн гомдолдог аж. Гэтэл гаднын автобус, J-800T хоёр технологийн хувьд яг л iPhone, 3310 шиг гэж ойлгож болох аж. Энгийн жишээ хэлэхэд нийслэлд явж байгаа ихэнх автобусын нь гүйлт 500 мянган км болсон. Энэ бол салж унах дөхсөн нийтийн тээвэр хотын замаар “нисч” явна гэсэн үг. Харин “Экобус” цоо шинээрээ. Дээрээс нь үнэ нэмэгддэг өөр нэг шалтгаан нь татвар байдаг аж. Гадаадаас автобус оруулж ирэхэд татварын хөнгөлөлт үзүүлэх хуультай. Гэтэл дотооддоо угсарч буй “Экобус”-ын сэлбэгэнд ямар нэг хөнгөлөлт байдаггүй аж. Мөн хөдөлгүүрийн евро ангилал дээшлэх тутам 10-18 мянган ам.долларын тоноглол нэмэгдэж, ашигт үйлийн чадамж сайжирдаг байна. Гэтэл татварын мөнгөөр татаас төлөлгүй гадаадаас худалдаж авсан автобусууд нь Евро-2, Евро-3 хөдөлгүүртэй мөртлөө 60-70 мянган ам.долларын үнэтэй. Тэгээд ч ихэвчлэн хуучин автобусууд орж ирдэг учир төд удалгүй өндөр өртгөөр засвар хийхэд хүрдэг байна.

Уг нь дотооддоо үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний гаалийн татварыг 20 хүртэл хувь багасгах боломжтойг Үйлдвэржилтийг дэмжих хуулийн төслийн хэлэлцүүлгээр ярьж байсан. Одоо гаалийн бүх татвар таван хувь. Дотоодын үйлдвэрлэлээ хамгаалахын тулд зарим зүйл дээр импортын гаалийн татварыг нэмье гэдэг ч хэрэгжихгүй, эсрэгээрээ тэглэчихсэн байгаа жишээний нэг энэ юм.

Дээрээс нь “Экобус” монгол залуусыг ажилтай болгож байгаа бол гаднаас оруулж ирж буй нийтийн тээвэр татвар ч үгүй, цалин ч үгүй дээрээс нь хуучин. Уг нь “Экобус” үйлдвэртэй төрийн түшээд танилцах үеэр УИХ-ын дарга З.Энхболд “Эд ангийг нь оруулж ирдэг энэ үйлдвэрийг татвараас чөлөөлөөгүй. Тэгэхээр гаднаас автобус авах нь ашигтай. Дотооддоо ашиггүй байх шийдвэрийг УИХ-аас гаргасан байна. Дотооддоо үйлдвэрлэх нь ядаж угсарч буй ажилчдынх нь цалин Монголд үлдэх юм байна. Тиймээс зайлшгүй гаднаас авах эд ангиудыг нь татвараас чөлөөлөх ёстой. Үүнийг УИХ, Засгийн газар судалж үзээд шийдэх боломжтой” гэжээ. Харин Үйлдвэрлэлийн сэтгэл сэргээсэн энэ үг бодит амьдрал дээр биеллээ олоогүй л байна. ■



“Экобус” авто угсралтын үйлдвэрийн I хэсэ

БОДЛОГО



Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат Концессын гэрээгээр баруун аймгуудад барьж буй авто замын ажилтай танилцлаа 2015 он 09 сар

Д.Эрдэнэбат: Монгол Улс уул уурхайгаас боловсруулах салбарын хөрөнгө оруулалт руу шилжихээ олон улсад зарлалаа

Д.Бэхбаяр

Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбаттай ярилцлаа

-Монгол Улс аж үйлдвэрийн салбарын том хуультай болоод удаагүй байна. Ер нь манай улсад өмнө нь аж үйлдвэрийн ямар бодлого байсан бэ?

-Социализмийн үед мал аж ахуйд суурилсан ямар үйлдвэрийг хөгжүүлэх талаарх аж үйлдвэрийн бодлого байсан.

Малын түүхий эдэд тулгуурласан үйлдвэрүүдийг тухайн үеийн социалист орнуудын тусламжтайгаар байгуулж, зээлээр боссон үйлдвэрүүд ч бий. Төлөвлөгөөт эдийн засаг учир бүх зүйл төлөвлөгөөгөөр явдаг, харин эдийн засгийн үр ашгийн бодлого дутуу дулимаг байжээ гэж харж байна. Гэхдээ аж үйлдвэрийн салбарын үндсийг энэ үед тавьж чадсан. Бид үүнийг үгүйсгэж

болохгүй. Ер нь манай улс 1930-аад оноос 1968 он хүртэл аж үйлдвэр гэсэн нэрийг хэрэглэж ирсэн. 1968 оноос хойш аж үйлдвэрийн дагнасан яам, агентлаг байгаагүй ч аль нэг яамны харьяанд давхардуулсан бодлогоор зохицуулж байсан байна.

Ардчилсан хувьсгалын дараа эдийн засгийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдсөн. Мөн ажиллаж байсан

үйлдвэрүүд алдагдалтай, технологи хуучирсан байдлууд давхацсан учраас олон үйлдвэр дампуурсан нь бодит үнэн юм.

Зах зээлийн шилжилтээс хойш аж үйлдвэрийн салбарт дагнасан тодорхой, цэгцтэй бодлого, хуульгүй явж ирсэн. Зах зээлд орсныхоо дараа төрөөс эдийн засгийг босгож ирэхэд л анхаарал хандуулсан байдаг. Өр зээл, зах зээлийн хараат байдал, чөлөөт худалдааг дэмжих чиглэлд идэвхтэй ажиллаж байсан. Дараа нь дэлхийд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өссөн нь уул уурхайн салбарыг хөгжүүлэх, ашигт малтмалын бүтээгдэхүүнийг экспортлоход бодлогоо чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн юм. ХАА, МАА-н салбарын гадаад экспортын бүтээгдэхүүний бодлого ЗХУ-аас хараат бус болсонтой холбогдон үндсэндээ зогссон шүү дээ. Ийм байдалд олон жил явж ирсэн.

Харин манай хувийн хэвшлийнхэн эдийн засгийн суурь үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн. Ганзагын наймаа эрхлээд олсон мөнгөөрөө иргэдийн хэрэгцээг хангах жижиг үйлдвэрүүд барьсан. Ганц нэг экспортын хөнгөн үйлдвэрүүд нь үйл ажиллагаагаа сэргээн технологио шинэчилж эхэлсэн байдаг.

Өнөөдрийг хүртэл бидний туулсан зам бол ашигт малтмалын баялгаа гадагш нь зарж, түүгээрээ амьдардаг улс байлаа. Гэтэл дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ унангуут бид ямар байдалд оров. Дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал дэндүү хоцорсон нь харагдлаа. Энэ нь экспортоор орж ирсэн валютаа буцаагаад импортын хэрэглээндээ зарцуулдгаас дүгнэлт хийж болно. 2012 оноос хойш Засгийн газар аж үйлдвэржилтийн салбартаа анхаарч эхэлсэн ч яаж хийх нь бүрхэг байв. Хүнд, хөнгөн үйлдвэрүүдийн бэлэн төсөл хөтөлбөрүүд байхгүй байсан нь үнэн. Тиймээс Засгийн газар орж ирсэн мөнгөөрөө үйлдвэрүүдийг дэмжээд явах ажлыг эхлүүлснийг зөв гэж харж байгаа.

-Төр өнөөдөр энэ салбарт хэрэгжүүлэх бодлогоо тодорхой болголоо. Улс орны эрчимтэй хөгжлийн эхийг тавих үүднээс танай яамыг байгуулсан болов уу?

-Аж үйлдвэрийн бодлогыг нэгтгэсэн Аж үйлдвэрийн яамтай болох шаардлага тулгарсан. Яам байгуулагдсанаас хойш

Монгол Улс төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлоготой боллоо. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зарим нэг алхам хийсэн. Үйлдвэрлэгчдийн олон жил хүлээсэн арга хэмжээг эхнээс нь шийдээд эхэллээ. Үүнийг тоон үзүүлэлт, үйлдвэрийн идэвхжлээр тодорхойлно. Дотоодын үйлдвэрүүд сэргэн, үйл ажиллагаа нь жигдэрч байгаа. Хэдийгээр эдийн засгийн хүндрэл тохиож байгаа ч бид үндэсний үйлдвэрлэлд түлхүү анхаарч, дэмжиж байгаа нь ирээдүйд эерэг нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэнтэй холбоотой. Үүнтэй уялдан Монголын эдийн засаг, үйлдвэржилтийн бодлогод аажмаар өөрчлөлт орж байна. Гадаад хөрөнгө оруулалт татарлаа гэдэг. Энэ нь ямар хөрөнгө оруулалт байсан бэ гэдэгт эргээд анализ хийх хэрэгтэй. Ашигт малтмалын түүхий эдийнхээ 90 хувийг түүхийгээр нь экспортолдог орны гадаадын хөрөнгө оруулалт бол зөвхөн уул уурхайн салбарынх байх нь ойлгомжтой. Гэтэл дэлхийд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унаад ирэхээр энэ салбарын хөрөнгө оруулалт буурдаг юм байна гэдгийг нотолчихлоо.

Тэгэхээр бид цаашид яах вэ. Уул уурхай болон импортоос хараат орон цаашдаа яах вэ гэдэгт төр шийдэл гаргах ёстой байсан. Энэ шийдэл нь **нэгдүгээрт**, дотоодын боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, экспортын баримжаатай болох бодлого. **Хоёрдугаарт**, ашигт малтмалын нөөцөө ашиглан бүрэн боловсруулсан бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангаснаар импортын хараат байдлаас гарах арга юм. **Гуравдугаарт**, өрсөлдөх чадвар, технологитой үйлдвэрүүдийг бусад оронтой хамтран байгуулах нь иргэдийнхээ хэрэглээг чанар стандартын түвшинд хангах боломж гэж харсан. Цаана нь ажлын байр гээд олон асуудал яригдана. Манай улс цаашид энэ чиг хандлага руу аажмаар шилжих болно. Үйлдвэр байгуулах нь нэг амьсгаагаар огцом хийдэг ажил биш юм. Цаг хугацаа орно. Бид дээрх бодлогоо олон улсын худалдаа эдийн засгийн харилцаандаа тусгаж, олон улсад ойлгуулахад хугацаа зарж байна. Зарахаас ч аргагүй юм.

-Төрөөс дотоодын үйлдвэрийг дэмжих бодлогын чиглэлээ гаргасан. Ямар чиглэл байх талд дэлгэрүүлж ярина уу?

-Түүхий эдийн экспортын хараат орноос түүхий эдийн нөөцдөө

тулгуурласан аж үйлдвэрийн хөгжлийг авч явах бодлого руу шилжиж байна. Мэдээж бид аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг олон улсад гаргахыг эрмэлзэнэ. Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортод гарах нөхцөлийг бодлогоор дэмжиж байна. Бид ашигт малтмал болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний арвин нөөцтэй. Дотоодын хэрэгцээг хангаад гадагш гаргах бүрэн боломжтой улс. Энэ нь улс орон бүрт тохиодог хувь заяа биш шүү дээ. Өнөөдөр манай улс зэс, хар төмөрлөг, нүүрсийг түүхийгээр нь шууд гадагш гаргаж байна. Хэрэв бид эдгээр бүтээгдэхүүнээ нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болгоод гаргавал олон талын ашиг тустай олон асуудлыг шийдвэрлэнэ. Эх орондоо ашиг орлого олох олон боломж олгоно.

Бид дотоодын үйлдвэрийг дэмжих бодлогын чиглэлээ гаргасан. Тухайлбал, хүнд үйлдвэр дээр зэс хайлуулах, нефть боловсруулах, ган хайлуулах гэсэн гурван төрлийн үйлдвэрт түлхүү анхаарч, үйлдвэрүүдийг босгох ажил ид явж байна. Яамнаас ийм үйлдвэрүүдийг барьж байгуулна, ингэхийн тулд та бүхний технологийг нэвтрүүлж хамтран ажилламаар байна гэдэг мэдээллийг хамтран ажилладаг улс орнуудад өгсөн.

Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт дэлхийн хэмжээнд ихэд хүндэрлээ. Ашигт малтмалын үнэ олон улсад хэзээ дахин өсөх нь бүрхэг байна. Тиймээс Монгол Улс уул уурхайн хөрөнгө оруулалтаас боловсруулах салбарын хөрөнгө оруулалт руу шилжихээ олон улсад зарлаж байгаа юм. Хандлага эерэг байна. Улс орнууд бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг шаардах нь зүйн хэрэг. Урьдчилсан судалгаа хэрэгтэй, хууль журмаа цэгцэлж, эрх зүйн орчноо бүрдүүлэх хэрэгтэй. Төсөл хөтөлбөр боловсруулах гээд олон шинэ нөхцөл үүсч байна. Бид эхнээс нь хийгээд явж байна. Хамгийн түрүүнд бодлогоор аль чиглэлийн ямар төслийг дэмжих вэ, ямар бараа бүтээгдэхүүнийг аль улсын хөрөнгө оруулагч нартай хамтран ашигтайгаар экспортлох чиглэлд судалгаа хийгээд ажиллаж байна.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд энэ асуудалд анхаарал хандуулаад эхэлсэн. Тухайлбал, хамгийн том нь Монгол, Японы эдийн засгийн түншлэл. Энэ



бол технологи нутагшуулах, шинэ үйлдвэрүүд оруулж ирэх, боловсруулсан бүтээгдэхүүнээ Япон болон бусад зах зээлд гаргах боломжийг нээж өгч буйгаар онцлог түншлэл болсон. Мөн энэхүү Монголын аж үйлдвэрийн салбарын анхдугаар чуулган ч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад бодлогоо танилцуулж, хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчноо бүрдсэнийг хэлэх зорилготой юм.

Монголын зах зээл дэндүү жижиг. Гэхдээ нөөцдөө тулгуурлан гадны технологийг нэвтрүүлж, экспортлох боломж нь асар өндөр юм. Тиймээс л гадны технологи, туршлагыг хөрөнгө оруулалттай нь оруулж ирээд гадаад зах зээл рүү гаргая гэсэн саналыг улс орнууд эерэгээр хүлээн авч байгаа.

-Хоёр хөрштэй эдийн засгийн харилцааны хувьд танай яам ямар бодлого түлхүү баримталж байна вэ?

-Хүнд үйлдвэрүүд байгуулахад хамтран оролцох саналыг хоёр хөршдөө гаргасан. Учир нь манай улсын импортын хараат том дарамтыг багасгах гол нөхцөл нь хоёр хөрштэйгээ хамтран ажиллахаас өөр арга байхгүй. Тэргүүлэх шугам ч гэж тодорхойлсон. Манай нийт импортын гуравны нэг нь нефть байна. Дотоодын хэрэгцээг хангах зорилготой нефть боловсруулах төслийн техник эдийн засгийн урьдчилсан үндэслэлийг хийж байна. Олон орон сонирхож байгаа. Энэ том төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхи Монголд байхгүй учраас хамтран

хэрэгжүүлэх түнш орныг хайж байгаа юм. Энэ бол Монгол Улсын үйлдвэржилтийн гадаад нээлттэй бодлого байх болно. Үүгээр Монгол, Хятад, Орос гурван орны ойлголцлыг бий болгох, тулгарах саад бэрхшээлийг шийдэх, цаашлаад тэгш хөгжих нөхцөлийг хангаад явъя гэж байгаа юм.

-Хүнд үйлдвэрийн салбарын төслүүд гадаадын хөрөнгө оруулалтгүйгээр явахгүй нь ойлгомжтой. Эрх зүйн орчин бүрдсэн гэж харж болох уу?

-Хууль эрх зүйн орчноо бүрдүүлчихсэн. Боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт дээр гадны компаниуд маш их судалгаа үндэслэлтэй орж ирнэ. Цаг хугацаа багагүй орох хөрөнгө оруулалтын салбар. Уул уурхайд хөрөнгө оруулаад, хэдэн техник авчраад газар шороо ухаад гараад явдаг асуудал биш.

Олон улсын хандлага нь аажмаар нааш эргэсэн. Бид Герман улстай харилцах харилцаагаа шинэ шатанд гаргахаар төлөвлөж байна. Герман, Европын орнууд бол технологийн хувьд тэргүүлэх улсууд. Хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр маш сайн технологитой улс. Хүнд үйлдвэрийн чиглэлээр ч байгаа. Мөн Европ өөрөө ашигт малтмал, болон түүхий эдийн маш том хэрэглэгч орон. Ашигт малтмал, түүхий эдийн хэрэглээний эрэлт тэнд их байна. Харин манайд технологи, үйлдвэрлэл, санхүүгийн чадавхи дутагдалтай. Энэ дутуу нөхцөлүүдээ харилцан хэрхэн нөхөн вэ гэдэгт

анхаарах ёстой. Төр өмнө нь бүгдийг хийх гэдэг байсан бол одоо экспортын ашигтай төсөлд баталгаа гаргаж өгнө. Үйлдвэрлэгчид өөрсдөө хөрөнгө оруулалт, технологио оруулж ирээд ажиллах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Яамны зүгээс дэлхийд өрсөлдөх чадвартай ашигт малтмалаас үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгчдийг түлхүү дэмжиж ажиллана. Өнөөдрийн байдлаар хөрөнгө мөнгөний хэмжээ нь нэлээд том 2-3 төсөл авж байна. Үүний тулд компаниудаа чадавхжуулах, технологио сайжруулах, орчин үеийн үйлдвэртэй болох ёстой. Зэс, хар төмөрлөгийн үйлдвэрүүдийг дагаад хэчнээн жижиг, дунд үйлдвэр бий болох вэ, хэчнээн ажлын байр нэмэгдэж, эдийн засагт хувь нэмэр оруулах вэ гэдэг талаас харах нь зөв.

Тухайлбал, хөнгөн үйлдвэрийн салбарт ноос ноолуурын экспортын чиглэлийн томоохон үйлдвэрүүд байгуулья. Манайхан өнөөдөр өөрийн улсын багтаамж болох 50-60 мянган цамц борлуулчихвал түүндээ сэтгэл ханачихдаг. Тэгвэл яамны бодлого хувийн хэвшлийнхнийг гадагш олон улсын зах зээл рүү харж ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна. Та нар нэг сая цамц үйлдвэрлэ. Өргөн уудам зах зээл байна. Үүний тулд технологио шинэчил, санхүүгээ сайжруул, бүтээгдэхүүнийг стандартын өндөр түвшинд хий. Тэгвэл төр дэмжинэ гэсэн ийм л бодлого. Өнөөдрийн байгаа зүйлдээ сэтгэл ханачихаад явдгаа болих хэрэгтэй. Манай зах зээл жижиг, үнэ өндөртэй байдаг, манайд ямар үйлдвэр хөгжих биш гэсэн бодлоо хая гэж байгаа юм. Таван хүнд зориулсан бүтээгдэхүүний өртөг өндөр гарна, таван мянган хүнд зориулбал өртөг бага гарна, гэхдээ түүнийгээ дэлхийтэй харьцуулж том харж, сэтгэж ажилла гэж байгаа юм. Зөвхөн дотоодын зах зээлээ харж, голоод суугаад байвал улс орон яаж хөгжих вэ. Тиймээс би гадагш томилолтоор явахдаа бизнесийнхний группийг дагуулж явдаг.

Зөвхөн уул уурхайгаар улсын хөгжлийг харахгүй болсон шүү

-ЕвроАзийн Торгоны зам, Хятад, Орос, Монголын эдийн засгийн коридор гэх мэт олон улсын хөтөлбөрүүдэд

Манай улс хэрхэн орж байгаа, үүгээр дамжуулан хөрөнгө оруулалт хэрхэн татах боломжтой вэ?

-Мэдээж Торгоны замын төсөлд Монгол Улс “талын зам” төсөл санаачлаад явж байгаа энэ бол хэтийн ажил. Харин Хятад, Орос, манай гурвын Эдийн засгийн коридор хөтөлбөр дээр ид ажиллаж байна. Тодотговол хоёр хөршийг холбох эрх ашиг, Хятадын Европын холбооны улстай холбох эрх ашиг. Тэгвэл завсрын дамжин өнгөрөх Монгол Улсын эрх ашиг юун дээр тулгуурлах вэ гэдэг нь их чухал. Бид холбогчийнхоо хувьд бусад улстай холбогдох аюулгүй байдлын найдвартай түнш байж, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийн бүх боломжоо манай улстай хамтран хийх ёстой гэдэг зарчим баримтлах ёстой. Энэ тохиолдолд бид хамтарч ажиллаж болж байна.

Дахин хэлэхэд өнөөдөр зөвхөн уул уурхайгаар улс орны хөгжлийг харахгүй болсон шүү. Үйлдвэр, худалдаа, эдийн засаг, соёл гэх зэрэг бусад салбарыг бодлогоор дэмжих хэрэгтэй. Эдгээр боломжийг ашиглан хөгжлийн зөв голдрилд орох ёстой. Аж үйлдвэрийн яам Герман, Европын холбоотой хамтын ажиллагааг сэргээн шинэ шатанд гарч ажиллах тухай дээр ярьсан. Европын холбоо нь хэрэглээ өндөртэй, ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүнийг хэрэглэж хэвшсэн улс. Тэнд бүтээгдэхүүнээ борлуулахын тулд тэдний стандартаар, тэдний технологиор, тэдний тавьсан шаардлагаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх ёстой. Энэ бол бидэнд хол сонсогдоно. Гэхдээ холыг ойртуулахын тулд бид эхлээд урьж, хамтран ажиллах шаардлагатай.

-Японы зах зээлд ч гарах сайхан нөхцөлийг Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрээр бүрдүүлээ?

-Япон бол жижиг, дунд үйлдвэрлэл, технологиор тэргүүлэх орон. 250 сая хүн амтай том зах зээлд монголчууд юугаар гарах талаар судалгаа хийж байна. Хамгийн боломжтой нь хөдөө аж ахуйгаас гаралтай хүнс болон ноос ноолууран чиглэлийн бүтээгдэхүүнүүд. Дээр нь Японы машин техникийн жижиг сэлбэг хэрэгслэлийн үйлдвэрлэл эрхэлж болж байна. Улмаар ийм үйлдвэрүүдийн парк байгуулах талаар ярьж байна. Түүхий эд нь манайд хямд, бас ажиллах

хүч нь байна шүү дээ. Энэ боломжоо ашиглах ёстой. Японы зах зээл рүү гаргахаар машины техник хэрэгслийн ганц нэг жижиг компаниуд ажиллаж байгаа. Цаашдаа паркын хэмжээнд ярина. Япончууд ажлыг маш их судалж, нягталдаг ард түмэн. Тэгэхээр бид тэвчээртэй, бас тогтвортой, тууштай бодлогоор тэдэнтэй хамтран ажиллах нь зөв.

-Аж үйлдвэрийн салбарын бодлого, хуулиуд, хэрэгжүүлээд эхэллээ. Мөн том төсөл, хөтөлбөрүүд тогтвортой үргэлжлэх бол гэдэгт бизнесийнхэн санаа зовж байна. Манай улсад бодлогын залгамж халаа гэж алга байна шүү дээ?

-Эргэлзээ байгаа. Манай яам байгуулагдаад удаагүй ч бодлогын шийдвэрүүдээ богино хугацаанд гаргаж тавьсан. Энэ нь гадаад, дотоодын үйлдвэрлэгчдэд таалагдаж байгаа. Гэхдээ энэ бодлого, төлөвлөгөө хэр удаан байх бол, засаг унаад шинэ засаг, сайд гарч ирэнгүүт өөрчлөөд өөр бодлого гараад ирэх вий, 2016 оны сонгуулийн дараа яах бол гэсэн эргэлзээ байгаа. Энэ нь ганц Аж үйлдвэрийн яамны асуудал биш.

Би УИХ-ын гишүүнийхээ хувьд бодлого тогтвортой явах эрх зүйн орчныг маш хурдан шинэчлээч гэдэг шаардлага тавьж байгаа. Ялангуяа Үндсэн хуульд засаглалын тогтвортой байдлыг хангах заалтыг хурдан оруулах, төрийн гаргасан шийдвэр бодлогыг дараагийн засаг төр уламжлан мөрддөг байхыг хуульчлах асуудлыг тавьж байгаа.

УИХ-аас Аж үйлдвэрийн салбарт төрөөс баримтлах бодлогыг 15 жилийн хугацаатай баталсан. Үүнийг хэн нэгэн сайд, УИХ-ын гишүүн гарч ирээд өөрчлөх ёсгүй. Энэхүү бодлогыг УИХ-ын бүх гишүүн, намуудын төлөөллүүд, үйлдвэрлэгчид дэмжиж байгаа учраас ямар ч засаг төр гарсан энэ бодлого цаашид тогтвортой хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байна.

-Та том хэмжээний төсөл, хүнд, хөнгөн үйлдвэрүүдийн тухай ярилаа. Тэгвэл цаашид барих том үйлдвэрүүдэд ажиллах боловсон хүчин манайд байна уу, хүний нөөцийн ямар бодлого байна вэ?

-Манай салбар инженер техникийн ажилтнуудын хомсдолд үнэхээр

орсон. Үйлдвэрүүдээс гадна яаманд мэргэжлийн хүн авъя гэхэд олдохгүй байна. Энэ бол Монгол Улсад инженер техникийн ажилтнууд тасарсныг

“Түүхий эдийн экспортын хараат орноос түүхий эдийн нөөцдөө тулгуурласан аж үйлдвэрийн хөгжлийг авч явах бодлого руу шилжиж байна.”

харуулна. Тодорхой бодлого хэрэгжүүлж эхэлсэн. 1000 инженер техникийн ажилтныг Японд бэлтгэхээр ажиллаж байна. Манай яам Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах гэж байгаатай холбогдуулан шинжлэх ухаан, үйлдвэрлэл, технологийг холбоход ямар сургууль шаардлагатай байгаа талаар тодорхой санал өгсөн. Зөвхөн онол биш, шинжлэх ухаан үйлдвэрлэл, технологийн холбоосоор мэргэшсэн ажилтныг бэлтгэх тухай ярьж байна. Манайд шинжлэх ухаан, үйлдвэрлэл хоёр олон жил тусдаа явж ирлээ шүү дээ.

-Бусад сайдтай харьцуулахад Аж үйлдвэрийн сайд орон нутагт маш их ажиллаж байгааг иргэд харж байна. Нэг харахад Сэлэнгэ, Дорнод, Завханд явж байх. Өрөөндөө шигдэж суухгүйгээр үйлдвэр, газар тариалан, замуудын ажил байдалтай танилцаад явж байгаагаас үзвэл та үйлдвэрлэгчидтэй их ойр байж, тэдний зовлон, жаргалыг мэдэрч байна уу гэлтэй.

-Ачаалал ихтэй яам. Монгол орны өнцөг булан бүрт үйлдвэрүүд бий. Ирэх жил Чингис бондоор баригдсан олон үйлдвэр ашиглалтад орох учраас өмнөхөөс ч илүүтэй орон нутагт ажиллана. Үйлдвэрлэгчдэд ямар зовлон бэрхшээл учирдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Маш их бэрхшээл зовлон, оюуны стресс дунд үйлдвэр босч ирдэг. Тэднийг сонсож, үйлдвэрийг нь үзэж харж урам өгөх ёстой. Зовлон бэрхшээлийг нь эдийн засаг, хууль эрх зүйн талаас эхэлсэн нь шийдээд явж байна.

Дараагийн алхам нь үйлдвэр



Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат Төв аймгийн Сэргэлэн суман дахь МАК компанийн "Хийт бетон" ны үйлдвэртэй танилцлаа 2015.09.29нд

барих процесс. Үйлдвэр барих нь байшин барилга, орон сууц барихтай адилхан асуудал биш юм. Маш нарийн төлөвлөлтөөр тоног төхөөрөмж суурилуулна. Тэр технологийг суурилуулах нарийн мэргэжлийн олон инженер техникийн ажилтан шаардлагатай. Мөн тэр ажилтнуудаа яаж тогтвортой ажилуулах талд хүндрэл учирна гэх мэтчилэн үйлдвэрлэгчдийн хэлдэг, ярьдаг, бэрхшээл бий. Эдгээр асуудлыг шийдэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр яам ажиллаж байгаа.

Худалдаанд цэнзур тавих хууль биш юм аа

-Монгол Улс анх удаа Худалдааны тухай хуультай болох гэж байгаа. Хуулийн ач холбогдол юу байх вэ?

-Бид чөлөөт зах зээлд шилжээд 25 жил өнгөрчээ. Нэг харсан чинь бүгд худалдаачин болчихож. Шат шатандаа шүү. Монгол Улс худалдааг зөв зохион байгуулалтад оруулах, худалдааг зөв цэгтэй зохицуулахад чиглэсэн хууль юм. Түүнээс худалдаачдыг шахах, дарамтлах тухай биш.

Мэргэжлийн хяналт, татвартай огт хамаагүй хууль. Худалдаа нь өөрөө энгийн хэрэглэгчид бараа бүтээгдэхүүнийг чанар стандартад нийцсэн байдлаар борлуулах тухай хамгийн энгийн ойлголт. Худалдаа нь

үндэсний аюулгүй байдлын хүрээнд ярих асуудал шүү дээ. Юу дуртайгаа оруулж ирдэг нь үндэсний аюулгүй байдалд хор уршиг болох нөхцөлийг бүрдүүлж магадгүй байна. Өнөөдөр бид гаднаас ямар хүнсний бүтээгдэхүүнүүд оруулж ирчихээд, өдөр тутмынхаа хэрэгцээнд хэрэглэж байгаагаа мэдэхгүй л байна. Ямар ч баталгаа алга. Хэдэн жилийн дараа хүний биед, генд ямар сөрөг нөлөө үзүүлж болох вэ гэдгийг зохицуулах бодлогогүй байгаа нь өөрөө худалдааны зохицуулалтгүйг харуулна.


Зарим хүн энэхүү хуулийн төслийг худалдаанд цэнзур тавих нь хэмээн ярьсан. Цэнзур бол биш. Энгийн жишээ хэлье. Европт иргэд нь том том худалдааны төвүүдээсээ худалдаа хийдэг. Харин Японд жижиглэнгийн системтэй, жижиг төвүүдээсээ худалдаа хийдэг. Энэ хоёр системийн аль нь Монголд ашигтай талаас судалгаа хийхэд жижиглэнгийн систем нь зүйтэй гэдгийг манай худалдаа эрхлэгчид өөрсдөө гаргасан. Монголын худалдаа эрхлэгчдийн сүлжээ маш томорч байна. Тэд сүлжээгээ нэг стандартад оруулъя, төр дэмжих үү гэж байна. Худалдаачид гэхээр зөвхөн Нарантуул зах гэж ойлгож болохгүй. Худалдаа нэг зохицуулалтад орж, хотын захын бөөний төвөөсөө жижиглэнгийн системээр дэлгүүрүүд рүү хуваарилагддаг байдлыг л бодлого болгож өгч байгаа юм. Худалдааны стандарт, аюулгүй байдал, чанарын

өндөр түвшний тухай бодлого гэж ойлгож болно. Энэхүү хуулийн төслийг УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэнэ.


-Европын том сүлжээ төвүүд, Японы жижиглэнгийн системийн ялгаа юу байсан бол?

-Европын орнуудын иргэд худалдан авалт, хэрэглээ өндөртэй хүмүүс шүү дээ. Японых бол тооцоотой, хямгач зах зээл. Японы жижиглэнгийн бараа хүргэлт, үнэ, стандарт, аюулгүй байдал нь манайд тохирно гэж үзсэн. Монголчуудын хэдэн хувь нь өнөөдөр тэр том төвөөс үйлчлүүлэх бол гээд судлахад бараг л таван хувь л гэж гарч байна. 95 хувь нь жижиглэн хүнсний дэлгүүрээр үйлчлүүлнэ гэсэн үг. Манай иргэдийн амьдралын түвшнээс харагдана. Нэг маргаан явж байгаа. Монголоос экспортлогч нь хувь хүн байх уу, хуулийн этгээд байх уу гэж. Энэ бол эрүүл маргаан. Миний хувьд экспортлогч бол хэн ч байж болно. Монголоос бараа бүтээгдэхүүн гадагш гарч, валют орж ирж л байвал сайн. Харин импортлогч дээр хуулийн этгээд байх нь зөв гэж үзэж байгаа. Ялангуяа хүнсний талд. Хэн нэгэн хуулийн хариуцлага хүлээх чадвартай хуулийн этгээд заавал байх ёстой гэсэн үг. Энэ мэтчилэн хуулийн заалтууд бий. Монгол Улсад байх ёстой, энэ хуулийг батлах цаг нь болсон учраас би энэхүү хуулийн төслийг УИХ дээр хамгаалахын төлөө явна аа. ■

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ




ДНБ-Д АЖ ҮЙЛДВЭР



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ


Аймаг	Борлуулалт (сая төгрөг)
Баруун бүс	50,322.6
Баян-Өлгий	15,577.3
Говь-Алтай	14,407.7
Завхан	7,946.2
Увс	8,418
Ховд	3,973.4
Хангайн бүс	1,488,070.4
Архангай	5,028
Баянхонгор	4,991.6
Булган	9,857.3
Өвөрхангай	21,962.9
Хөвсгөл	10,074.6
Орхон	1,436,156
Төвийн бүс	1,188,341.1
Дорноговь	12,736.5
Дундговь	3,071.5
Өмнөговь	573,667.5
Сэлэнгэ	344,701.2
Төв	41,697
Дархан-Уул	172,334.9
Говьсүмбэр	40,132.5
Зүүн бүс	146,026.2
Дорнод	19,207.8
Сүхбаатар	119,512.4
Хэнтий	7,306
Улаанбаатар	8,203,780.6

НЭГ ХҮНД НОГДОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН ЗАРИМ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ



Эх сурвалж: Үндэсний статисткийн хороо

ФОТО МЭДЭЭ



Батлан хамгаалах салбарын бараа, бүтээгдэхүүний худалдан авалтыг дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр хамтран ажиллах зорилго бүхий санамж бичигт Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон нар гарын үсэг зурлаа. Батлан хамгаалах салбар одоогоор үндэсний 60 гаруй үйлдвэрийн 600 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэж байна. Тиймээс 55 гаруй үйлдвэрийн 500 гаруй нэр төрлийн барааг тус салбарт нийлүүлэх бүрэн боломжтой аж. /2015.01.25/



Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат Улаанбаатар хот дахь зарим үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа. Тодруулбал, "Говь", "Эрэл" асфальт бетоны үйлдвэр, "Хос Аз" гутлын үйлдвэр, "Монгол шевро", "Мон-Ит булигаар", "Монгол нэхмэл", "Мон-Ирээдүй" зэрэг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, үйлдвэрлэгчдийн санал, хүсэлтийг сонсов. /2015.03.05/



Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт ажиллалаа. /2015.03.15/



Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа. /2015.03 сар/



Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үндэсний чуулган" Төрийн ордны Их танхимд зохион байгуулагдлаа. Чуулганд хот, хөдөөд ЖДҮ эрхэлдэг 500 гаруй үйлдвэрлэл эрхлэгчээс гадна төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон юм. /2015.04.14/



Аж үйлдвэрийн яам, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ хамтран "Замын-Үүд чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын чуулган 2015" арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд гадаад, дотоодын нийт 100 гаруй хөрөнгө оруулагч оролцож, санал бодлоо солилцлоо. /2015.04.25/

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлагдлаа. "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого" нь гурван үе шаттайгаар 15 жилийн хугацаанд хэрэгжих юм. /2015.06.19/



Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат "Монгол-Японы Засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан VII зөвлөлдөх уулзалт"-д оролцлоо. /2015.06.25/

Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль батлагдлаа. /2015.07 сар/




-Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь хэмжээг нэмлээ /цемент, шинэ троллейбус, зөгийн бал, бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүн/

-Дотоодоос худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг баталлаа. /Засгийн газрын 336 дугаар тогтоол/

ТҮНШЛЭЛ

Наран мандах зүгээс

Б.Үүрийнтуяа



“Би хувьдаа нэгэн хүсэл мөрөөдлийг тээж явдаг. Япон, Монгол хоёр улсын эдийн засгийн харилцаа нь Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн бүхий л хүчин чадлыг ашиглан өргөжин хөгжөөсэй. Цаашид хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалт, худалдаа эргэлт улам нэмэгдэн, харилцан ашигтай, бие биенээ нөхсөн эдийн засгийн харилцаа тогтож, улмаар Япон, Монгол хоёр улс өөр хэн нэгнээр орлуулашгүй Стратегийн түншүүд болоосой гэж хүсдэг” хэмээн Монгол Улсад суугаа Японы элчин сайд Шимизү Такэнори манай сэтгүүлд өгсөн нэгэн ярилцлагадаа дурьдсан билээ. Түүний сэтгэлдээ тээн явдаг энэхүү мөрөөдлийн нэгээхэн хэсэг нь биеллээ олоход тун ойр иржээ.

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр манай улсын хувьд анхных. Тиймээс нухацтай хандах учиртай гэх. Дээрх хэлэлцээр Монгол Улсад ямар боломж олгох, Японд юугаараа ашигтай талаар олны бодол хэдэн талд хуваагдаж. Тухайлан авч үзвэл хөдөө аж ахуй, уул уурхайд суурилсан эдийн засагтай орны хувьд тус хэлэлцээр Монголын эдийн засагт өнгө нэмэн солонгоруулахаас гадна хөдөө аж ахуй, уул уурхайгаас бусад салбарт ч шууд болон шууд бус нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Тодруулбал, шинэхэн яамаа өлгийдөн авсан аж үйлдвэрийн салбарт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бэлтгэх үйлдвэрүүд, тэдгээрээр дамжуулан ажлын байр шинээр бий болгох, тухайн үйлдвэрт ажиллах чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, улмаар иргэдийн аж амьдралыг дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлэх гэх мэт өнөөгийн Монголд зайлшгүй шаардлагатай буй чухал өөрчлөлтүүдийг бий болгоно гэдгийг холбогдох албаныхан онцолж буй.

Япон улстай үзэглэсэн хэлэлцээрийн “ачаар” хоёр орны хоорондын худалдааны эргэлт 65 хүртэлх хувиар, үйлдвэрлэл болон ДНБ 0.34 хүртэлх хувиар өснө гэх тооцоо гарсныг Аж үйлдвэрийн яамнаас мэдээлсэн.

Түүнчлэн аралын улсаас хөрөнгө оруулалт татах замаар стратегийн ач холбогдол бүхий салбаруудад Японы техник, технологийг дотоодын үйлдвэрлэлд нэвтрүүлэх, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тээврийн зардлыг бууруулахаас гадна хөршүүдийн хараат байдлаас бага ч атугай ангижрах боломж бийг мөн дурьдсан.

Гэвч аливаа зүйл сайнтай, саартай. Хэдийгээр дээрх түншлэлийн хэлэлцээр үндэсний үйлдвэрлэгчдийг импортын өрсөлдөөнөөс хамгаалж чадахгүйд хүрэх, зарим үйлдвэрлэл богино болон дунд хугацаанд уналтад орох, улмаар ажилгүйдэл нэмэгдэх зэрэг тодорхой хэмжээний сөрөг үр дагавар байгаа ч давуу тал түүнээс олон бийг тайлбарлан ойлгуулах нь зүйтэй. Тухайлбал, дэвшилт технологийн үр шимээр шинэ зах зээлд нэвтрэх, үүнд тулгуурлан эдийн засгаа нэг салбараас хэт хараат байхаас хамгаалахын сацуу орлогын олон эх үүсвэртэй болох боломжийг бүрдүүлдэг.

Тэгвэл эерэг үр дүнд хүрэхийн тулд тус төрлийн хэлэлцээр манай улсын хөгжлийн стратегид хэр нийцэж буй, эдийн засгийн хувьд үр ашиг нь хэр өгөөжтэй болох, богино, дунд болон урт хугацаанд бий болох давуу, сул талууд гэх мэт урьдчилан тооцсон байх шаардлагатай. Яг энэ асуудлаар гаргасан тооцооллод дурьдсанаар 2015 он улсын төсвийн орлогод гаалийн татвараас орох орлого 5.5 хувиар буурах бөгөөд бусад шууд болон шууд бус татвар тодорхой хувиар нэмэгдсэнээр төсвийн орлого нийт 0.22 хувиар буурах, 2020 он гэхэд гаалийн татварын орлогод өөрчлөлт гарахгүй бөгөөд нийт татварын орлого 0.16 хувиар нэмэгдэнэ гэжээ.

Эцсийн бүтээгдэхүүнд өртөг шингээн бусад зах зээлд худалдаалах нь улс орны хөгжлийн томоохон түлхэц болдог. Тэгвэл Японы зүгээс манай орны экспорт хийх боломжит салбарыг, уул уурхай, хөдөө аж ахуйгаас гадна, төмөрлөгийн салбар байж болох талаар

онцолсон. Мөн тэдний ихээр сонирхож буй хоёр бүтээгдэхүүнд металлургийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай кокс болон электроникийн үйлдвэрлэлд чухал гэгддэг газрын ховор металл ажээ. Цэвэршүүлсэн зэс, кокс зэрэг бүтээгдэхүүнийг Японы зах зээлд нийлүүлэх боломж нээлттэй гэдгийг ч Аж үйлдвэрийн яамнаас тайлбарласан. Учир нь ийм төрлийн эцсийн бүтээгдэхүүн худалдаалах нь манай улс байгалийн нөөц баялгаа илүү үр өгөөжтэй ашиглах, ажлын байр нэмэгдүүлэх, тээврийн зардал хэмнэх гол арга зам байх аж. Түүнчлэн нийлүүлдэг биш үйлдвэрлэдэг орон болох зорилгын хүрээнд аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт татах замаар эрдэс бүтээгдэхүүний салбарт кластерийг хөгжүүлэх нь чухал алхам болох юм.

Дээрх бүхэн хэрэгжиж, хөрсөнд бууж эхлэхэд шалгуур, сорилтууд биднийг угтаж буй. Японы талаас тавьж буй гол нөхцөл нь Монгол Улсын Гаалийн туухай хууль, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хууль болон Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах.

Энэ асуудал хоёр тал харилцан ноот бичиг солилцоноор урагшилж Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хэрэгжилт нэг алхам ахих аж. Үүний эхлэлийг Аж үйлдвэрийн яам, Сангийн яам энэ оны аравдугаар сарын 5-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар дээрх хуулиудад өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлэн дэмжүүлсэн бөгөөд УИХ-аар эцэслэн хэлэлцүүлэх ажиллаж буй.

Ийнхүү наран мандах зүгээс “найдаж” болох түншлэлийн боломж нээгдсэн. Туршлага дутаж мэдэх ч энэхүү боложийг бодит байдал болгох нь уул уурхайд суурилсан, уналт, сэргэлтийн мөчлөгт хүлэгдсэн манай орны эдийн засгийг нэг биш нэлээд олон гарцтай болгох учиртай. Гагцхүү бүхнийг зөв биш юм аа гэхэд аль болох зөв зохицуулах, шийдвэрлэх, зөв залах зам бидэнд үлдлээ. ■

Өрсөлдөж чадвал хөрөнгөтэй

Ц.Буян

Монгол Улсад хийсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт ДНБ-ний нэг хувьтай л тэнцэж байна. Нэгэн үе 44 хувьтай тэнцэж явсан сайхан цаг бий. Энэ нь манай улсын хөрөнгө оруулалтын орчин хүнд байгааг л харуулж байгаа хэрэг. Нийт хөрөнгө оруулалтын хувьд өнгөрсөн онд нийт 5.5 их наяд хөрөнгө оруулалт хийсний 800 сая орчим нь уул уурхай, 400 сая орчмыг боловсруулах үйлдвэрлэлд зарцуулжээ. Мөн 300 гаруй саяыг цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамжид хөрөнгө оруулсан статистик мэдээлэл байна. Үүний дийлэнх нь улсын хөрөнгө оруулалт буюу төсөв, бондын хөрөнгөөс санхүүжсэн. Багахан хувийг Концессын төслүүд эзэлнэ.

“Монголд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхийгээр нь хил гаргаад урд хөршид үйлдвэрлэхийн аль нь ашигтай вэ гэдэг дээр хөрөнгө оруулагчид сонголт хийж байна” хэмээн Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар ярьсан юм. Товчхондоо бол өрсөлдөх чадварын асуудал. Монгол Улс өнөөдөр хэр аж үйлдвэржсэн орон билээ. 1990 оноос өмнө “Эрдэнэт”, цахилгаан, дулааны хэдэн станц байгуулагдаж тэдгээрийг дагалдан арьс, шир боловсруулах, гутал, оёмол, сүлжмэлийн жижиг үйлдвэрүүд бий болсон. Гэсэн ч 1990 онд зах зээлд шилжихэд өрсөлдөх чадвараар хол хоцорсон тул дийлэнх нь үйл ажиллагаагаа зогсоож, тэнд ажиллаж байсан мэргэжилтнүүд нь ганц, хоёр машинтай жижиг цехийн хэмжээнд тус тусдаа ажиллаж эхэлсэн. Тооны хойноос хөөцөлдсөн төвлөрсөн төлөвлөгөөний алдаа дутагдал үүнд байлаа.

Тиймээс хамгийн чухал асуудал өрсөлдөх чадварыг сайжруулахгүйгээр дан төрийн татаас, санхүүжилтээр аж үйлдвэрийн салбарт тогтвортой хөгжих боломжгүй гэнэ. Тухайлбал, ноос, мах, сүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд олон төрлийн татаас олгож байсан ч дорвитой амжилтад хүрээгүй. Харин байгалиас заяасан өрсөлдөх чадвартай

гэж хэлж болох ноолуур харьцангуй аж үйлдвэржсэн, өнөөдөр экспортын орлогын багагүй хувийг бүрдүүлж байгааг С.Жавхланбаатар жишээ болгосон юм.

Монголын өрсөлдөх чадварыг хамгийн хүчтэй хойш татдаг гурван хүчин зүйл бий аж. Тэдгээр нь дэд бүтцийн хөгжил сул, муу засаглал болон авлига. Адаглаад зам харилцаа муутайгаас тээврийн өртөг өндөр, төрийн бодлого тодорхойгүй бас тогтворгүй, хүнд сурталтай гэдэг нь л Монголд бизнес эрхлэхээс татгалзах шалтгаан. Аж үйлдвэрийн салбарт хийж байгаа хөрөнгө оруулалтыг харахад жижиг, дунд, цехийн чанартай үйлдвэрлэлд л хөрөнгө оруулж байгаагаас биш нэмүү өртгийн сүлжээ бий болгосон хөрөнгө оруулалт муу байгааг С.Жавхланбаатар онцлон тэмдэглэсэн.

Хөрөнгө оруулалтын орчин тийм ч харанхуй болчихоогүй байна. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат “Гадаад хөрөнгө оруулалт татарлаа гэдэг. Энэ нь ямар хөрөнгө оруулалт байсан бэ гэдэгт эргээд анализ хийх хэрэгтэй” гэсэн нь учиртай. С.Жавхланбаатар даргын үзэж буйгаар уул уурхай уналтад орсноор бусад салбарт боломж олдож байгаа. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчид уул уурхайгаас татсан хөрөнгөө шингээчих өгөөжтэй салбар хайж байгаа аж. Ялангуяа дэд бүтцийн шинжтэй хөрөнгө оруулалт гадныхны сонирхлыг ихээхэн татаж байгаа гэнэ.

Тэгэхлээр хөрөнгө оруулагчдын анхаарлыг энэ “зүгт” татах ажлыг зөв хийх хэрэгтэй. Тэд илүү тооцоо, судалгаатай боловсруулсан төсөлд хөрөнгө оруулах сонирхолтой байдаг гэнэ. Тиймээс төсөлд тулгуурласан, тэр нь нэгдсэн бодлого, хөтөлбөртөө нийцсэн байх гэсэн зарчмыг Хөрөнгө оруулалтын газар баримталж байна. Одоогоор энэ бодлогод хамгийн нийцтэй нь Концессын төслүүд байгаа юм. Учир нь тодорхой хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хийсэн байдаг



У цахилгаан станцын концессын гэрээнд Фифт Комбайнд Хийт Энд Пауэр Плантад ХХК-ийн гүйцэтгэх захирал Рибессе Беноут гарын үсэг зурж буй нь

нь хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцдэг байна.

Одоогоор Концессын 15 төсөлд нийт таван тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулаад байна. Эдгээр төслийг хэрэгжүүлэхэд 3-4 жил шаардлагатай. Жилд дунджаар 2-3 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ гэсэн үг. Үүнээс 250 сая ам.долларын замын төсөл хэрэгжээд явж байгаа бөгөөд ирэх онд дуусах аж.

Мэдээж хэрэг том зургаар нь харвал эдийн засаг дахь нийт хөрөнгө оруулалт сэргэх нь салбарын хөрөнгө оруулалтад нөлөөтэй.

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орчныг сайжруулахад ямар ажил хийх хэрэгтэй байгаа талаар хөрөнгө оруулалтын даргаас асуухад тэрбээр “Хоёр зүйл бий” гэсэн юм. Нэг нь санхүүжилтийн тогтолцоог сайжруулах. Хөрөнгө оруулалт орж ирэхэд эрхзүйн орчин бүрдсэн ч санхүүжилтийн хэлбэрийг шийдэх тал дээр дутмаг. Санхүүжилт хийх процесс нь төвөгтэй, ойлгомжгүй. Тиймээс хөрөнгө оруулагчид баталгаа шаарддаг. Гэтэл Монгол Улсын өгч буй баталгаа нь маш сул байгаа аж. Нөгөө нь хууль эрхзүйн талдаа хууль нь засгийн бүх харилцаагаа зохицуулах чадамжтай байх ёстой гэлээ. Хуулийн энэ заалт эдийн засгийн бусад харилцаанд ямар нөлөө үзүүлэх вэ, үүнээс хэрхэн сэргийлж, зохицуулж болох вэ гэдгийг тооцдог байх хэрэгтэй хэмээн тодотгосон юм. ■



НЬЮ ЭКО ЭНЕРЖИ ХХК
NEW ECO ENERGY LLC

Манай уриа: *Түүхий нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн - Өндөр үр ашги*



Хямд түүхий нүүрснээс өндөр үнэтэй
кокс болон цэвэр эрчим хүч үйлдвэрлэнэ.



Монгол улсын аж үйлдвэрийн салбарт
экспортын шинэ төрлийн бүтээгдэхүүн нэмэгдэнэ.



Монголын анхны будагны үйлдвэр "Бэст Пэйнт ХХК"-ийн гүйцэтгэх захирал З.Эрдэнэбат

3.Эрдэнэбат: Сайн чанарын будаг эх орондоо үйлдвэрлэхийг зорьсон

Ц. Бадрал

Монгол Улсад байдаггүй үйлдвэрийг зориглон байгуулж импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа "Бэст Пэйнт ХХК"-ийн гүйцэтгэх захирал З.Эрдэнэбаттай ярилцлаа. Тус үйлдвэр түүхий эдээ гадаадаас импортолдог ч дотоодод эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээрээ онцлог юм.

-Юуны өмнө "АМЭ трейд" компанийн талаар танилцуулна уу. Ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг вэ?

-Манай компани 2008 онд байгуулагдсан. Барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 2014 оноос үйл ажиллагаагаа өргөтгөөд Монгол Улсад анхны будгийн үйлдвэр байгуулаад ажиллаж байна. Одоогоор үндсэн зургаан төрлийн будаг хийж байгаа. Энэ дээр дутагдалтай тал юу байна гэхээр хэрэглэгчид их шаардлага өндөртэй болсон. Тухайлбал, кодоор будгынхаа өнгийг захиалдаг болсон. Монголд бол будаг найруулж өнгө гаргаж авч байна. Аж үйлдвэрийн яамны төслийн дэмжлэг ирэх юм бол кодоор 60-70 өнгө гаргадаг болно.

-Будгийн үйлдвэрлэл Монголд шинэ

салбар. Өнөөдөр танай компанид өрсөлдөгч бий юу?

-Одоогоор манайхаас өөр будгийн үйлдвэр байхгүй. Энэ нь манай улсад химийн болон нефтийн үйлдвэр байдаггүйтэй холбоотой. Тиймээс 100 хувь импортоор будаг худалдаж авдаг.

Гаалийн мэдээгээр жилд 80 орчим сая ам.долларын будаг, будагтай төст бүтээгдэхүүн импортоор орж ирдэг юм билээ. Үүнд лак, шингэлэгч гэх мэт химийн бүтээгдэхүүн багтаж байгаа. Яг нарийн судлаад тогтооход хэцүү. Монгол Улсад зарагдаж байгаа бүх будгийн 80 хувь нь, БНХАУ-аас орж ирдэг. Тэгэхдээ ямар нэгэн чингэлэг, агаарын тэвэрээр тэвэрлэдэггүй. Эрээн-Замын-Үүдийн боомтоор УАЗ-469 машинаар орж ирдэг болохоор нарийвчлан бүртгэж чаддаггүй.

Сүүлийн хэдэн жил хятад будгийн үнэ өсөхгүй, нэг хэмжээнд байгаа нь УАЗ-469 машинаар орж ирж байгаа будгууд нь гаалийн татвар төлдөггүйтэй холбоотой. Чингэлгээр юм уу, том авто машинаар тэвэрлэдэг бол гаалийн татвар төлөх ёстой. Бид Замын-Үүдийн хилийн мэргэжлийн хяналт, гаалийн газрынхантай дөрвөн өдөр ажиллаж үзсэн. Тэнд 600 орчим УАЗ-469 машин

байна. Үүний 60 нь зөвхөн будаг зөөдөг. Оргил үедээ 80 машин болно. Арын суудлаа авчихаад дүүртэл нь будаг ачна. Нэг машин ойролцоогоор хоёр тонныг ачна. Өдөрт 100-120 тонн хятад будаг Монгол Улсад орж ирж байна.

Хилийн мэргэжлийн хяналтынхны хувьд хятад будагны чанар, савлагааг анхаарч үздэг. Даанч дээрх замаар орж ирж байгаа будгийг шалгах аргагүй. Хятад будаг савлагаандаа хүрдэггүй, хүний биед хортой хар тугалганы ялгаруулах хэмжээ их. Гэвч дотоодод үйлдвэр байдаггүй болохоор хориглочихож бас болдоггүй.

Сүүлийн үед хувь хүмүүс солонгос будаг их хэрэглэх болсон. Гарч байгаа үнэр, их талбай будах чанар, найрлагаараа солонгос будаг илүү байна. Үүнд үндэслээд ОХУ-ын үйлдвэрүүдтэй хамтарч ажиллах бус Солонгос технологи, үйлдвэрлэлийг нэвтрүүлж гэж зорьж ажиллаж байна.

-Хүчин чадлын хувьд?

-Үйлдвэрээ БНСУ-ын Сувон хотын "Намъяанг" үйлдвэрээс санаа авч байгуулсан. "Намъяанг" үйлдвэрийн таван жилийн өмнөхтэй ижил хүчин чадалтай. Хоногт 12 тонн будаг

үйлдвэрлэх хүчин чадалтай. Зургаан өнгийн будгийг Солонгос технологи, стандартаар будаг үйлдвэрлэж байна.

-Үйлдвэр байгуулахаасаа өмнө зах зээлээ мэдээж судалсан байх. Яагаад заавал будгийн үйлдвэр байгуулсан юм бэ?

-Бид ашгийг тийм их чухалчлаагүй. Монгол Улсад барилгын салбар нэлээд эрчимжиж, олон тооны барилга баригдаж байна. Гэтэл хамгийн гол нь манайд барилгын материалын хэд хэдэн чухал үйлдвэр огт байхгүй. Нэгдүгээрт, будгийн үйлдвэр, дээвэр хийхэд ордог хар цаасны, плитаны үйлдвэр. Тиймээс судалж үзээд будгийн байгуулах, түүхий эдийг нь дотоодоосоо олборлох боломжтой, зөвхөн химийн орцыг хойд хөршөөс импортлоход болох юм гэж шийдсэн.

Хоёрдугаарт, чанарын асуудал. Хятад будаг хүний биед харшил өгдөг, үнэр ихтэй учраас уушгинд муу гэдгийг иргэд мэддэг болсон. Тийм учраас сайн чанарын будаг эх орондоо үйлдвэрлэдэг болъё гэж зорьсон. Хар цаас, плитаны үйлдвэрийн хувьд нь их том зах зээл хэрэгтэй юм билээ.

-Химийн үйлдвэр байдаггүйгээс будаг үйлдвэрлэж чаддаггүй гэж ярьсан. Тэгэхээр танайх химийн үйлдвэртэй гэсэн үг үү?

-Будгийн хамгийн гол бүтээгдэхүүн шингэлэгч, полестеритол, олиф нь зайлшгүй химийн үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн. Будгийн үндсэн орц, 70-80 хувийг бүрдүүлдэг түүхий эдүүд, шохоон чулууг дотоодоос олборлох боломжтой. Энэ талаар судалж байна. Одоогоор манай үйлдвэр үндсэн түүхий эдээ БНСУ-аас, полистеритол, олифыг ОХУ-аас импортлож байна.

Анх 1984 онд Политехникийн дээд сургуулийн эрдэмтэн багш нар, ШУА-ийн Химийн хүрээлэнгийн эрдэмтэд хамтраад туршиж хийж үзсэн байдаг. Гэхдээ тэр нь зөвхөн хөдөө аж ахуйд л ашиглах боломжтой шороон будаг байжээ. Тэр эрдэмтэд өнөөдөр ч ажиллаж байгаа. Тухайлбал, ШУТИС-ийн доктор н.Батцагаан судалгаагаа үргэлжлүүлж байна. Монгол Улсад таван орд газар байгаа юм. Сүүлд Булган, Дархан-Уул аймагт хоёр орд нэмэгдэж илэрсэн. Манай компани болон АҮЯ-наас энэ үйлдвэрлэлд ойрын үед тавьж байгаа зорилго бол түүхий эдээ дотоодоосоо

олборлох.

-Эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн, үүнээс улбаалаад барилгын салбарын өсөлт ч удааширч байна. Ийм нөхцөлд энэ салбарт үйл ажиллагаа явуулах нь хэр ирээдүйтэй гэж харж байна вэ?

-Хямрал, хүндрэл хоёр жил орчим үргэлжлэх болов уу. Цаашдаа өсөлт үргэлжилнэ гэж харж байна. Будагны хувьд барилгын салбар гэлтгүй өөрөө их өргөн хэрэглээний бүтээгдэхүүн. Айл өрх, албан байгууллагууд жил бүр засвар хийдгээс эхлээд уул уурхай, эрчим хүч зэрэг томоохон үйлдвэрийн техникийг зэврэлтээс хамгаалах зорилготой гэх мэтчилэнгээр будагны хэрэгцээ их. Тийм ч учраас тэд дотоодын бүтээгдэхүүнийг их сонирхож байгаа. Дотооддоо үйлдвэрлэж байгаагийн хувьд чанартай, үнэ боломжийн байх хэрэгтэй.

-Хөрөнгө оруулалтаа яаж шийдсэн бэ?

-100 хувь өөрийн хөрөнгөөр байгуулсан. Үйлдвэрт 4.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Тонг төхөөрөмжөө өргөтгөх, будгийн лаазны үйлдвэр оруулж ирэхийн тулд АҮЯ-нд хандсан. Яамны мэргэжилтнүүд судлаад явж байгаа. Лаазны үйлдвэр нь бас Монголд огт байхгүй. Лаазаа БНХАУ-аас худалдаж авсан. Тэгэхдээ зөвхөн 20 кг савлагаатайгаар зах зээлд нийлүүлсэн. Хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй байхын тулд 0.5-18 кг хүртэл янз бүрийн савлагаатай будаг үйлдвэрлэх хэрэгтэй. Тиймээс лаазны үйлдвэр байгуулахын тулд улсаас хөнгөлттэй зээл хүсч байгаа юм.

Лаазны үйлдвэртэй болчихвол зөвхөн будгийн үйлдвэрлэлээр хязгаарлагдахгүй. Бүх төрлийн лааз үйлдвэрлэх боломжтой. Жишээлбэл, манай улсын нефть, тос тослогооны материал импортлодог компаниуд мөн л лаазны үйлдвэр байдаггүйгээс хуванцар савтайгаар нь бүтээгдэхүүн оруулж ирдэг.

Ийм үйлдвэр ашиглалтад орох юм бол эдгээр компани бүтээгдэхүүнээ бөөнөөр худалдан авч, түүнийгээ өөрсдөө жижиглэнгээр савлаж хэрэглэгчдэд хүргэх боломжтой болно. Түүний хэрээр нэгж бүтээгдэхүүний өртөг буурах ач холбогдолтой.

-Танай үйлдвэрлэж буй будаг үнэ ханшийн хувьд хэр өрсөлдөх чадвартай вэ?

-Солонгос будагнаас 30 хувь хямд, орос будагтай ойролцоо, хятад будагнаас арай үнэтэй. Дотоодод түүхий эдээ боловсруулдаг үйлдвэр нь гараад ирвэл хятад будагтай жишиж очно. Үнэр, чанар хамаагүй илүү учраас давуу талтай. Дотоодын зах зээлийн 40 хувийг хангах боломжтой гэж харж байгаа.

-Импортыг орлох бүтээгдэхүүн хийж эхэлсэн үйлдвэрлэгч хүний хувьд аж үйлдвэрийн салбарын ирээдүйг хэрхэн харж байна вэ?

-Анх удаа Аж үйлдвэрийн яам байгуулагдлаа. Гадаадын олон улсын туршлагаас харахад манайх шиг ихэнх бүтээгдэхүүнээ импортлодог улс хөгждөггүй нь тодорхой байна. Хамгийн сайн жишээ БНСУ. Жижиг, том, дунд гэж ялгалгүй бүгдийг нь дэмжиж ирсэн учраас өнөөдөр хөгжлийн энэ хэмжээнд ирсэн.

Яам байгуулагдсанаар үйлдвэрүүдээ их дэмжиж байгаа. Харин дотоодын үйлдвэрлэгчид энэ дэмжлэгийг чанартай, боломжийн үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ард иргэддээ хүргэж байвал улсын хөгжилд их хувь нэмэртэй. Яам зөв бодлого хэрэгжүүлж байна. Эхэндээ хүнд байж болно. Үйлдвэрүүд тодорхой хугацааны дараа хөл дээрээ тогтчихвол асуудалгүй болно. Үйлдвэрлэгчид хоорондоо уялдаатай ажиллаж, нэгнийхээ дутууг нөхөж ажиллаж гэж ярилцсан. Том зорилго тавьж ажиллаж буй болохоор их сайхан ирээдүй харагдаад байгаа. Хөгжлийн хамгийн зөв зам аж үйлдвэрийг хөгжүүлэх юм. ■



Бэст Пэинт будаг солонгос будагнаас 30 хувь хямд, орос будагтай ойролцоо, хятад будагнаас арай үнэтэй.

 **YAMAHA**
Revs Your Heart

TOTAL MOTORS

DELIVERING WORLD STANDARD

АЛБАН ЭСНЭ ДИСТРИБЬЮТОР

**YXZ
1000R**



УРЬДЧИЛСАН ЗАХИАЛГА

Yamaha YXZ1000R

- 998сс, 3 цилиндр бүхий 5 шатлалт механик дамжуулагчтай цэвэр спорт UTV
- FOX® 2.5 Podium RC2 Shocks® амортизатор



Хаяг: Баянзүрх дүүрэг 8-р хороо Амгалан, Улаанбаатар
Утас: 98981060, 98981020. Вэб хуудас: www.totalmotors.mn
www.facebook.com/totalmotorsmongolia

ХҮНИЙ НӨӨЦ

Хөгжлийн хөдөлгүүрийн тухайд цухасхан

Ц.Элбэг



Аж үйлдвэрийг хөгжүүлэе! Тийм ээ, аж үйлдвэржсэн орон болохыг монголчууд олон жилийн турш хүсч, зорьж ирсэн. Том зорилт, зорилго. Ямар ч байсан энэ салбарт төрөөс баримтлах бодлогыг нь УИХ-аар батлаад тогтоогоод өгчихсөн, эхний ээлжийн томоохон үйлдвэрүүд үйл ажиллагаагаа эхэлчихсэн. Гэхдээ нэг үйлдвэр, нэг байгууллагыг хөгжүүлэх тухай бус нийт салбарын хөгжлийн тухай ярихад хөндөггүй өнгөрч болохгүй зүйл нь хүний нөөц. Аж үйлдвэрийг хөгжүүлэхэд хэн нэгэн хүн, аль нэг яам дангаараа хийх ажил биш. Эцсийн дүндээ чадварлаг, технологийг нь эзэмшсэн боловсон хүчин салбарын гол “хөдөлгүүр” билээ.

Тийм ч учраас “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын бичигт “Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын бичигт “өндөр технологийн салбарын хүний нөөцийн бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх” гэх зэргээр тодорхой заасан бий. Монгол Улсын их, дээд сургуулиудыг жил бүр 40 мянга орчим оюутан төгсөн гарч байгаагийн 4000 хүрэхгүй нь инженер мэргэжилтэн болон бэлтгэгдэж байна.

Япон-Монголын хамтын ажиллагааны үр дүнд 1000 инженерийг арлын улсад сургахаар болсон. Үндсэндээ тэд бол аж үйлдвэрийн салбарыг ирээдүйд авч явах, өвлүүлэх асар их нөөц мөн. Харин одооноос тэргүүлэх аж үйлдвэрээ тодорхойлж, бодлогынхоо хүрээнд ямар чиглэлийн инженерийг хэдийг бэлтгэх вэ, тэд ирээд хаана ажиллах

вэ гэдийг нарийн тооцох шаардлага байгаа юм. Ерөнхийдөө Аж үйлдвэрийн яамнаас мэргэжилтэн бэлтгэх тал дээр хэрэгжүүлэх үндсэн хоёр бодлого бий. Нэгдүгээрт, үндэсний болон гадаадын их, дээд сургуулиудад оюутан сургах. Тэдэнд Засгийн газрын болон бусад тэтгэлгийг олгох замаар дэмжлэг үзүүлнэ. Хоёр дахь нь ноу-хау эзэмшсэн хүмүүсийг дэмжих, тэднийг ажиллах боломжийг олгох. Гадаадад тухайн технологи дээр нь ажиллаад сурчихсан, технологио эзэмшсэн иргэдийг эх орондоо ирж хөдөлмөрлөх боломжийг хангаснаар хүний нөөцийн асар өргөн фронт бийг Аж үйлдвэрийн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Баттогтох хэлж буй. Монгол Улсад эдийн засгийн идэвхтэй 1.2 сая иргэн байдаг. Харин тэдний 10 орчим хувь нь буюу 120 гаруй мянга нь дэлхийн 80 гаруй оронд хөдөлмөрлөж байгаа аж. Тэд эх нутагтаа иргэж ирэхдээ ноу-хау, технологийг хамт нэвтрүүлж байдаг аж. Жишээ нь, “Санко Соолар Монголиа” ХХК-ийн захирал С.Хүрэлбаатар яг ийм үлгэр жишээг үзүүлж яваа нэгэн. Тус компани нарны зайн дэлгэц үйлдвэрлэж “Монголд үйлдвэрлэв” шошготойгоор Япон улсад нийлүүлдэг. Өнөөдөр энэ компани бүтээгдэхүүнээ “Чоно” хэмээн нэрлэн тус улсад нийт есөн МВт хүчин чадал бүхий дэлгэц экспортлосон амжилттай. Түүгээр зогсохгүй Японд хоёр МВт хүчин чадалтай нарны эрчим хүчний станц байгуулжээ.

Зөвлөлт тогтолцоо задран унахаас өмнө Монгол Улс олон сайн оюуны уурхайгаа хойд хөршид, одоо бидний хэлээд байгаа өндөр технологийн гэгдэх

нефтийн, нисэх онгоцны инженер гэх мэт нарийн мэргэжлээр сургасан байдаг. Харамсалтай нь, тэднийг ид хийж бүтээх хүслээр тэмүүлэн эх орондоо буцан ирэхэд нь сурсан эрдэм чадварыг ашиглая гэвч технологи нь нэвтэрч чадаагүй байсаар нийгмийн шилжилтийн ороо бусгаа үетэй золгосон билээ.

Аж үйлдвэрийг хөгжүүлэхэд технологи нэвтрүүлэх, бий болгох зайлшгүй шаардлагатай. Өнөөдөр нэгэнт туршаад үр өгөөж нь мэдэрсэн технологийг бид дахиж хийх гэж оролдох нь цаг, хөрөнгө үрсэн ажил болно. Харин тэр технологийг зөв сайн нутагшуулах тухай ярих нь зөв. Магад үүнийг хамгийн сайн хийж чадах нь хилийн чанад дахь “фронтынхон” л болов уу. Гэхдээ үндэсний брэнд технологитой, түүнийг бий болгох шаардлага байгааг Д.Баттогтох дарга сануулж буй. Бид одоог хүртэл ямарч технологийн агууламжгүй, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлээ ч үгүй байна.

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн гуравдугаар зүйлд “Бодлогын зорилго нь дэвшилт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино” хэмээн ганцхан зүйл заалтаар тодорхой хэлжээ. Өндөр технологийг эзэмшиж, өндөр технологийн зах зээлд нэвтэрч, технологийн экспортлогч болох нь эцсийн зорилго гэж болох юм. Ингэж чадвал улсын хөгжил зогсолтгүй хэмнэлд орж, Монгол Улс хөгжингүй орнуудын эгнээнд хөл тавих ч ойрхон буй за. ■

Мөрөөдлийн ЧИМЭЭ

Э.Зоригт

Зах зээлийн сургаар навс унасан нэг салбар бол яах аргагүй аж үйлдвэрийн салбар. Ийнхүү зоримог хэлж байгаагийн учир нь хэвийн ажиллаж байсан үйлдвэрүүдийг хувьчилж, ажилчид нь “гудамжинд гарсан”. Тэдний нэг жишээ нь тухайн нийгмийн үед гутлын үйлдвэрт ажиллаж байсан Ш.Эрдэнэбат юм. Тэр өдгөө “Дэнжийн 1000”-д гутал засварын газар ажиллуулж сууна. Ш.Эрдэнэбат “Миний мэдэх олон сайн гутлын мастер хог дээр гарч, ихэнх нь эрхэлсэн ажилгүй архичин болсон. Зарим нь над шиг гутлын өсгий хадаад хэдэн цаас зулгааж байна. Уг нь бид чинь урдаас гутал авах биш өөрсдөө үйлдвэрлээд байж чадах үйлдвэр, боловсон хүчинтэй байсан юм шүү дээ” гэв.

Өмнөх нийгэмд байсан хүнд, хөнгөн үйлдвэрүүд хаалгаа барьснаар монголчууд гар хоосон ардчилалтай золгож, 25 жилийн дараа “Монголчууд хадаас үйлдвэрлэлээ” хэмээн баярлаж сууна. Уг нь үйлдвэрлэдэг байсан шүү дээ. Гэтэл одоо үйлдвэрлэгч орон болохыг мөрөөдөж сууна.

Эдийн засгийн уналтаас гарах богино, дунд, урт хугацааны олон төлөвлөгөө Засгийн газар, УИХ гаргасан. Түүний нэг нь аж үйлдвэрийн салбарыг дэмжих, тэр дундаа аж үйлдвэрийн парк байгуулах юм. Хэрвээ аж үйлдвэрийн парк байгуулж чадвал монголчууд ямар ч үед модоо барихгүй. Модоо барихгүйн тулд уг нь нэлээн дээрээс л аж үйлдвэрийн парк байгуулахаар зорьж ирсэн юм билээ. Тухайлбал, Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл 2003 онд, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль 2009 онд тус тус баталсан байдаг аж. Гэтэл үндсэн чиглэл болон хуулийг хэрэгжүүлэх ажил удаашралтай явж иржээ. Энэ нь үйлдвэрлэл, технологийн паркийн тухай ойлголт нийгэмд төлөвшөөгүй, парк



БНХАУ-ын ШУӨЗО-ны Хоргос боомт дахь аж үйлдвэрийн паркийн төлөвлөлт

байгуулахаар төлөвлөсөн газруудад дэд бүтэц хөгжөөгүй, хөрөнгө оруулалтын бодлого тодорхой бус, паркийн зохион байгуулалтаар ажиллах үйлдвэр, аж ахуйн газруудын технологийн түвшин сул, хуулийн зохицуулалт бүрхэг байсантай холбон аж үйлдвэрийн салбарын бүтэлгүйтлийг тайлбарладаг.

Мөрөөдөл биелэх сураг

Шинэчлэлийн Засгийн газар “эмхлэгдсэнийхээ” маргаашнаас л Сайншандыг аж үйлдвэрийн паркттай болгоно хэмээн амалж, эдийн засгаа аврахаар болсон. Гэтэл хямралын сургаар тэр парк нь сураг алдарсан. Сураг алдарсан шалтгааны талаар Аж үйлдвэрийн яамны Чөлөөт бүсийн хөгжил, аж үйлдвэрийн паркийн хэлтсийн дарга Б.Чимэгсанаа “Сайншандын хувьд Төрийн өмчийн хорооны 2013 оны 107 дугаар тогтоолоор “Сайншанд Аж үйлдвэрийн цогцолбор” ХХК-ийг байгуулсан. Төрийн өмчийн хороо энэ оны есдүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанаар компанийн нэр болон дүрмийг шинэчлэн баталсан. Одоогийн байдлаар аж үйлдвэрийн цогцолборын суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө болон суурь судалгаанууд хийгдсэн. Цаашид дэд бүтцийн ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлээр ажиллаж байна” гэв. Түүний хэлснээс үзэхэд Сайншандын аж үйлдвэрийн паркийн ажил нүдэнд харагдаж гарт баригдах тал дээр ахицгүй

байгаа ч урагшилж байгаа юм байна.

Өөр нэг сайн мэдээ гэвэл үйлдвэрлэгч болох мөрөөдөлтэй монголчууд зөвхөн зүүн урд зүгт саравчлан аж үйлдвэрийн паркийн утааг хүлээх шаардлагагүй гэнэ. Учир нь Аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого болон “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хуульд үйлдвэржилтийг маш тодорхой дэмжжээ. Тэр бүү хэл Монголын өнцөг булан бүрт аж үйлдвэрийн паркийг төрөл төрлөөр нь барихаар зурагласан аж. Аж үйлдвэрийн яамны сайд Д.Эрдэнэбат “Засгийн газраас таван байршилд аж үйлдвэрийн парк байгуулах зөвшөөрөл олгосон. Аж үйлдвэрийн яам байгуулагдсанаас хойш “Эрдэнэт технопарк” ХХК, “Дарханы Үйлдвэр технологийн парк /ҮТП/, Өмнөговь аймгийн “Баянговь нутаг” ҮТП-ийн удирдлагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээ байгуулснаар Эрдэнэт, Дархан, Өмнөговь аймгийн “Баянговь нутаг” үйлдвэр, технологийн паркийн үйл ажиллагааг эхлүүлж, паркт шинэ техник технологи, инноваци нэвтрүүлнэ. Мөн дэд бүтцийн бүтээн байгуулалтад гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, паркийн нэгжүүдийг кластераар хөгжүүлэх, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр ажиллаж байгаа” гэсэн юм.

Түүнчлэн хөдөөгийн сум бүр өөрийн гэсэн аж ахуйтай, хөдөө аж ахуйн түүхий эдээ боловсруулахыг эрмэлздэг.

Иймд сумдын онцлогт тохирсон хөдөө аж ахуйн парк байгуулах нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй хэмээн салбарын яамны сайд, дарга нар үзэж байгаа гэсэн. Эхний ээлжинд Архангай аймгийн Эрдэнэмандал, Булганы Хутаг-Өндөр, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Төв аймгийн Жаргалант, Баянчандмань сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сэлэнгийн Мандал, Хөвсгөл аймгийн Хатгал тосгон зэрэг суманд концессийн гэрээгээр Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах уралдаант шалгаруулалтыг зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар Хөрөнгө оруулалтын газартай хамтран ажиллаж байгаа юм байна.

Мөн салбарын яамнаас Аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд стратеги бодлого, төлөвлөлт, аж үйлдвэрийн байршлын зураглалыг боловсруулжээ. Удахгүй Засгийн газраар хэлэлцүүлж, батлуулах төлөвлөгөөтэй байгаа гэнэ. Энэхүү зураглалд ойрын жилүүдэд байгуулагдах аж үйлдвэрийн паркийн байршлыг тодорхойлсон аж. Үүнд, Улаанбаатар, Ховд, Чойр, Дорнод гэх мэт газрууд багтсан аж.

Дээрээс нь хууль эрхзүйн зохицуулалтаар татварын болон бусад төрлийн дэмжлэгийг аж үйлдвэрийн салбарыг өөд татах хэн бүрт үзүүлэхээр болжээ. Тухайлбал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг улсаас олгоно гэжээ. За тэгээд өндөр үр ашиг бүхий дэвшилт болон өндөр технологи бий болгон, нэвтрүүлж, нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгоно. Экспортын үйлдвэрлэлийг экспортын санхүүжилтийн төрөл бүрийн арга хэрэгсэл, түүний дотор факторингийн (бусдын авлагыг худалдан авах) үйлчилгээг хөгжүүлэх замаар дэмжинэ гэх мэт олон сайхан заалт шинэ хууль, бодлогын баримт бичигт тусгажээ. Тиймээс монголчууд зөвхөн Сайншандын тийш бус дөрвөн зүг,

найман зовхист үйлдвэрийн утаа хэзээ гарахыг саравчлан харах боломжтой болжээ гэсэн үг.

Чөлөөт бүс бол боломж

Үйлдвэржилтийг дэмжихийн тулд зөвхөн парк байгуулаад болчихгүй. Өөр нэг чухал зүйл бол чөлөөт бүс юм. Энэ талаар Аж үйлдвэрийн яамны Чөлөөт бүсийн хөгжил, аж үйлдвэрийн паркийн хэлтсийн дарга Б.Чимэсанаагаас тодрууллаа.

-Чөлөөт бүсийн тухай хууль шинэчилэн батлагдсан. Энэ талын хууль шинэчлэгдсэнээр үйлдвэрлэгчдэд ямар ашигтай вэ?

-Энэ хууль өмнөхөөсөө олон давуу тал, өөрийн гэсэн онцлогтой. Өмнөх хууль бол захиргааны шинжтэй, зарим зохицуулалт бүрхэг, бусад хуультай уялдаа муутай байсан. Харин шинэчлэн батласан хууль бол эдийн засаг, бизнесийн харилцааг өргөн хүрээнд зохицуулсан, бизнесийг дэмжсэн, маш нээлттэй болсон. Тухайлбал, өмнөх хуульд худалдааны, эдийн засгийн, аялал жуулчлалын чөлөөт бүс гэх мэтчилэн хэлбэрийг хатуу хуульчилсан байсан юм. Улмаар худалдааны чөлөөт бүсэд зөвхөн худалдан борлуулах, бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг сайжруулахаас өөр үйл ажиллагаа явуулах боломжгүй зохицуулалттай байв. Тэгвэл энэ удаад бид чөлөөт бүсийг хэлбэрийн хувьд нээлттэй байхаар зохицуулж өгсөн. Өөрөөр хэлбэл, хэлбэрийн хувьд ангилж хуульчлаагүй. Мөн чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ өргөжсөн. Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд худалдаа, үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээ, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болно. Тиймээс чөлөөт бүс бол хүн бүрт нээлттэй бизнесийн боломж бүхий талбар юм.

Төрөл бүрийн хөнгөлөлт олон байгаа гэсэн. Энэ талаар дурьдахгүй юу?

-Чөлөөт бүсэд үйлчлэх тусгай дэглэмийг маш сайн хуульчилж өгсөн. Тусгай дэглэм бол хөнгөвчилсөн зохицуулалт гэсэн үг. Түүнчлэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгасан. Тухайлбал, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжийг үл хөдлөх

хөрөнгийн татвараас бүрэн чөлөөлж байгаа. Тухайн бүсэд хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх боломжтой.

Мөн эрхлэх үйл ажиллагааных нь чиглэлээс хамааран газрын төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэхээр заасан. Тухайлбал, зочид буудал, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийг газрын төлбөрөөс таван жил бүрмөсөн чөлөөлөөд, дараагийн гурван жилд нь 50 хувиар хөнгөлөхөөр тусгасан байх жишээтэй.

Харин үйлдвэрлэл, дэд бүтцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг эхний 10 жилд газрын төлбөрөөс бүрэн чөлөөлөхөөр заасан. Хилийн чанадаас чөлөөт бүсэд импортолж байгаа бараа ямарч татваргүй орно. Экспортын чиглэлээр чөлөөт бүсээс гарч байгаа бараанд татвар ногдуулахгүй. Чөлөөт бүс дотор үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгдөх татварын таатай нөхцөл бүрдсэнээрээ онцлогтой. Ийм таатай орчинд үйлдвэрлэл хөгжихгүй байна гэсэн ойлголт байхгүй. Тиймээс энэ талын хуулиа судлаад аж ахуйн нэгжүүд чөлөөт бүсэд үйл ажиллагаагаа эхлүүлэх хэрэгтэй. Ингэж чадвал монголчууд бүтээгч болж чадна.

-Хэрэгжилтийн талаар мэдээлэл өгнө үү?

Хууль хэрэгжээд зургаан сар гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд чөлөөт бүсэд мөрдөх дүрэм, журмыг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албадын бүтэц, зохион байгуулалтыг шинэчилсэн. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах нэгдсэн тохиролцоонд хүрсэн. “Замын-Үүд”, “Алтанбулаг” чөлөөт бүсийн дэд бүтцийн ажлыг Концессын зүйлийн жагсаалтад оруулсан бөгөөд зарим ажил Концессоор хийгдэж байна. Хуулийг сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт зэрэг арга хэмжээ зохион байгуулснаар “Замын-Үүд”, “Алтанбулаг” чөлөөт бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. ■



Д.Эрдэнэбаяр /Аж үйлдвэрийн яамны
Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын
хэлтсийн дарга /

Монголын органик нэрийн бүтээгдэхүүнийг экспортолно

Засгийн газрын 2015 оны 133 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк” барих төсөл хэрэгжүүлэх шийдвэр гарсан.

Монгол Улсын эдийн засгийн голлох хөдөө аж ахуйн салбарын хувьд жил бүр арьс, шир, ноос, ноолуур, мах, сүү зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эдийг ихээхэн хэмжээгээр бэлтгэдэг хэдий ч дийлэнх хэсгийг нь ангилан ялгалт, хадгалалт муугаас гадна боловсруулалтгүйгээр экспортлож байна. Ийнхүү малын гаралтай үйлдвэрлэлийн түүхий эд стандартын шаардлага хангахгүй байгаа гадна, тарьсан хүнсний ногоо, үр, тариаг хадгалах томоохон хэмжээний агуулах, зоорь дутагдалтайгаас иргэд, аж ахуйн нэгжүүд ургацаа зах зээлийн үнээс доогуур борлуулж ашиггүй ажиллаж байна.


“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк” нь хөдөө аж ахуйн нөхөн сэргээгддэг баялагт тулгуурласан хөнгөн, хүнсний боловсруулах үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрүүд түүхий эд, бүтээгдэхүүнээ бэлтгэж, цуглуулах тогтолцоог бүрдүүлэх, орон нутаг дахь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын түвшинд хүргэж, дунд болон урт хугацаанд Монголын гэсэн органик-нэрийн бүтээгдэхүүнийг олноор бий болгох,

дотоодын хэрэгцээг хангаж цаашлаад экспортлох зорилготой юм.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг нэг цэгт төвлөрүүлэн, жилийн турш тасралтгүй боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хадгалах, тээвэрлэх, борлуулах байнгын тогтолцоог бүрдүүлж, хөдөө аж ахуйн салбарын улирлын чанартай үйлдвэрлэлийн сул талыг арилгаж, ажлын байрыг нэмэгдүүлэх. Нөгөөтэйгүүр төрийн дэмжлэг, зохицуулалт, үйлдвэрлэл эрхлэгчдийн хөрөнгө оруулалтыг нэг цэгт төвлөрүүлэн, хамтран ажиллаж үйлдвэрлэлээ өргөтгөх, ашиг орлогоо нэмэгдүүлэх, олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг олгон кластер хэлбэрээр хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк” чухал үүрэг гүйцэтгэнэ.

Тус парк нь

- Мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах бүс,
- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах бүс,
- Хүнсний ногоо хадгалах, боловсруулах бүс,
- Хөнгөн үйлдвэрлэлийн бүс гэсэн дөрвөн бүсээс бүрдсэн, бие даасан инженерийн хангамжтай, 20 гаруй барилга,



байгууламжтай цогцолбор байх юм.

Эхний ээлжинд хүн ам олонтой, зах зээлийн багтаамж сайтай, дэд бүтэц, тээвэр, логистикийн сүлжээнд ойр, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааны хувьд ойролцоох суурингууддаа нөлөөлөл үзүүлж чадахуйц хэмжээний 5000-гаас дээш хүн амтай 40 орчим томоохон суурин газар байгуулахаар төлөвлөж байна.

Тус паркийн бүтээн байгуулалтын ажлууд дэд бүтэц, үйлдвэр, цехүүдийг барих ажлыг боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний хэмжээний томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, мэргэжлийн холбоод Концессын хэлбэрээр өөрсдийн хүч хөрөнгөөр барьж байгуулан ашиглах боломжтой гэж үзэж байна. Орон нутаг нь үндэсний үйлдвэрлэгчидтэй хоршин түүхий эд ханган нийлүүлж, кластерийн тогтолцоонд шилжин ажиллах бөгөөд цаашдаа тодорхой хувийг орон нутгийн үйлдвэрлэгчид эзэмших боломжтой болно.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр дараах бодитой үр дүн гарах юм.

Үүнд:

- Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, ногоон технологид суурилсан экспортын бармжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерууд хөгжиж, мах, сүү, арьс шир,

ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын хэмжээ нэмэгдэж боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь, хэмжээ өснө

- Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий монгол нэрийн бүтээгдэхүүнүүд бий болж, экспортын бүтэц сайжирч, гадаад худалдааны тэнцэлд эергээр нөлөөлнө.

- Олон улсын шилдэг техник, технологи Монголд нутагшин, бүтээгдэхүүний технологийн агууламж нэмэгдэнэ

- Хөдөө аж ахуйн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын логистикийн нэгдсэн сүлжээ боловсронгуй болж, байгальд халгүйгээр хадгалах, савлах технологи хөгжинө

- Хөдөө аж ахуйн болон хүнсний үйлдвэрүүдийн төлөвлөлт, зураг төсөл боловсруулах, инженерийн дэд бүтцийг барих олон улсын ногоон хөгжлийн стандартыг хангасан шилдэг туршлагауд нэвтэрнэ.

- Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал, хаягдал багатай үйлдвэрлэл, эрүүл хэрэглээ хөгжинө

- Ажлын байрууд шинээр нэмэгдэн иргэд орон нутагтаа үйлдвэрлэл эрхлэн суурьшин сайхан амьдрах сонирхол бий болж, амьдралын түвшин сайжрах болно. ■



- СЭТГЭЛД ХҮРСЭН ЭХ БЭЛТГЭЛ ДИЗАЙНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
- СҮҮЛИЙН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ
- ӨНДӨР ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- ЧАНАРТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН, СОЁЛТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ

**БРОШҮР, ТАРААХ
МАТЕРИАЛЫН ХЭВЛЭЛ**

Бидний амжилт үйлчлүүлэгчдийн
сэтгэл ханамжаар хэмжигдэнэ.

**ЗӨВХӨН
ДАВАА ГАРАГТ**

**20%
ХЯМДРАЛТАЙ**

**ХҮРД
ЧАНАР**

📞 976-11-459790

📠 976-11-459790

✉ info@selengepress.mn

🌐 www.selengepress.mn



ХӨТӨЛИЙН "ЦЕМЕНТ-ШОХОЙ" ХК

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧ

ТАНИЛЦУУЛГА

Хөтөлийн "Алтан гадас" одонт "Цемент-Шохой" ХК-ийн түүхийн хуудас 1980-аад оноос эхэлдэг. Хуучнаар ЗХУ-ын зураг төслийн дагуу, тус улсын техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон нойтон аргын үйлдвэр жилд 500 мянган тонн цемент, 65 мянган тонн шохой, 162 мянган Гкал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай байгуулагдсан. 2014.05.14-нд 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай хуурай технологийн үйлдвэр ашиглалтанд орсон.

ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХҮЧИН ЧАДАЛ

Цемент: 1,000,000 тонн
Шохой: 65,000 тонн
Дулаан: 162,000 Гкал



Орчин үеийн тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC 17025:2007) стандартын шаардлага хангасан итгэмжлэгдсэн лабораторид түүхий эд болон бүтээгдэхүүнээ шинжлэн дараах нэр төрлийн өндөр чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

ЦЕМЕНТ 42.5

Цемент: OPC42,5 15%, PC42,5 MNS 974:2008 цементийг зам, барилгын бүх салбарт; PC52,5 MNS 974:2008 ангиллын цементийг Хөтөлийн төмөр бетон дэрний үйлдвэр болон автозамын компаниудад нийлүүлж байна.



ШОХОЙ

Шохой: 70%-иас дээш идэвхжилтэй, 0-120мм ширхэглэлтэй шохой үйлдвэрлэж Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, хөнгөн болон эрдэс бетоны үйлдвэрүүдэд нийлүүлдэг.



Шинжилгээний үзүүлэлт		Хэмжих нэгж	MNS-974:2008 Стандартын зохих үзүүлэлт	Үзүүлэлт
Барьцалдах хугацаа	Эхлэх	цаг/мин	45 минутгаас багагүй	2 цагаас багагүй
	Дуусах	цаг/мин	10 цагаас багагүй	3,5 цаг хүртэл
Нунтаглалт	№008 шигшүүр дээрх үлдэгдэл	%	10 хүртэл	9%
Цементэд агуулагдах хүхрийн ангидрид /SO ₂ /		%	3.5 хүртэл	2%
Магнийн ислийн хэмжээ /MgO/		%	5 хүртэл	0.5%
Эзэлхүүний өөрчлөлт			Өөрчлөлтгүй байх	Өөрчлөлтгүй
Цементийн бат бэх 3 хоногт	Гулзайлт	МПа	3.5-с багагүй байх	4.0
	Шахалт		17-с багагүй байх	17-22
Цементийн бат бэх 28 хоног	Гулзайлт	МПа	6.5-с багагүй байх	6.5-8.0
	Шахалт		42.5-с багагүй байх	42.5 дээш
Цементийн хувийн цацраг идэвхийн тун		Бк/кг	370	65
Хувийн гадаргуу		см ² /г	-	3000-4000
Чулуунцрын эрдсийн бүрэлдэхүүн		%	C ₂ S/55-65/, C ₃ S /15-20/, C ₄ A /7-10-14/	10/, C ₄ AF


ХОЛБОО БАРИХ

70368151, 70368672
www.khutulcement.mn
info@khutulcement.mn



Монгол улс, Сэлэнгэ аймаг,
Сайхан сум, Хөтөл

[Twitter](#) [Facebook](#) [YouTube](#) [Instagram](#) /khutulcement



АЖ ҮЙЛДВЭРИЙН ЗУРАГЛАЛ

Д.Баттогтох: Судалгаанд үндэслэн аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглалыг гаргасан



Х. Өнөржаргал

Монгол Улс анх удаа аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, зураглалтай болжээ. Энэ талаар Аж үйлдвэрийн яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга (PhD) Д.Баттогтохтой ярилцлаа.

-Монгол Улс анх удаа аж үйлдвэрийн хөгжлийн бүсчлэлийг тодорхойлсон зураглалтай боллоо. Энэ талаар тодруулахгүй юу?

-Аж үйлдвэрийн яам байгуулагдсанаар үйлдвэрлэлийн нэгдсэн бодлогыг тусгайлан авч үзсэн. Өмнө нь үйлдвэрлэлийн бодлогын асуудал яамдын бүтцэд салбар, салбараараа хуваагдаж багтсан байсан. Харин манай яам байгуулагдсанаар бүтцийн хувьд салангид байсан асуудлыг нэгтгэж, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Чөлөөт бүс, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль болон бусад эрхзүйн орчинтой холбоотой өөрчлөлт, шинэчлэлтийг хийсэн. Мэдээж бодлого бол судалгаа, шинжилгээнд үндэслэгдэх ёстой. Энэ утгаараа салбарын эрдэмтэн судлаачид, мэргэжлийн холбоодоос бүрдсэн ажлын хэсэг байгуулж, аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, дэд бүсүүдийг гаргаж ирсэн. Энэ ажил нь шинжлэх ухаан, судалгаанд үндэслэн хийсэн аж үйлдвэрийн төлөвлөлтийн томоохон ажил болсноороо онцлог юм.

Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, зураглалын хүрээнд үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, байршил, төлөвлөлтийг анх удаа орон зайн горимд оруулан тооцож мэдээллийн бааз үүсгэсэн байгаа. Товчхондоо энэ ажил нь салбарын урт хугацааны бодлогын суурь мэдээлэл, бааз болохоос гадна төрөөс хаана, ямар чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх боломжтой талаарх

мэдээллийг өгөх юм.

-Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг ямар аргачлалаар тодорхойлсон бэ?

-Аргачлалын хувьд хосолмол аргыг хэрэглэсэн. Ер нь улс орон бүр нутаг дэвсгэрээ бүсчлэхдээ тухайн орны онцлог, уламжлал, засаг захиргаа, дэд бүтэц, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, байгаль, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс зэргийг харгалзан бүсчлэлийн аль нэг хэлбэрийг дангаар эсвэл хослуулан хэрэглэдэг. Бид Аж үйлдвэрийн бүсчлэлийг тогтоохдоо эдийн засгийн газарзүйн арга, зураглалын, хөгжлийн чадавхийн, тэргүүлэх чиглэлийг тогтоох аргуудыг ашигласан. Энэ ажил нь процесс талаасаа дата, мэдээлэл цуглуулах, суурин боловсруулалт хийх, байршлын анализ хийх, бодлогын анализ хийх гэсэн үе шаттайгаар хийгдсэн.

Үндсэндээ өмнөх судалгаатай нийлээд 100 орчим сэдэвчилсэн зураглал, тооцооллыг хийсэн. Эдгээрээс хамгийн чухалчилж үзсэн суурь үзүүлэлт бол одооны үйлдвэрийн байршил, хүн амын тархалт, суурьшил, ажиллах хүчний асуудал, дэд бүтэц, тусгай хамгаалалт, ус зүй, аялал жуулчлал, гидрогеологи, уур амьсгал зэрэг үзүүлэлтэд тулгуурласан. Мэдээж нарийвчилсан үзүүлэлтийг тухайн үйлдвэрлэлийн салбараас хамааруулан өөр өөрөөр сонгосон. Тухайлбал, ноос, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүсийг тогтоохдоо, түүхий эдийн нөөц, одоо байгаа ноосны үйлдвэрийн байршил, малын тоо, нийлүүлэлт, өртөг, борлуулалтын сүлжээг нь цогцоор нь харж тогтоосон байгаа. Бодлогын анализын хүрээнд геополитик, орон нутгийн болон бусад салбарын бодлогын чиглэлийг мөн

тооцож гаргасан.

-Зураглалыг гаргахдаа хэдэн бүс, дэд бүсэд хуваасан юм бэ?

-Үндсэндээ аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн таван бүс, 27 дэд бүсийг тооцон гаргасан. Эдгээр бүсэд 18 үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг аль нь тэргүүлэх байдлаар хөгжих бололцоотой талаар бүсүүдийн төлөвлөлт, зураглалд тусгаж өгсөн. Тэгэхээр тухайн бүсийн онцлогт тохирсон тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэлийг төрөөс санхүүгийн болон санхүүгийн бус дэмжилгээр дэмжинэ гэж ойлгож болно.

-Аж үйлдвэрийн хөгжлийн дэд бүсүүдийг сүүлийн үед маш ихээр яригдаж байгаа кластерийн тогтолцоо гэж ойлгож болох уу?

-Өмнө хэлсэнчлэн, тухайн дэд бүсүүдийг тогтоохдоо үйлдвэрлэлийн нийлүүлэлт, борлуулалт, өртгийн сүлжээ гэдэг зүйлийг орон зай талаас нь харгалзсан. Кластер гэдэг ойлголт нь нийтлэг утгаараа газар зүйн хувьд ойр байрлалтай, нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний үйл ажиллагаа нь нягт уялдаатай тухайн чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн байгууллагууд, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдэл, сүлжээг ойлгодог.

Систем талаас кластер нь нэгдсэн зохион байгуулалтад орсон тодорхой зорилготой үйл ажиллагаа явуулж байгаа харилцан хамаарал бүхий субъектүүдийн нэгдэл. Тэгэхээр аж үйлдвэрийн хөгжлийн дэд бүсүүдийг нэг кластер хэлбэрээр ойлгож болохгүй. Гэхдээ тухайн бүсэд 2-3 кластер бүсийн үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлээр хөгжих боломжтой гэж ойлгож болно. ■



MOST RELIABLE BANK IN MONGOLIA

Үйлдвэрлэлд тулгуурласан хөгжлийг түгээгчид

Г.Орхон



Тайванийн хөгжлийн гол зангилаа жижиг, дунд үйлдвэрлэлийг амжилттай хөгжүүлснийх гэдгийг дахин сануулъя.

Цагаан будаа, чихрийн ургамлаас өөр орлогын эх үүсвэргүй байсан нэгэн улс өнөөдөр Азийн бар болтлоо хөгжиж чаджээ. Энэ бол Тайвань. Чухам эдний хөгжлийн түлхүүр үйлдвэржилт байсан юм. Аж үйлдвэрлэлийг хөгжүүлсний дүнд өдгөө дэлхийд эдийн засгийн үзүүлэлтээрээ гайхуулж яваа улсууд энэ мэт сонин содон түүх хийгээд сургамжийг түүхийн хуудаснаа үлдээжээ. Тэр ч байтугай загасчны жижиг тосгоноос дэлхийн хэмжээний улс болсон орон ч манай тивд бий.

1949 оноос Тайванийн эдийн засаг эрчимтэй хөгжиж үйлдвэржиж эхэлсэн юм. Үйлдвэржүүлэх дөрвөн жилийн хөтөлбөрийн дагуу 1953 оноос хөвөн даавууны болон бэлдэц гаргах үйлдвэрийг, 1957 оноос шил, төмөр, арматур зэрэг үйлдвэрлэлийг явуулжээ. Харин 1963 оноос гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, электрониксийн үйлдвэрлэлийн үндсийг бий болгох зорилт тавьж хэрэгжүүлсэн аж. Уг зорилтыг улс даяараа дагасны дүнд өнөөдөр тайваньчууд дэлхийн электрон барааны томоохон үйлдвэрлэгч болоод байна. Тус улсын хөгжлийн гол зангилаа жижиг, дунд үйлдвэрлэлийг амжилттай хөгжүүлснийх гэдгийг дахин сануулъя. Тайванийн эдийн засаг 1952-1980 онд 8.7 хувь, 1983-1986 онд 6.9 хувьд хүрч байж. Энэ хооронд гадаад худалдаа нь ч өсч хэдийн аж үйлдвэржсэн орон болж чаджээ. Тайвань нь арваадхан жилийн дотор танигдахын аргагүй хөгжсөн бөгөөд өдгөө Тайванийн нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 37.931 ам.доллар, эдийн засгийн өсөлт 10.5 хувьтай байна. Мөн инфляци маш бага, дэлхийд эдийн засгийн чадлаараа 19 дүгээрт, ДНБ-ээрээ 18 дугаарт жагсаж,

хөгжингүй орнуудтай мөр зэрэгцэн явна. Ялангуяа, гадаад худалдааны эргэлтээр толгой цохиж яваа.

Дэлхийн бүх улсын дахь үйлдвэржилтийг үндсэн таван шатад хуваан авч үздэг байна. Тэргүүнд, үйлдвэржилтийн бэлтгэлийн үе шат гэж бий. Дараа нь үйлдвэржилтийн үндсэн суурийг бэхжүүлэх үе шатанд эрх зүйн орчны нарийвчилсан хуулиуд, дэд бүтцийн асуудлууд зэргийг хамааруулдаг аж. Манай улсын хувьд үйлдвэржилтийн хуулиа гаргачихлаа. Харин одоо хатуу болон зөөлөн дэд бүтцийн асуудал руугаа анхаарч байгаа. Хатуу гэдэгт зам, зөөлөн дэд бүтцэд кластерийг хөгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх зэрэг ордог байна. Тэгэхээр бид үйлдвэржилтийн нэгээс хоёрдугаар үе шат руу явж байгааг Аж үйлдвэрийн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Баттогтох ярьсан.

Олон улсад гуравдугаарт, үйлдвэрийн бүтцийг сайжруулах тухай асуудлыг авч үзэж байгаа аж. Монгол Улс эхний гурван шатын аль алинд нь ахиц гаргах шаардлагатай байгааг Д.Баттогтох дарга онцолсон. Учир нь манай улсын экспортын 81.6 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байгаа нь эдийн засгийн төрөлжилт байхгүйг харуулж буй юм. Тиймээс бид уул уурхайн олборлолт хийхээс гадна үүнээс олсон орлогоороо эдийн засгаа сэргээж, бусад үйлдвэрлэлээ дэмждэг ийм төрөлжүүлэх шат руу орох хэрэгтэй гэнэ. Хөгжингүй орнууд ч ингэж үйлдвэрлэлийн голлох салбаруудаа дэмждэг байна. Үүний дараа, нийгмийн нэгдэл нягтралыг сайжруулах буюу кластерийг хөгжүүлэх тухай асуудал бий. Харин үйлдвэржилтийн сүүлийн

үе шат буюу хөгжингүй аж үйлдвэрүүд мэдлэгт суурилсан мэдээллийн үе гэдэгт гар ажиллагаа гэхээс илүүтэй оюунлаг хөдөлмөрийг хамааруулж байгаа юм. Тухайлбал, фэйсбүүкийг нэрлэж болно.

Үйлдвэржилтийн бодлогоор эдийн засгаа тэтгэж буй орнууд дээрх таван шатыг туулж яваа аж. Үүнээс гадна, экспорт болон импортын чиглэлээр аж үйлдвэрлэлээ хөгжүүлсэн орнууд бий. Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур зэрэг улс экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлсэн. Харин Энэтхэг, Аргентин, Мексик, Бразил зэрэг орон нь импортыг орлох чиглэлийн үйлдвэрлэлээ явуулж, түүнийг дэмжих бодлого явуулж байгаа. Учир нь эдгээр улсын өөрсдийн зах зээл нь том байгаад юм.

Экспорт болон импортын чиглэлээр үйлдвэрлэлээ хөгжүүлсэн орнуудын тэргүүн жишээд Өмнөд Солонгосыг дурьдаж болно. Тус улс нь үйлдвэржүүлэх хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Эхний шатанд импортыг хязгаарлах хатуу бодлого явуулсны дүнд үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалж зөвхөн машин техник, тоног төхөөрөмжийн импортыг хүлээн зөвшөөрч байжээ. Импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлийг баримталж бүх хүчээ төмөрлөгийн үйлдвэр барихад зориулж, ашиглалтад оруулж чадсанаар импортоор авдаг бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж чаддаг болсон аж. Мөн экспортын чиглэлээр хөнгөн үйлдвэрүүдийг хөгжүүлж иржээ. Тус улсын Засгийн газрын зүгээс экспортын хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн суурь салбарыг хөгжүүлэх асуудлыг чухалчилсан байна. 1970-аад



Өдгөө Өмнөд солонгосчууд Нөөцөд тулгуурласан эдийн засгаас инновацид суурилсан чиглэл рүү шилжиж байгаа гэнэ.

оны сүүлч хүртэл экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж төмөрлөг, хими, машины үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэв. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр, засгаас нь онцгой анхаарч хөнгөлөлттэй зээл олгох, үйлдвэртээ зориулж импортоор авах зүйлийг нь гаалийн татвараас хөнгөлөх буюу чөлөөлөх бодлого баримталж байж. Шинээр экспортод зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гаалийн болон ашгийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Улмаар энэ чиглэлийн үйлдвэрлэлийн салбар 1980 оноос эрчимтэй хөгжиж эхэлсэн байна. Сүүлийн 50 жилийн хугацаанд хурдацтай хөгжсөн нь тус улсын талаарх хатуу үнэн баримт. Өдгөө Өмнөд солонгосчууд Нөөцөд тулгуурласан эдийн засгаас инновацид суурилсан чиглэл рүү шилжиж байгаа гэнэ. Тодруулбал, Засгийн газраас нь 1960-1980 онд аж үйлдвэрлэлд суурилсан бодлого барьж байсан бол 1990 оноос хойш инновацид суурилсан төрийн бодлого хэрэгжүүлж эхэлсэн байна.

Ер нь аль ч улс орон шинжлэх ухаан, технологийн бодлогоо аж үйлдвэрийн бодлоготой хамт явуулж байж эдийн засгаа амжилтай сэргээдэг аж. Тухайлбал, Солонгост, төрийн бодлого гарсны дараа Шинжлэх ухааны яам, Үйлдвэрийн паркаа байгуулсан. Өдгөө тус улс усан завь, дэлгэцийн үйлдвэрлэл, роботын технологиор дэлхийд тэргүүлж явна. НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын "UNIDO"-ийн 133 орныг хамруулсан Үйлдвэрлэлийн гүйцэтгэлийн өрсөлдөх чадварын индекст /2013/

манай улс 109 дүгээр байрт оржээ. Япон улс үйлдвэрлэлийн гүйцэтгэлийн өрсөлдөх чадвараар хамгийн өндөр үнэлгээ авч, удаах байрт ХБНГУ жагссан байна. Тус үнэлгээний эхний долоод тэргүүн туршлагаараа гайхуулж яваа Өмнөд Солонгос, АНУ, Тайвань, Сингапур, БНХАУ оржээ. Тус индексийг таван гол үзүүлэлтээр тооцдог бөгөөд тэдгээрээс дунд, өндөр технологитой боловсруулах үйлдвэрлэлийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь хамгийн чухал үзүүлэлт аж. Тус үзүүлэлтээр Сингапур улс 73.41 хувь, Япон 53.7, ОХУ 23.14 байхад Монгол Улс 5.97 хувьтай гарчээ. Энэ нь тухайн улсын үйлдвэрлэлд өндөр технологитой боловсруулах үйлдвэрлэл хэр буйг харуулж байгаа юм.

Өнөөх загасчны жижигхэн тосгоноос дэлхийн хэмжээний хөгжилтэй улс болж



1950 оны Сингапур

чадсан хонконгчууд ч мөн технологийн үйлдвэрлэлд суурилсан хөгжлөөр

толгой цохиж явааг дахин онцолъё. Монгол Улстай харьцуулахад газар нутгийн хэмжээ хэд дахин бага ч тус улс нь олон улсын боомт хот болох маш ашигтай байрлалтай гэгддэг. Үүнийгээ ч тэд төрийн зохицуулалттайгаар татвар болон эрх зүйн орчныг нь дэмжсэний үндсэн дээр ашиглаж чаджээ. Эдийн засаг нь хөгжиж эхлэхдээ худалдаа, далайн тээвэр дээр суурилж, үүн дээр түшиглэн аж үйлдвэрлэлээ хөгжүүлж эхэлсэн байна.

Хонконгийн аж үйлдвэржих үйл явц 1950-аад оноос эхэлсэн бөгөөд 1960 оноос хувцас, пластик, электроникийн бүтээгдэхүүнүүдийг экспортолж эхэлсэн байна. Үйлдвэржилтийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлт хурдацтай явагдаж ажлын байр өсөн нэмэгдэж, хүн амын амьдралын түвшин эрс дээшилжээ. 1960 оноос тус улсын Засгийн газраас татварын орчныг таатай болгож, хөдөлмөрийн хуулийг батлан, эдийн засгийн шинэчлэлийн бодлогыг явуулжээ. Мөн л төрийн бодлогоо технологийнхтой уялдуулж байж.

Монгол Улсын хувьд үйлдвэржилтийг хөгжүүлэхийн тулд тусгайлан Аж үйлдвэрийн яамыг байгуулсан нь зөв алхам гэж буй. Шинэ яамдаа үйлдвэрлэгчид ам сайтай байгаа. Хэдий өнөөдөр үйлдвэрлэлийн эцсийн шатанд явж буй Тайвань, Солонгос зэрэг оронтой харьцуулахад бидний хөгжлийн алхам эхэн үед явж байгаа ч богино хугацаанд үйлдвэржиж чадах боломж нөөц бийг албаныхан онцолж байна. Гагцхүү ингэх

чиглэлийг энэ мэт тэргүүн туршлагаас хуваалцах нь зүйн хэрэг. ■

“Аж үйлдвэр” тэдний нүдээр

“Монголд үйлдвэрлэв” аж үйлдвэрийн чуулганы хүрээнд төрийн болон хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл, гадна болон дотоодын хөрөнгө оруулагчид хамтран нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх юм. Монголд анх удаа болж буй тус чуулган нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх гарцыг олоход чиглэж буй. Тус чуулганд оролцох илтгэгч,

панелист, модераторуудын төлөөллөөс хурлын гол сэдвүүдийн талаарх үзэл бодлыг нь сонирхлоо. Тэд Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүд, Экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Худалдааны бодлогоор үйлдвэрлэлийг дэмжих нь болон салбарын технологи ба хүний нөөц, хөрөнгө оруулалтын төслүүд зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцэх юм.



Д.Нэмэхбаяр /Аж үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга/:

-Монгол Улсын аж үйлдвэрийн салбарт нэн тэргүүнд боловсруулах

үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтыг татах шаардлагатай байна.

Өнөөдрийг хүртэл манай улсад уул уурхай болон хөнгөн, хүнсний үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрийн салбар хөгжиж ирсэн боловч уул уурхайн болон хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн салбар сайн хөгжиж чадаагүй байна. Иймд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг боловсруулах үйлдвэрийн төслүүдэд татах, түүний дотор уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулж, дараагийн шатны буюу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үндсэн түүхий эд болох төмрийн хүдэр, зэсийн баяжмал, газрын тос боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулах асуудал үйлдвэрлэл

хөгжих үндсэн нөхцөл болоод байна. Боловсруулах үйлдвэрлэлийн төслүүдэд дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт сайн хийж, ажиллаж байна. Жишээлбэл, төмөрлөгийн болон цементийн үйлдвэрийн төслүүд, эрдэс хөвөнгийн үйлдвэр, барилгын материалын үйлдвэрүүдийг дурьдаж болно. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл, газрын тос боловсруулах үйлдвэрийн төслүүдэд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол их байна. Мөн металл хийц, эд ангийн үйлдвэр, нүүрс, химийн үйлдвэр, тээврийн хэрэгслийн угсралтын үйлдвэр барьж байгуулах санал, санаачлагууд сүүлийн үед эрс нэмэгдэж, тодорхой ажлууд хийгдэж эхлээд байна.



К.Энхчулуун/“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал/:

–“Дарханы төмөрлөгийн үйлдвэр”

ХК-ийн хэрэгжүүлж буй “Уул уурхай, металлургийн цогцолбор” төсөл нь анх 2010 онд эхэлсэн. Төслийг үндсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2014 онд эхний шатны бүтээн байгуулалтын ажлуудаа бүрэн хэрэгжүүлж дуусгасан. Энэ шатанд уул уурхай, баяжуулах үйлдвэр болон тэдгээрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд багтсан юм. 2015 оноос бид төслийн хоёрдугаар шатны буюу төмрийн хүдрийн дараагийн шатны гүн боловсруулах үйлдвэрүүд, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, гангийн үйлдвэрийн өргөтгөл шинэчлэл, дагалдах дэд бүтцийн өргөтгөл, эдгээрийг байгуулахад шаардлагатай урьдчилсан суурь судалгаануудыг хийж, бэлтгэл ажлуудыг эхлүүлээд байна.

Төслийн хоёрдугаар шатны ажлуудыг бүрэн хэрэгжүүлэхэд нийт


700 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийх урьдчилсан тооцоог гаргасан. Төслийг бүрэн хэрэгжүүлж дууссанаар Монгол Улсын ган цувимал бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хангаж, төмрийн хүдрээс импортыг орлох нэмүү өртөг шингэсэн эцсийн ган бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх юм. Мөн олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг бага өртөг зардлаар үйлдвэрлэж, байгаль орчинд ээлтэй дэлхийн жишигт хүрсэн техник технологийг нэвтрүүлнэ. Нөгөө талаас дотоодын нийт бүтээгдэхүүн болон улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, цогцолбор үйлдвэрийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих суурь нөхцлүүдийг бүрдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн томоохон ач холбогдолтой.



ERDENET
C A R P E T

National
collection

Classic
collection



Aquarelle
collection



"NOMIN UNITED", 3RD FLOOR,
KHAN-UUL DIST, CHINGGIS AVE, P.O. BOX 2316,
ULAANBAATAR 17042, MONGOLIA 210136

Tel: 976-75777889, 976-94107889

Fax: 976-75778889

Email: export@erdenet.biz, rugexport@erdcarpet.com

Website: www.erdenetex.mn



Үчида Хажимэ / Монгол дахь Японы бизнесийн зөвлөлийн дэд тэргүүн/:

-Бид аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын эдийн засаг сэргэх гол хүчин зүйлсийн нэг гэж бодож байна. Уул уурхайн салбарын хэлбэлзэл бидэнд сургамж болж, эрүүл эдийн засагтай байхын тулд олон талт худалдааны бодлоготой байх нь чухал гэдгийг

ойлгууллаа. Энэ жил Монгол Улс эдийн засгийн түншлэлийн анхныхаа гэрээнд аж үйлдвэрийн тэргүүлэх орон болох Япон улстай гарын үсэг зурлаа. Энэ нь Япон улсын компаниудтай хамтарч Монголын үйлдвэрүүдийн технологи, ноу-хауг сайжруулах мөн хоёр орны худалдааны хэмжээг нэмэгдүүлэх сайхан боломж юм.



А.Мөнхболд /Монголын Логистикийн холбооны тэргүүн/:

-Аж үйлдвэржилтийн бодлогын салшгүй нэг хэсэг бол худалдааны бодлого байх ёстой. Худалдааг дэмжих гадаад, дотоод улс төрийн бодлого байх ёстой. Худалдааны

бодлого маш чухал, мөн худалдааны бодлогоор үйлдвэрлэлийг амжилттай дэмжсэн нэгэн жишээ бий. Вьетнам улс Солонгосын "Самсунг" брендийн гар утас угсрах үйлдвэрийн эхний хэсгийг 2012 онд өөрийн нутаг дэвсгэрт байгуулж, 2013 онд дөрвөн тэрбум ам.долларын борлуулалт хийж чадсан. 2014 онд хоёрдахь шатны үйлдвэрийг байгуулж найман тэрбум ам.долларын борлуулалт хийж, 12 мянга орчим ажлын байр бий болгосон байдаг.

Монгол Улс үйлдвэрлэгч болж дэлхийд бүтээгдэхүүн нийлүүлэхийг хүсч байгаа бол юуны өмнө хэрэглэгчийн зан төлөвийг судлах шаардлагатай. Япон улстай Чөлөөт худалдааны гэрээ байгуулсан нь сайн боловч тэдний зах зээл, хэрэглэгчид манай монгол

хэрэглэгчээс зуу дахин хүнд шаардлага тавина. Монгол хэрэглэгчийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаа энэ үед гадаад зах зээл хол сонсогдож байна. Хэрэглэгч, зах зээлд чиглэсэн үйлдвэрлэл, худалдаа гэдэг бол маш сайн нийлүүлэлтийн хэлхээ, логистикийн шийдлийг шаардаж байдаг. Үүргийн худалдаачид битгий хэл манай олигархиуд худалдааны бодлогыг эсэргүүцэх нь зүйн хэрэг.

Учир нь тэд зөвхөн ашиг харж амьдардаг шүү дээ. Гэвч улс орон хөгжих шаардлагатай, бид хэрэглэгчдээ хамгаалж сурах, мөн гадаад зах зээлд өрсөлдөх нь чухал байна. Худалдааны тухай хууль эрхзүйн орчныг бий болгохгүйгээр үйлдвэрлэл хөгжүүлэх боломжгүй. Мөн логистикийн эрхзүй бидэнд маш ихээр шаардагдана.



С. Жавхланбаатар/Хөрөнгө оруулалтын газрын дарга/:

-Монгол Улс аж үйлдвэрийн бодлогыг гурван чиглэлд барих ёстой. Эхнийх нь уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэр. Үүнд хамгийн чухал зүйл нь юуг боловсруулж, ямар бүтээгдэхүүн гаргах вэ гэдэг асуудал. Тухайлбал, Эрдэнэт, Оюутолгой болон Цагаансувragын орд газар зэсийн баялаг их. Тэгвэл үүнийг хэрхэн боловсруулж ямар эцсийн

бүтээгдэхүүн болгож зах зээлд гаргавал бид өрсөлдөж чадах вэ. Хоёр дахь нь хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэржилт. Ялангуяа, нэн тэргүүний зорилт болох импортыг орлох бүтээгдэхүүн, цаашлаад экспортын барааны нэр төрлийг олшруулахад өргөн боломж бий. Сүүлийнх нь оюуны чадавх, мэдлэг шингэсэн үйлдвэрлэл. Энэ төрлийн үйлдвэржилтийг хөгжүүлэхэд ихээхэн талбар бий.

МОНГОЛД
ҮЙЛДВЭРЛЭВ

Аж үйлдвэрийн форум 2015
Мэдээллийн ивээн тэтгэгч

MONGOLIAN
ECONOMY



Bloomberg
TV MONGOLIA





Т.Баярсайхан /Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны тэргүүн/:

-Өнөөдөр хөнгөн аж үйлдвэрлэлийн



Ч.Даваабаяр /Баялаг бүтээгчдийн холбооны ерөнхийлөгч/:

-Экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл манай улсад тийм ч хангалттай түвшинд хүрч хөгжиж чадаагүй байна. Ерөнхий зургийг нь харвал гадаад худалдааны алдагдал буурч байгаа ч энэ нь экспортын хэмжээ нэмэгдсэн гэхээсээ илүүтэй импортын хэмжээ буурсантай холбоотой. Бас экспортод эзэлж байгаа гол бараа нь

салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 30 гаруй хувийг үйлдвэрлэж, бүтээгдэхүүнийхээ 40 гаруй хувийг АНУ, Ази, Европын 20 гаруй оронд экспортолдог болсон. Арьс, ширний үйлдвэрлэлийн салбар 1980-1990 онд хөгжлийнхөө оргил үед хүрч, Монгол Улсын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 13 гаруй хувийг үйлдвэрлэж, экспортын бүтээгдэхүүний 10 гаруй хувийг дангаараа үйлдвэрлэн гаргаж байсан түүх бий. Арьс, ширний үйлдвэрлэлийн салбар 2014 онд 120 гаруй тэрбум төгрөгийн экспорт хийсний 65 хувь нь хагас боловсруулсан арьс ширний экспорт байна. Экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг арьс, ширний үйлдвэрлэлийн салбарт дүгнэж

эрдэс бүтээгдэхүүн хэвээрээ байна. Үүн дээр экспортод арай илүү жин дарж байгаа нь нэхмэл бүтээгдэхүүн.

Эндээс экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах шаардлага буй нь харагддаг.

Нийт экспортын 97 хувь түүхийгээрээ гарах жишээтэй. Ийм бүтээгдэхүүнийг технологийн агууламж багатай бүтээгдэхүүн гэж нэрлэж байгаа бөгөөд үүнийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээр солих шаардлага байна. Дээр нь дэлхийд ганцхан Монголд байх цөөн тооны брэнд бүтээгдэхүүн экспортод гарч байна. Мах, махан бүтээгдэхүүн бага зэрэг нэмэгдэнэ. Экспортод гаргаж болохуйц маш олон төрлийн бүтээгдэхүүн Монголд үйлдвэрлэгдэж байгаа ч чанар, үзэмжийг нь сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэх зэрэг шаардлага тулгарч байгаагаас энүүхэндээ нутаг усандаа, цаашлаад бүсдээ, нийслэлд л борлуулалт хийх хэмжээнд байгаа нь олон юм.

үзэхэд нийт экспортын ихэнх хувийг хагас боловсруулсан арьс, ширний экспорт эзэлж байгаа нь цаашдаа гүн боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн хийх шаардлагатайг харуулж байгаа юм.

Арьс, ширний үйлдвэрлэлийн технологийн парк байгуулах, түүхий эдийн чанарыг сайжруулах, малыг эрүүлжүүлэх хэрэгтэй. Сумдад мал нядалгааны орчин үеийн цех болон түүхий эд тордолтын цехүүдийг байгуулах. Салбар хариуцсан Аж үйлдвэрийн яамтай болж, богино хугацаанд аж үйлдвэрийн бодлогыг тодорхойлон гаргасан. Үйлдвэржилтийн хуулийг боловсруулж батлуулсан нь сайшаалтай.

Хэтэрхий жижиг, дунд үйлдвэрлэл гэж туйлширчихгүй бол бодлогын хувьд зөв гэж харж байна.

Монгол Улсад үйлдвэрлэлийг нэгдсэн бодлогоор хөгжүүлэх хэрэгтэй. Нэгт, манайд ямар нөөц боломж буйг судлах. Хоёрт, гадаад зах зээл юу сонирхож байна, юу эрэлт ихтэй байна. Энэ хоёр үндсэн үзүүлэлтэд тулгуурлаж бодлого явах ёстой. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийг өргөжүүлээд явбал экспортын багцыг маш олон нэр төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулах боломжтой.

Гэхдээ өнөөгийн байдлаараа шууд гадаад зах зээлд гарна гэхэд учир дутагдалтай. Тэнд технологийн шинэчлэл хийж бүтээгдэхүүний чанарыг сайжруулахаас гадна боловсон хүчний ур чадварт анхаарахын зэрэгцээ сав, баглаа, боодлыг нь өөрчлөх хэрэгтэй. Олон ширхэгээр үйлдвэрлэх шаардлага байна. Хамгийн гол нь гаргах зах зээлээ судлах, холбоо харилцаа тогтоох нь чухал. Энэ бүхэнд төр оновчтой, шуурхай, үр дүнтэй шат дамжлага бий болгож дэмжих хэрэгтэй. ■

Чухал нь экспорт



Ц.Сайхан

Аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх гол шалтгаан нь импортыг орлож, экспортыг дэмжих. Үйлдвэрлэлийг импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дагнан хөгжүүлнэ гэвэл олон дутагдалтай гэдэгт өнөөдөр эдийн засагчид санал нэгддэг. Үүний хамгийн тод жишээ нь Латин Америкийн орнуудын туршлага. Латин Америкийн орнууд 1970-1980 оны хооронд импортыг орлох үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлсэн боловч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хэмжээ эргээд буурчээ. 2000-гаад оны үед дөрөв орчим хувийн өсөлттэй байсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хэмжээ сүүлийн жилүүдэд хасах утга заах болсон юм. Импортыг орлох бодлогыг түлхүү баримталснаар тус бүс нутгийн олон улс өрийн дарамттай болж хоцорсон аж.

Гэтэл бөмбөрцгийн нөгөө хагаст Зүүн Азийн улсууд экспортыг илүү дэмжсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлжээ. Өнөөдөр Солонгос, Япон, Хятад, Хонконг хэдийнээ хөгжингүй орнуудын эгнээнд хөл тавьсан. Импортыг орлох бодлогын сул тал нь үйлдвэрлэгчдийн гадаад зах зээл дээр өрсөлдөх чадварыг сулруулдаг байна. Учир нь импортын тарифыг нэмж, дотоодын үйлдвэрлэлээ хамгаалснаар аж ахуйн нэгжүүд тэр хамгаалалтандаа амархан дасч шинэчлэл хийх сонирхолгүй, үнийн хүчтэй өрсөлдөөнд ордоггүйгээс хэрэглэгчид эцэстэй илүү үнэтэй бүтээгдэхүүн худалдан авахад хүрч хохирдог аж.

Харин Зүүн Азийн орнууд дотоод зах

зээлийг хамгаалахдаа үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд экспортлох шаардлага тавьснаар амжилтаа илүү удаан хадгалж чаджээ. Жишээлбэл, Өмнөд Солонгос дотоодын авто машины үйлдвэрүүдийг хамгаалах үүднээс импортын татвараа тусгай хэлэлцээр байгуулаагүй орнуудын бүтээгдэхүүнд 20.4 хувьд хүргэжээ. Ийнхүү дэмжлэг үзүүлснийхээ хариуд Засгийн газар нь барууны хэрэглэгчдийн таашаалд нийцэхүйц чанар, үзэмжтэй машин үйлдвэрлэх “үүрэг” өгдөг. Ийм харилцаанд орсон тус улсын машин үйлдвэрлэгчид технологийн шинэчлэлийг ойр ойрхон хийж, гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ амжилттай борлуулах боломжийг үргэлж эрэлхийлж байдаг аж.

Гэвч импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлд мөн давуу тал бий. Ийм төрлийн үйлдвэрлэл богино хугацаанд хөгжих боломжтой гэнэ. Үүнээс гадна үндсэн хүчин зүйлийн бүтээмж (total factor productivity)-ийг нэмэгдүүлдгийг эдийн засагч Б.Дөлгөөн хэлж буй. Үндсэн хүчин зүйлийн бүтээмж гэдэг нь үйлдвэрийн бүтээгдэхүүний гарц нэмэгдэхэд нөлөөлсөн капитал болон хөдөлмөр дээр бусад хүчин зүйлийг нэгтгэснийг нэрлэдэг байна. Үүнд багтдаг гол хүчин зүйлс нь технологийн дэвшил болон бүтээмж байдаг аж.

Дээрх туршлагаудаас суралцаж Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг гурван үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан. Эхний үе шатад “экспортыг дэмжих, импортыг

орлох”, хоёр дахь үе шат нь “экспорт давамгайлсан”, гуравдугаар үе шатад “мэдлэгт суурилсан” аж үйлдвэрийн бүтцийг бий болгоно хэмээн тодорхойлжээ. Мэдлэгт суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлснээр Монгол Улс гадны технологийг авч ирж нутагшуулах бус үндэсний тодотголтой технологийг гадаадад экспортлодог болох зорилго тавьж буй. Олон жилийн турш алдагдалтай явж ирсэн гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн жилийн өдий үеэс ашигтай гарах болсон. Гэхдээ бид юу худалдан авч, юу экспортлож байгаа вэ гэдгийг эргэн саная. Хэрэв Монгол Улс аж үйлдвэржсэн орон байсан бол гадаадаас хямд түүхий эд авч нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэд дахин өндөр үнээр буцаан худалдаж, одоогоос илүү ашиг олох байв. Гэвч нөхцөл байдал тийм биш бөгөөд эсрэгээрээ хямд түүхий эд нийлүүлж, үнэтэй эцсийн бүтээгдэхүүн худалдан авсаар байна.

Уг нь 1998 онд Засгийн газрын 158 дугаар тогтоолоор “Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” батлагдаж байжээ. Уг хөтөлбөрт “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, эрдэс болон хөдөө аж ахуйн түүхий эдэд гүн боловсруулалт хийж, экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийг заасан болно” хэмээн үндэслэлээ тодорхойлжээ. Тухайн үед

НИЙТ АЖИЛЧДЫН ТОО-250



экспортын бараанд хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн зонхилж байв. 1997 онд экспортын нийт барааны 55.9 хувийг эрдэс түүхий эд, 22.5 хувийг нэхмэл, бүтээгдэхүүн эзэлж байжээ. Нийт бараа бүтээгдэхүүний 57,2 хувийг түүхий эд эзэлж байсныг уг хөтөлбөрийн баримт бичигт дурьджээ. Өнөөдөр бараг 90 хувь.

Нэг талаас энэ тоо монголчууд бодлогодоо хэр үнэнч байдгийг хэлээд байх шиг. Ямартай ч бодлогоо гаргаад, стратегиа тодорхойлчихлоо. Гэвч энэ хөтөлбөрийг 18 жилийн өмнөх шиг цаасан дээр л үлдээхгүйн төлөө ажиллах ёстой. ■

3. Үжин

Говийн агаар чийглэг. Дуу чимээ их. Хурдан хурдан алхалсан залуус зөрөлдөж, хаа нэгтээгээс бэлчээрийн малын үнэр хамар цоргих нь содон. Энэ бол элсээр биш ноолуураар дэлхийд танигдсан Монголын өөр нэгэн говь болох “Говь” ХК-ийн үйлдвэрийн хэсэг юм.

Ноолуурын аялал

Эх орны өнцөг булан бүрээс сорчлон бэлтгэсэн ноолуур “зочлох” эхний хэсэг бол бүтээгдэхүүн хүлээж авах анхан шатны үйлдвэрийн хэсэг. Энд үндсэн дөрвөн өнгийн ноолуурыг хүлээн авч, гар аргаар ялгаад дараа нь угаах дамжлага руу шилжүүлнэ. Усанд орж, өнгө зассан ноолуур хялгаснаас салгах машин руу хүргэгдэнэ. Эхний шат дамжлагад хүний оролцоо их байх бол хоёр дахь дамжлагаас эхлэн том том машинууд ноолуурыг угааж, хатааж, өнгө будганд хүртэл оруулна. Ямаа гэх эзнээсээ салсан ноолуур “Говь”-д ирээд ёстой л гоо сайхны хувьд бүрэн өөрчлөгдөнө гэсэн үг. Өнгөө өөрчилж будах дамжлагаас гарсан ноолуур зүсээ хувиргахаар ээрэх дамжлагад шилжин утас болж үргэлжлэн сүлжих, нэхэх хэсэг рүү явах ажээ. Энэ мэт малчдын гараас шууд ирсэн ноолуур “Говь” компанийн 10 гаруй шат дамжлагаар дамжиж эцсийн бүтээгдэхүүн болж хэрэглэгч таны гарт хүрдэг аж.

Эрүүл мэндэд ээлтэй алтан хольц

Ноолууран бүтээгдэхүүнийг зөвхөн хүйтэн, сэрүүний улиралд өмсдөг гэдэг ойлголтыг “Говь” компанийнхан халжээ. Хөнгөн, нимгэн, зөөлөн, гэрэлтсэн... Энэ бол зуны ноолуур.

Мөн тэд нэгэн цоо шинэ бүтээгдэхүүнийг гаргаж авахын тулд ноолуур болон торго, хөвөн даавууны алтан хольцийг олсон байна. Тухайн бүтээгдэхүүн нь агаарын солилцоо сайтай байдгаараа давуу талтай төдийгүй хорт хавдрын эсрэг үйлчилгээтэй гэдгийг Үйлдвэрийн удирдлагын газрын дарга Г.Саруулзаяа

СУРВАЛЖЛАГА

ИЙМ НЭГЭН “ГОВЬ”



“Говь” компанийн бүтээгдэхүүн.

Өнөөдөр тус компанийн “Монголд үйлдвэрлэв” шошготой ноолуураар дэлхийн 30 гаруй орны хэрэглэгчид хувцаслаж байна. Мөн тэд дотоодын зах зээлийн 50 гаруй хувийг дангаар эзэлдэг.

хэлсэн. Учир нь торго нь нарны хэт ягаан туяанаас хамгаалдаг бол хөвөн даавуу нь агаарын солилцоог сайжруулдаг аж. Тийм болохоор амьсгалдаг цамц маань хорт хавдраас сэргийлэх боломжтой гэнэ.

Нууц жор

Говийнхонд алтан хольцоос гадна өөр нэг нууц жор байдаг аж. Тэр жороо Японы эмэгтэй бэлэн хувцас үйлдвэрлэлийн салбарын тэргүүлэгч Larine компанитай хамтарснаар олжээ. Пальто, пиджакны үлгэр суулт, оёдлын болон материалын чанарыг цоо шинэ технологийн дэвшилд хүргэх зорилготой тэдний хамтын ажиллагаа үр дүнгээ өгч өдгөө “Говь” компанийнхан пальтоны үйлдвэрлэлээ өмнөх жилээс 58 хувиар өсгөж чадсан байна.

Мөн дэлхийд өрсөлдөхүйц чанартай, 100 хувь ноолууран пальтог олон улсынхаас 3-10 дахин хямд үнээр борлуулдаг аж. Учир нь түүхий эдтэйгээ хамгийн ойр байдаг үйлдвэр бол “Говь” шүү дээ.

“Говь”-ийнхан ноолуураа цуглуулахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүх шат дамжлагыг өөрсдөө хянадаг нь үйлдвэрийн гол бахархал гэдгийг Гадаад худалдааны ахлах менежер Б.Дүүнээ онцолсон. Ийм үйлдвэр дэлхийд ердөө тав байдаг бөгөөд энэ нь хэрэглэгчдийн итгэлийг даах гол шалгуур болдог аж. Тиймээс ч өнөөдөр тус компанийн “Монголд үйлдвэрлэв” гэсэн шошготой ноолуураар дэлхийн 30 гаруй орны хэрэглэгчид хувцаслаж байна. Мөн тэд дотоодын зах зээлийн 66 хувийг эзэлдэг. “Говь” ХК жилд дунджаар 750 мянган төрлийн сүлжмэл, 25 мянган ширхэг оёмол, 350 мянган уртааш метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

Технологижсон “Говь”

Ноолуурын үйлдвэрт технологийн гайхамшгийг харах боломжтой. Хэрэглэгч бүрийнхээ сэтгэлд нийцсэн өнгийг гаргах будагч машин, долгионы аргаар хатаагч, уран хатгамалын машин, 3D принтер, хялгас ялгагч гээд сонин, содон технологи “Говь”-ийн үйлдвэрт зогсоо зайгүй ажиллана. Эдгээр машин монгол хүний уран сэтгэмжийг бодит болгох гол туслагч бөгөөд 1200 төрлийн өнгийг гаргаж, 20-хон грамм жинтэй оролт үйлдвэрлэж, таны хүссэн зургийг ноолуур дээр хэвлэх жишээтэй. Тэр бүү хэл ганц ч оёдолгүй хувцас гаргадаг гээд боддоо.

Эдийн засгийн нүдээр

Тус компани Монголын ноос ноолуурын салбарын 66, гадаад зах зээлийн 50 орчим хувийг дангаараа эзэлдэг. Хувьчлалаас буюу 2007 оноос хойш “Говь” ХК 27.1 тэрбум төгрөгийг техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад зарцуулснаар өрсөлдөгч нараасаа ялгаран, олон улсад нэр хүндтэй брэнд болж чадсан байна. Тэр ч утгаараа өдгөө дэлхийн ТОП таван ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн нэгт зүй ёсоор ордог аж. Хямралын үед ч тэд хөрөнгө оруулалтын хэмжээгээ бууруулаагүй бөгөөд өнгөрсөн онд 3.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

Ноолуурын салбар нь экспортын хэмжээгээрээ Монголд уул уурхайн бүтээгдэхүүний дараа орж байгаа, стратегийн чухал салбар. Манай улс жилд 7500 тонн түүхий ноолуур боловсруулж, дэлхийн зах зээлийн 40 хувийг хангаж байгаа ч эцсийн бүтээгдэхүүний экспортын хувьд хүчин чадал, боломжоо бүрэн ашиглаж чадахгүй байгаа гэдэг. Гэхдээ өнгөрсөн онд “Говь” ХК борлуулалтын орлогоо 35 хувь өсгөж 65.9 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн хэмжээг 48 хувь өсгөж 10.5 тэрбум төгрөгт хүргэснээр Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас хамгийн

2014 онд цэвэр ашгаараа тэргүүлсэн 10 ХК, тэрбум төг



Эх сурвалж: БиДиСЕК

Экспортын гол нэрийн бараа, сая ам.доллар



Эх сурвалж: УСХ, БиДиСЕК

өндөр ашигтай ажилласан компани болжээ.

Сүүлийн жилүүдэд “Говь” хамгийн том өрсөлдөгч болох Хятад улсын зах зээл рүү эрчимтэй нэвтэрч байна. Өнгөрсөн онд хоёр, энэ он гараад нэг дэлгүүрийг Өвөр Монголын хотуудад нээгээд байгаа. Монгол Улс ноолуур үйлдвэрлэлээрээ дэлхийд Хятадын дараа хоёрдугаарт бичигдэж байна. Гэвч энэхүү 7500 тоннын ердөө 10 гаруй хувийг бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгон гаргаж байгаа бөгөөд үлдсэн хэсэг нь анхан шатны боловсруулалтад орж, экспортлогдож байна.

Монгол Улс жилдээ ердөө 1.2 сая ширхэг ноолууран эцсийн бүтээгдэхүүн борлуулж байна. Үүний 40 хувь нь экспортод гарч байгаа. “Говь” ХК-ийн хувьд жилийн хүчин чадал нь 750 мянган ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх бөгөөд өнгөрсөн жил 470 мянган ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Монголын зах зээлийн 66 хувийг хангажээ.

Загвар, чанар, өнгө, үнийн өргөн сонголт бий болгосноор худалдан авагчдын тоо жил бүр нэмэгдсээр байгаа аж.

Компанийн орлогын 40 гаруй хувийг экспортын орлого бүрдүүлдэг учраас валютын ханш чангарах нь “Говь” ХК-ийн хувьд харин ч эерэгээр тусдаг. Тиймээс ч тэд энэ удаагийн хямралд цочроогүй аж. Тэдний экспортын гол зах зээл нь Франц, Япон, Орос улс. Дотоодын борлуулалтад гаднын жуулчид мөн багагүй хувь нэмэр оруулах бөгөөд дотоодын нийт худалдан авалтын 50 хувийг жуулчид бүрдүүлдэг байна. ■



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР

Хөгжлийн хөг

Г.Түшээ



Японы нэгэн профессор нохойныхоо доор Чингис хааны зурагтай эсгий дэвсгэр дэвссэн байж. Ийм нэг сонин мэдээг өнгөрсөн дөрөвдүгээр сард болсон “Улаанбаатар форум 2015”-ын үеэр ШУТИС-ийн профессор Л.Оюунцэцэг олонд сонордуулсан. Өнөөдөр бид ямар бараа, бүтээгдэхүүнийг хэнд, ямар зориулалтаар үйлдвэрлэхээ тааруухан тооцоолж буй нь энэ. Товчхондоо, манайд мэдлэгт суурилсан үйлдвэрлэл үгүйлэгдэж байна. Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжлийнхөө явцад энэ мэт олон бартаа туулдаг. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн хийж чаддаг эсвэл сонирхлынхоо хүрээнд үйлдвэрлэл явуулах бус зах зээлийн

эрэлт хэрэгцээг судалж, дэлхийн зах зээлийг харах учиртай. Тиймээс эл салбарыг зөвхөн дотоодын зах зээлийн эрэлт, хэрэгцээгээр хязгаарлах нь учир дутагдалтай гэнэ. Хөгжил ярих бол илүү алсыг харж, том зах зээл рүү тэмүүлэх нь зүйтэй аж.

Төрийн бодлогод үйлдвэрүүдийг томруулах, экспортод гарахад чиглэсэн өөрчлөлт хийгдэж буй. Тухайлбал, үйлдвэрүүдийг “жижиг”, “дунд”, “бичил” гэж илүү нарийн ангилж тус бүрт нь чиглэсэн бодлого хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг Аж үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Билгүүн ярьсан. Үйлдвэрүүд томрох,

зах зээлээ тэлэх нэг боломж нь кластер буюу хамтын ажиллагаа. Кластер нь жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлогын цөм аж. Манай үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн бүх шат дамжлагыг өөрсдөө бий болгох шаардлагатай болдог. Энэ нь тэдэнд тулгарч буй гол асуудал. Харин кластерийг нэвтрүүлснээр үйлдвэрлэгчид хамтарч буюу нэг нь утас ээрч, нөгөө нь оймс нэхэх, үлдсэн нь сав баглаа, борлуулалтыг нь хариуцах зэргээр бүтээмжээ дээшлүүлж, зах зээлээ тэлж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой. Улмаар олон улсын зах зээлд гарах боломж нээгдэнэ. Кластерийг хөгжүүлэх нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, эдийн

засгийн идэвхжлийг хангах үр дүнтэй аж. Манай улсад мах, чацаргана, арьс шир болон оёмол бүтээгдэхүүний чиглэлээр кластерийг хөгжүүлэх боломжтойг салбарын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Баттогтох ярьсан. Тиймээс цаашид жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд кластерийн талаарх мэдлэг олгох, давуу талын ойлголтыг нэмэгдүүлэхээс гадна энэ талаарх эрх зүйн баримт бичгийг бий болгох, хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй байгаа аж.

Дотоодын үйлдвэрлэгчид, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийг “Гадна зах зээлийг онилж, өрсөлдөхүйц бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэхгүй байна” хэмээдэг. Гэвч “Бест Шүес”, “Ханбогд” кашимер тэргүүтэй хэд хэдэн дунд үйлдвэр хилийн дээс хэдийн алхжээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний 20 орчим хувийг бүрдүүлэгч жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэлийн алсын хараа гадаад зах зээлийг зорьж явна. Учир нь төрийн бодлого, тэр дундаа Аж үйлдвэрийн яамны зүгээс экспортыг дэмжиж, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ гэж байгаа. Өнөөдрийн байдлаар улсын нийт экспортын дөнгөж 0.7 хувийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид бүрдүүлж байна.

Тиймээс тэднийг экспорт хийхэд нь бэлтгэж, “бойжуулах” хэрэгтэй байгааг Г.Билгүүн дарга дурьдсан. Энэ хүрээнд Аж үйлдвэрийн яам иргэд төслөө бичээд санхүүжилт авдаг байсан өмнөх тогтолцоог халж үйлдвэрлэл явуулж, шинэ технологи нэвтрүүлж, экспортод гаргах үйлдвэрлэлийг дэмжинэ гэж буй.

УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл “Монгол бол аж үйлдвэрийн суурь бааз багатай улс. Орчин үед Тогтвортой бөгөөд хүртээмжтэй аж үйлдвэрийн хөгжил гэж үйлдвэржилтийн шинэ концепц гарсан байна. Манайх энэ рүү явах ёстой” гэв. Үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах нь зүйтэй ч үйлдвэрлэлийн орчинд дотоодын үйлдвэрлэгчдийн хамгаалуулах буруу авир, импорт болон үйлдвэрлэлийн хооронд хиймэл зөрчилдөөн үүсэх аюул бийг тэрбээр сануулсан. Салбарын яамны зүгээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэднийг хамгаалах арга хэмжээ, хуулийн зохицуулалтыг удаа дараа авч хэрэгжүүлэн ажиллаж буй. Гэхдээ

үйлдвэрлэгчид цэвэр өрсөлдөөний зарчмаар явах ёстой гэх хүмүүс ч бий.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд үйлдвэрлэл эрхэлсэн хүмүүс маш хүнд үеийг туулсан ч хатуужил сууж, импорттой өрсөлдөж сурсныг олон хүн онцолдог. Дотоодын үйлдвэрлэгчдэд “энкубатор”-ын нөхцөл бий болгохоос зайлсхийх хэрэгтэйг С.Дэмбэрэл гишүүн сануулсан. Ингэхийн тулд өрсөлдөөд, улам сайжирч явах бодлого хийгээд энэ заагийг олж харах ёстойг тэрбээр учирлав. Тиймээс үйлдвэрлэгчдээ хамгаалахын өмнө энэ мэт олон зүйлийг

Манайд 145 чиглэлээр 378 жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгцээ байгаагаас 78 хувь нь боловсруулах болон хөдөө аж, ахуйн салбарт хамаарч буй.

тооцоолох хэрэгтэй аж.

Өнгөрсөн оны байдлаар бизнес бүртгэлийн санд бүртгэлтэй 59800 гаруй аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажилагаа явуулж байгаа бөгөөд үүний 84.5 хувь буюу 50600 нь жижиг, дунд үйлдвэрлэл байна. Үүнээс зургаан хувийг хөнгөн үйлдвэрлэл, 8.5 хувийг барилга, 6.2 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлнэ. Харин хамгийн их буюу 44.6 хувийг худалдаа үйлчилгээний салбарынхан эзэлж байгаа юм. Тэгэхээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дийлэнх нь энэ чиглэлээр үйлчилгээ эрхэлж байна гэсэн үг.

Яамны зүгээс мөн худалдааны бодлогоор үйлдвэрлэлийг дэмжихийг эзэх буй. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд эл үйлдвэрлэлээр хөгжсөн бусад орны туршлагаас суралцах нь чухал. Тухайлбал, Азийн бар улсуудын хөгжил жижиг, дунд үйлдвэрлэлээс эхэлсэн бөгөөд Тайванийн эдийн засгийн хөгжлийн хөг

нь жижиг, дунд үйлдвэрлэл. Өөрөөр хэлбэл, энэ үйлдвэрлэлийг дэмжиж байж эдийн засаг нь сэргэсэн улс олонтаа.

Манайд 145 чиглэлээр 378 жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгцээ байгаагаас 78 хувь нь боловсруулах болон хөдөө аж, ахуйн салбарт хамаарч буй. Үндэсний хэмжээнд брэнд бүтээгдэхүүнээр нэрлэж болох 205 бүтээгдэхүүнийг тодорхойлсон бөгөөд салбараар нь авч үзвэл 70 хувь нь хүнс, аялал жуулчлал, сүлжмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн байна. 17 салбарын 205 брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх боломжийг МҮХАҮТ-ын орлогч дарга М.Сарандаваа онцолсон. Тухайлбал, хувцас, гутал, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн болон ноос, ноолууран бүтээгдэхүүн зэргийг нэрлэж болно.

Монголчуудын хувьд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөөц, боломж бийг албаныхан хэлж байгаа. Нөгөө талаас, баялаг бүтээгчдэд ихийг бүтээх, олон улсын зах зээлд гарах хүсэл, эрмэлзлэл их бий. “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид нийт үйлдвэрлэл эрхлэгчдийн 85 хувийг эзэлж байна. Хэдий уг үйлдвэрлэл нь ДНБ-ий 20 орчим хувийг бүтээж буй ч экспортод өчүүхэн хувийг нэмэрлэдэг. Энэ нь үйлдвэрлэгчид үйл ажиллагаагаа тэлэх, үйлдвэрлэлээ томруулж чадахгүй байгааг илтгэж байгаа” хэмээн Г.Билгүүн дарга ярилаа. Үүнийг өнөөг хүртэл төрөөс баримтлах бодлогод шинэчлэл хийгдээгүй байсантай холбодог. Харин өдгөө эл салбар тусгайлсан яамтай болж, уг яам нь үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэлээ тэлэх, гадна зах зээлд гарахад дэм үзүүлэхэд бодлого чиглэж буй. Нэг үгээр, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжилд хөг нэмэх гэнэ. Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын асуудлыг төр, хувийн хэвшлийн хамтын хүчээр шийдвэрлэх нь зөв алхам гэдгийг албаныхан цохон тэмдэглэдэг байна.

Хамтын хүчээр өнөөгийн олон асуудлыг шийдвэрлэн, үйлдвэрлэл эрхлэгчдийн нуруун дээрх ачааг төр хуваалцсанаар жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж сая бүрдэх учиртай. Үүний зэрэгцээ өдгөө дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч орнуудын туршлага бидний хөгжлийн замд тулгарч буй олон зангилагааг тайлах билээ. ■

МОН & ЛАНС



Монгол улс, Улаанбаатар хот, Шуудан - 20/372 И-мэйл: monlans2000@yahoo.com
Утас: 99097706, 99017706 Утас/Факс: 976-11-350493

Үйлдвэрлэгчид ярьж байна

Цүнх болон жижиг эдлэл түлхүү экспортолдог

Б.Энх-Оюун/ "SRB" компанийн захирал/:

Үйлдвэрлэгч бидний хувьд



ажиглалтын байдалтай байна. Төрийн шийдвэр, бодлогууд цаг үеэ олсон ажил болж байна. Гагцхүү төрийн бодлого хэр тогтвортой хэрэгжих вэ, хэр урт настай шийдвэр гэдгийг үйлдвэрлэгчид бид харж байна.

Аж үйлдвэрийн яамны зүгээс аливаа ажлыг эхлүүлэхийн өмнө бидний санал, бодлыг сонсч, тусгаж байгаа нь сайн хэрэг. Манайх арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж Тайвань, БНСУ, Япон зэрэг орон руу 2012 оноос хойш гурав дахь жилдээ экспортолж байгаа.

Цүнх болон жижиг эдлэл түлхүү экспортолдог. Үйлдвэрлэлийг дэмжих хуулиар экспортлогчдыг түлхүү дэмжих юм байна гэж ойлгосон. Ялангуяа судалгаа, шинжилгээний ажилд зарцуулсан зардлын тодорхой хувийг эргүүлж олгох болсонд таатай байна.

Уялдаатай ажиллах нь чухал

М.Сосордулам/"Үлэмж камер" компанийн захирал/:

-Аж үйлдвэрийн яам байгуулагдсанаас хойш хийж, хэрэгжүүлж байгаа шийдвэрүүд үйлдвэрлэгчдийн хувьд маш том дэмжлэг болж байна. Гэхдээ бидний хувьд нэг болгоомжлол байгаа нь төрийн шийдвэр, бодлого хэр тогтвортой хэрэгжих вэ гэдэг асуудал юм.

Одоо энэ гарсан шийдвэр, тогтоолууд цаашдаа тогтвортой хэрэгжих юм бол бидний хувьд маш том дэмжлэг болно. Манай компани ноолуур угааж, самнаж экспортод гаргадаг. Өнөөдөр экспортын хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг



дэмжих талаар ярилаа. Төр үндсэн гурван төрлийн дэмжлэг үзүүлнэ гэж ойлгож байгаа. Хамгийн гол нь уялдаатай ажиллах хэрэгтэй.

Хандах газартай болсондоо баяртай байна

Г.Энхбат/"Ноос ирээдүй" компанийн захирал/:



Манай салбар цаашид тогтвортой хөгжих бодлогоо тодорхойлж, үйлдвэрлэлийг дэмжих хуультай боллоо.

Үйлдвэрлэгчид өмнө нь мэргэжлийн холбоодоороо дамжуулан төрд ханддаг байсан бол өнөөдөр хариуцах эзэнтэй, хандах газартай болсондоо маш их баяртай байгаа. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиас үйлдвэрлэлийг яаж дэмжих гэж байгаа талаар тодорхой ойлголттой болсон.

Харин манай салбар мэргэжилтэй

боловсон хүчин бэлтгэх тал дээр бусад яамдтай бодлогоор хамтарч ажиллах хэрэгтэй. Үйлдвэрлэлийг чадварлаг инженер, техникийн ажилчид, мэргэжилтэй боловсон хүчин авч явна. Нөгөөтэйгүүр, шинжлэх ухаан, өндөр технологид суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төр бодлогоор дэмжих нь чухал юм.

Дэлхийд үнэлэгдэх бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чадварлаг инженер хэрэгтэй



ЗО.Мөнхцацрал/ "Эрдэнэт хивс" компанийн захирал/:

-Дэлхийн стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал. Ингэж байж бид экспортын хэмжээгээ нэмэгдүүлнэ. Дэлхийн стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд технологийн шинэчлэл, чадварлаг инженер техникийн ажилчид хэрэгтэй.

Бидний шийдэх гэж хугацаа алдаад байдаг энэ асуудлыг төрийн бодлогоор дэмжиж байгаад их баяртай байна. Төр нэгдсэн бодлогоор дэмжиж байхад үйлдвэрлэгчид бидний хийх ажил үлдлээ гэж ойлгож байгаа. Мөн чадварлаг инженер техникийн ажилчдыг бэлтгэхэд Яам бодлогоор дэмжих хэрэгтэй.

Экспортын дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй

П.Эрдэнэбат/"Ханбогд кашмер" ХХК-ийн гүйцэтгэх захирал/:



-Манай компани бүтээгдэхүүнээ 100 хувь экспортод гаргадаг бөгөөд

жилдээ 60 орчим сая ам.долларын борлуулалт хийж байна. Төр бодлогоор үйлдвэрлэгчдээ дэмжиж байна, энэ нь бидэнд мэдэгдэхүйц нөлөөлж байгааг хэлмээр байна.

Харин үйлдвэрлэгчидтэй хамгийн ойр ажилладаг төрийн хяналтын байгууллагууд болох ГЕГ, МХЕГ-тай уялдаа, холбоотой ажиллах хэрэгтэй. Үйлдвэрлэлийг дэмжих хуультай боллоо, төрийн бодлого тодорхой болчихлоо. Үйлдвэрлэгч бидэнд итгэл, үнэмшил

байна. Сайн ажиллах урам, зориг өгч байгаа.

Гэхдээ экспортыг нэмэгдүүлэхийн тулд дотоодын экспортын дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй. Яам байгуулснаас хойш хийж байгаа ажлуудад үйлдвэрлэгчид сэтгэл хангалуун байгаа. Гагцхүү төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжраад, шийдвэрүүд хэрэгжээд явбал бид үйлдвэрлэлээ явуулаад, экспортоо нэмэгдүүлж чадна. ■

ИНФОГРАФИК

ТӨРӨӨС
АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО"-ЫН
ТАНИЛЦУУЛГА

ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 8 ЗОРИЛТ

- 1 Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх
- 2 Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон " Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал " -ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах
- 3 Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх
- 4 Аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих
- 5 Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих
- 6 Бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх
- 7 Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, үр чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 8 Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг бүрдүүлж, экспортыг төрөлжүүлэх


БОДЛОГЫН ЗОРИЛГО НЬ

Аж үйлдвэрийн салбарыг дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино

БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ 2014 ОНД ДНБ-НИЙ



2030 ОНД БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД ЭЗЛЭХ ХУВЬ 21.2% ДАХИН НЭМЭГДЭНЭ



АЖ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ



ХҮРЭХ ҮР ДҮН

Бодлогыг хэрэгжүүлснээр боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин **2014** оны түвшнээс **2** дахин нэмэгдэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дотоодын хэрэгцээгээ хангаж, дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвартай **эцсийн бүтээгдэхүүн экспортологч орон болно.** Түүнчлэн судалгаа хөгжлийн боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулж, **үйлдвэрлэл, технологийн парк, үйлдвэрийн кластер, логикийн сүлжээг** хөгжүүлнэ

Худалдааг хуульчлахын учир

Г.Баатар



Дэлгүүрийн лангуун дээр давснаас өөр зүйл байдаггүй байсан үеэс хойш 25 жил өнгөрчээ. Гар, нүүрийн арчуур, хүүхдийн шар суултуур төдийхнөөс өөр бараагүй байсан Улсын их дэлгүүр өнөөдөр түмэн бараа, бүтээгдэхүүнээр дүүрсэн байна. Энэ нь Монгол Улсын худалдааны салбар хөгжлийн замаа туулж буйн нэгэн илрэл юм.

Шинэ нийгмийн шилжилтийн үед соёлжиж яваа монголчууд картын бараанд дараалдаг байсан нь тухайн үед барааны хомсдол хэр их нүүрлэснийг харуулж байгаа юм. Тэр үед зах зээлээ бараагаар хангах, хомсдолоос гарахын тулд жижиг худалдаачдаа дэмжих бодлогыг төрөөс эрчимтэй явуулж байжээ. Ийнхүү Монголын худалдааны салбар хөгжлийн замыг туулсаар өдгөө Монгол Улсын ДНБ-ий 60 гаруй хувийг эзэлдэг болоод байна.

Гэвч өнгөрсөн хугацаанд энэ салбарт хууль эрх зүйн зохицуулалт орхигдсон бөгөөд худалдааны хуулийг өнөөдөр заавал батлах ёстойг мэргэжилтнүүд анхааруулж байна. Худалдааны салбар үйлдвэрлэлийн салбараа дэмждэг. Гэхдээ иргэд үйлдвэрлэл эрхлэхээс илүүтэй худалдаа руу “хошуурч” байна. “Хүмүүст үйлдвэрлэл эрхэлж зовж байснаас мухлаг нээгээд талхны мөнгөө олоод суух боломжийг худалдаа олгодог бололтой. Манай худалдаачид хэрэглэгчиддээ үйлчлэх биш аль болох тэднээс их ашиг унагах, нэг удаагийн үйлдлээр л баяжих сонирхолд хөтлөгдсөн байгаа юм” хэмээн Монгол Улсын 17 дахь

Ерөнхий сайд Д.Бямбасүрэн ярьсан.

Их хотын гудамжинд сүндэрлэсэн өндөр шилэн барилгуудын дийлэнх нь худалдааны төвүүд. Гэвч эдгээр шилэн барилгын дотор “гунгалаг” худалдаа, ёс зүйн талаарх ойлголт алга. Өнөөдөр Монголын худалдаачид импортлосон бараагаа худалдан авсан үнээсээ хэд дахин өндөр үнээр борлуулж байгаа нь үнэн. Үнийн хэт хөөрөгдөл, бизнесийн харилцааны ёс зүй, хүнсний аюулгүй байдал, стандарт, чанар гэдэг ойлголтыг бид умартаж. Монгол Улс худалдааг зохицуулах бодлоготой болох хэрэгтэйг дээрхээс харж болох. Үгүйлэгдэж байсан хуулийн зохицуулалтыг хийхээр энэ намрын УИХ-ын чуулганаар Худалдааны тухай болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэх гэж байна. Манай улсын хувьд Худалдааны хууль батлах гэж буй нь анхны тохиодол. Худалдааны хуулиар ямар ч зохицуулалтгүй байгаа дотоод худалдааг бүрэн цэгцэлж, үндэсний үйлдвэрлэгчид, дотоодын зах зээлийг хамгаалах юм. Мөн үндэсний стандарттай болж дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломж бүрдэнэ. Товчхондоо, салбарын яамны зүгээс худалдааны бодлогоор үйлдвэрлэлийг дэмжихийг зорьж байгаа юм. Уг хуулийг баталснаар ямар ч хяналтгүй болсон хүнсний аюулгүй байдалд хяналт хариуцлага ирэхээс гадна эрдэс баялгийн худалдаа ил тод, хариуцлагатай, хяналттай болох аж.

Д.Бямбасүрэн “Монголын худалдаа-

чид авч ирсэн бараанаасаа зуу, хоёр зуун хувийн ашиг унагахгүй бол сэтгэл нь ханахгүй байх шиг байгаа юм. Ийм нөхцөлд харилцааны зохицуулалт хэрэгтэй. Жишээлбэл, хоёр жилийн өмнө ОХУ Худалдааны хууль гаргаж, бараа худалдаалж буй хүмүүс худалдаж авсан үнэ дээрээ 30 хувиас илүү үнэ нэмэхийг хориглосон. Өөрөөр хэлбэл, хэт өндөр ашиг хөөх тухай асуудал байхгүй болсон” гэв. Харин манайд асуудал эсрэгээгээ. Үүнийг уг хууль таслан зогсоох учиртай. Соёлжсон эдийн засагтай оронд бизнес эрхлэгчид “Би бусдын төлөө үйлчилж, бусдын хэрэгцээг хэр хангана тэр хэмжээгээр бизнесээ тэтгэж байна” гэж ойлгодог. Тухайлбал, Баруун Европын орнуудад лангуун дээр хүнсний ногоог цэвэрлээд тавьдаг. Манайд бол шороотой чигээр нь тэр тусмаа, зарим нь бараг шороонд хутгаж байгаад гаргадаг тухай Д.Бямбасүрэн гуай ярьсан. Олон улсын жишгийн дагуу манай худалдааны салбарт соёл мөн дутагдаж байна.

Үндэсний үйлдвэрлэгчид худалдааны энэхүү шинэ хуулийг бас нэг боломж гэж харах хэрэгтэй. Учир нь энэ хуулиар дотоодын зах зээлийг хамгаалах, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих тодорхой заалтууд орж байгаа аж. Манайхан импортын бараа хэт их орж ирж, дотоодын үйлдвэрүүдийг “дарж” байна гэдэг ч энэ талаарх хууль эрхзүйн зохицуулалт байхгүй байгааг МУИС-ийн “Худалдаа” хөтөлбөрийн ахлагч Н.Отгонсайхан хэлсэн. Тэгвэл салбарын яам хийгээд Засгийн газрын



ЭМ ЭМ ЖИ КАПИТАЛ ХХК

WWW.MMJCAPITAL.MN

ЭМ ЭМ ЖИ КАПИТАЛ ХХК НЬ 2001 ОНД БАЙГУУЛАГДАЖ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ГАДААД ДОТООД ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН. ТУС КОМПАНИ НЬ 2010 ОНД СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД НООС НООЛУУР БЭЛТГЭХ, УГААХ, САМНАХ ЗОРИЛГООР 6500 МКВ ОРЧИН ҮЕИЙН СТАНДАРТАД НИЙЦСЭН АГУУЛАХУУД, ХОНОГТ 15 ТОНН НООС НООЛУУР УГААХ ХОС ШУГАМТАЙ УГААХ ҮЙЛДВЭР, 2015 ОНД НООС НООЛУУР САМНАХ ҮЙЛДВЭРҮҮДИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАН АМЖИЛТТАЙ АЖИЛЛАЖ БАЙНА. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АЖИЛЛАХ ХҮЧ, МАТЕРИАЛЛАГ БААЗЫН ХУВЬД БҮРЭН БЭХЖИЖ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЧАНАРЫН ӨНДӨР ТҮВШИНД ҮЙЛДВЭРЛЭЖ, ҮЙЛЧИЛЖ ХАМТРАН АЖИЛЛАГСАД ХЭРЭГЛЭГЧДИЙНХЭЭ ТАЛАРХАЛЫГ ХҮЛЭЭН АЖИЛЛАЖ БАЙНА.



ТАНШЛЫЦАЛГА

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, СУХБААТАР ДҮҮРЭГ 2-Р ХОРОО, НАРНЫ ЗАМ ЖИГУУР ГРАНД ОФФИС ЦЕНТР
"Б" КОРПУС, 7-Р ДАВХАР УТАС: +976-11-320585, 320686, ФАКС: +976-11-320242 И-МЭЙЛ: INFO@MMJCAPITAL.MN

Дэлхийн эдийн засгийн замын зураг
бүтэн жилийн турш тантай хамт

The World in 2016

The Economist сэтгүүлийн "THE WORLD IN 2016" жилийн дугаарыг Монгол дахь албан ёсны тусгай зөвшөөрөл эзэмшигч "**Mongolian Economy**" сэтгүүл монгол хэлээр эрхлэн гаргах гэж байна.

2016.01 сард танд хүрнэ

зүгээс уг асуудлыг анхаарч 10 гаруй нэр төрлийн импортын барааны гаалийн албан татварын хэмжээг 6.5-20 хүртэл хувь байхаар нэмж тогтоосон. Энэ нь дотоод зах зээлээ хамгаалж буй нэг хэлбэр. Бид хүнсний ногоог урд хөршөөс худалдан авахгүйгээр хэрэглээгээ дотоодоосоо хангах бүрэн боломж бий. Хүнсний ногооны импортод хаалт хийхийн тулд тарифын бус зохицуулалтаар буюу гаднаас орж буй бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ, мөнгөн дүнд хязгаар тогтоох, хяналт тавих зэрэг аргаар хянах боломжтой аж.

Нөгөө талаас, үндэсний үйлдвэрлэгчдийн хүнсний ногоо тэргүүтэй бараа, бүтээгдэхүүнийг худалдааны сүлжээ дэлгүүрүүдээр борлуулж болох юм. Энэ аргыг олон улсад хэрэглэдэг бөгөөд тухайлбал, Герман улс ийм жишгээр дотоодын үйлдвэрлэлээ дэмжиж яваа. Тэгэхээр энэ нь үйлдвэрлэгчдийг бараагаа борлуулах, хэрэглэгчдийг найдвартай бүтээгдэхүүнээр хангах нэг сүлжээ болдог байна. Худалдааны тухай хуульд худалдааны сүлжээний асуудлыг ч мөн хуульчилж өгчээ.

Энэ хууль хэрэгжиж эхэлснээр Монголд үйлдвэрлэж буй бүх бараа, бүтээгдэхүүн зураасан кодтой болно. Монголын үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ зураасан кодтой болгосноор Европ, хамгийн сүүлд Япон улстай хийсэн эдийн засгийн түншлэлийн гэрээний үр дүнд тухайн улсуудад бараа, бүтээгдэхүүн үйлчилгээг экспортлох боломжтой болно гэсэн үг. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга М.Оюунчимэг “Европын холбооноос Монголын экспортод гаргаж байгаа 7200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнд хөнгөлөлт олгосон. Тэгэхээр үүнийг нөгөө л гарал үүслийн гэрчилгээгээр нотолно. Тухайн барааг Монголд үйлдвэрлэсэн гэдгийг нотлосноор бид энэ хөнгөлөлтийг эдлэх боломжтой” гэлээ.

Хэрэглэгчид “Яг энэ алимны шүүсийг Солонгост уухаар их өөр байдаг ш дээ. Монголд уухаар амт нь их өөр юм” гэж ярьдаг. Учир нь худалдааны тээвэрлэлт явагдаж байгаа нөхцөлд бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн горимыг

бид баримталж чадахгүй байгаагийн нэг жишээ. Манай улс даршилсан өргөст хэмхийг Орос, Польш, Вьетнам зэрэг улсаас импортолдог. Гэтэл уг бүтээгдэхүүнийг худалдаачид тухайн нийлүүлэгчид захиалга өгснөөс хойш сар гаруй хугацааны дараа лангуун дээрээ тавьдаг байна. Уг бүтээгдэхүүнийг хавар, намрын улирал маш их хэмжээгээр оруулж ирдэг аж. “Монгол шиг давсалсан өргөст хэмх 7000 км-ын алсаас худалдаж авдаг улс ер нь байдаг юм болов уу. Өргөст хэмхийн 95 хувь нь ус. Тэгэхээр усан дээр ус нэмээд шилэн саванд савлаад ирэхээр хүнд хэрэгтэй нь хэдэн хувьд нь ирэх вэ дээ” хэмээн Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн ярьсан.

Худалдааны тухай хууль нь дэлгүүрийн лангуун дээрх бараа бүтээгдэхүүн гэхээсээ илүүтэй Монголын баялаг зэсийн баяжмал, нүүрсийг олон улсын зах зээл дээр хэрхэн борлуулж, энэ баялаг нь хатуу валют хэлбэрээр эх орондоо хэрхэн орж ирж байгаа зэрэг өргөн хүрээний асуудлыг зохицуулахаар хуулийн төсөлд тусгаснаар экспорт хийж буй компаниуд төлбөр, тооцоогоо Монголын банкуудаар дамжуулж хийх гэнэ. Ингэснээр бид албан бусаар бизнес явуулах, татвараас нуугдах зэрэг байдлыг алга болгох боломжтой. Монголын баялгийн гадагшилжбуй тэр урсгалыг ч мөн хянах боломж бүрдэх нь. Түүнчлэн Худалдаа бэлтгэлийн сайд асан Б.Шаравсамбуу “Улсын гадаад худалдааг ганзгын наймаанаас илүүгүй ойлгодог удирдлагууд улстөрчдийн түвшинд бэлтгэгдсэн байна. Үүнээс болж Монгол Улсын гадаад худалдаа нэг цонхны зохицуулалтгүй болсон” гэж ярьсныг энд тэмдэглэе.

Өнөөдрийн Монгол Улсын Засгийн газар нүүрс, зэс тэргүүтэй уул уурхайн бүтээгдэхүүний худалдааны асуудлыг худалдааны түвшинд авч хэлэлцэж байгаад олон хүн эргэлзэж байна. Үүнийг хуульчилж, хуулийн дагуу шийддэг болох учиртай. Худалдааны тухай хууль нь монгол хүний эрүүл мэнд хийгээд улсын эдийн засаг, үндэсний аюулгүй байдалтай холбоотой аж. ■



Компанийн танилцуулга:

Номин сүлжээ дэлгүүр нь өөрийн 3 их дэлгүүр, 9 супермаркет, 7 хайпермаркет, 10 бөөний худалдааны төвд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйлчлүүлэгчиддээ өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү ойртуулах үүднээс Дархан, Орхон, Дорнод, Ховд, Сүхбаатар, Өмнөговь, Дорноговь зэрэг аймгуудад өөрийн салбар худалдааны төвүүдээ нээн ажиллуулж байна. Түүнчлэн 21 аймагт даатгалын салбарыг ажиллуулж ард иргэддээ даатгалын цогц үйлчилгээг үзүүлэхээс гадна явуулын худалдаагаар дамжуулан бүх аймаг, хот, сумдуудад хүрч үйлчилж байна.

Бидний үйлчилгээний гол зорилго нь хэрэглэгчиддээ чанарын баталгаатай, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний болон ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг үйлчилгээний дээд зэргийн сэтгэл ханамжийн хамтаар хямд үнээр түргэн шуурхай хүргэх явдал юм.

Номин Юнайтед Их дэлгүүр

Номин Юнайтед их дэлгүүр нь Хан уул дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд 2014 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Хэрэгцээт бүхий л үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн бөгөөд халуун дотно, тав тухтай орчинг бүрдүүлж чадсан нь тус дэлгүүрийн онцлог юм. Хүнс болон гэр ахуй, цахилгаан бараа, тавилгын хэрэгцээгээ бүрэн хангахын зэрэгцээ Эрдэнэт хивсийн нэрийн дэлгүүр, Олон Үндэстний хоол, Empire фитнес клуб, Номин Юнион, Номин Даатгал, SB үсчин, гоо сайхан, Голомт банк, Хаан банк, Төрийн банк, Нотариатын үйлчилгээ зэргийг нэг дороос авах боломжтой.





“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХК

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
МЕТАЛЛУРГИЙН САЛБАРЫН
ҮНДЭСНИЙ ТЭРГҮҮЛЭГЧ
КОМПАНИ



ЭХ ОРНЫ ТӨМРИЙН ХҮДРЭЭС НЭМҮҮ ӨРТӨГ
ШИНГЭСЭН ЭЦСИЙН ГАН БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛДВЭРЛЭЖ ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ
БҮРЭН ХАНГАХ
“УУЛ УУРХАЙ, МЕТАЛЛУРГИЙН ЦОГЦОЛБОР”
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ



ДЭЛХИЙН ЖИШИГТ
ХҮРСЭН ЧАНАРТАЙ
БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛДВЭРЛЭГЧ

Үйлдвэрийн район,
Дархан сум, Дархан-Уул аймаг
Монгол Улс

Утас: +976 – 75771101
Факс: +976 – 75771101
И-мэйл: info@dmp.mn
Вэб: www.dmp.mn

MONGOLIAN
ECONOMY

IV-Р УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ



УТАС: 70115476, 94092904